

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН  
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 06-НЫ  
ӨДӨР/ЛХАГВА ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

| №  | Баримтын агуулга  | Хуудасны дугаар |
|----|---|-----------------|
| 1. | Хуралдааны товч тэмдэглэл:  | 1-3             |
| 2. | Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:<br><br>1. Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 4-71            |

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы  
04 дүгээр сарын 06-ны өдөр /Лхагва гараг-/ийн нэгдсэн  
хуралдааны төвч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.*

**Чөлөөтэй:** А.Адъяасурэн, Г.Амартувшин, Ж.Батсуурь, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг, Б.Чойжилсүрэн;

**Эмнэлгийн чөлөөтэй:** Х.Баделхан, Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар;

**Тасалсан:** Ц.Анандбазар, Т.Аубакир, Х.Ганхуяг, Ж.Эрдэнэбат;

**Хоцорсон:** Ж.Батжаргал- 07 минут, Д.Бат-Эрдэнэ- 08 минут, Б.Бейсен-06 минут, Т.Доржханд- 24 минут, Б.Дэлгэрсайхан- 1 цаг 05 минут, Л.Мөнхбаатар- 05 минут, Ж.Мөнхбат- 1 цаг 05 минут, Н.Наранбаатар- 06 минут, Х.Нямбаатар-15 минут, Б.Саранчимэг- 07 минут, Ж.Сүхбаатар- 2 цаг 03 минут, Ц.Сэргэлэн- 3 цаг 17 минут, Ц.Туваан- 33 минут, Г.Тэмүүлэн- 3 цаг 16 минут, Н.Учрал- 1 цаг 27 минут, Б.Энх-Амгалан- 07 минут.

**Нэг.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндөн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн,

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Т.Энхтүвшин, Ж.Чинбүрэн, Ш.Адьшаа, Б.Бейсен, Т.Аюурсайхан, Ж.Ганбаатар, О.Цогтгэрэл, Н.Ганибал, Ч.Хүрэлбаатар, Ж.Батжаргал, Г.Ганболд, Ц.Даваасүрэн, Б.Энх-Амгалан, Д.Ганбат, Х.Булгантуяа, Б.Саранчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Баттөмөр, Д.Сарангэрэл, Б.Пүрэвдорж, Ц.Туваан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Б.Бейсен, Ж.Мөнхбат, Д.Ганбат нар үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 14

Бүгд: 57

75.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн Хурх тосгоны төрийн албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа хариуцан ажиллав.

**Хуралдаан 4 цаг 11 минут үргэлжилж, 76 гишүүнээс 61 гишүүн хүрэлцэн ирж, 80.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 21 минутад өндөрлөв.**

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
**ЕРӨНХИЙ НАРИЙН**  
**БИЧГИЙН ДАРГА**

**Л.ӨЛЗИЙСАЙХАН**

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН  
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 06-НЫ  
ӨДӨР/ЛХАГВА ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ирц танилцуулъя.

Гадаад, дотоодод томилолттой, эмнэлгийн чөлөөтэй 11 гишүүн байна. Ирвэл зохих 65 гишүүнээс 40 гишүүн ирсэн, ирц бүрдсэн байна аа. 52,6 хувьтай байна.

Ингээд Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хоёрт, Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орьё.

**Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлж байна аа.

Дэлхий даяар 6 сая гаруй хүний амь насыг авч одсон хүн төрөлхтний амьдралын хэмнэлийг танигдахын аргагүй өөрчилсөн цар тахлын нянг нэн амаргүй цаг үе халдварын дараалсан 4 давлагааг та бид хамтдаа даван туулахад Улсын Их Хурлын баталсан цар тахлын эсрэг хууль эрх зүйн орчин түүхэн үүрэг гүйцэтгэсэн гэдгийг Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд би өнөөдөр батлан хэлэхийг хүсэж байна аа.

Вакцинжуулалтын ажлыг төлөвлөгөөт хугацаанаас 8 сарын өмнө татан төвлөрүүлж, нийт иргэдээ шуурхай хамруулах, эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай эм тариа, амьсгалын аппарат зэрэг тоног төхөөрөмжийг цаг алдалгүй худалдан авах боломжийг бүрдүүлж, болзошгүй эрсдэлээс 40 гаруй мяняган хүний амь насыг авран хамгаалж, эдийн засгаа үе шаттай нээж, 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улс шар түвшинд шилжиж, цар тахлын бүхий л хязгаарлалтуудыг цуцалсан дэлхийн болон Ази тивийн улс орнуудын анхдагч улсуудын нэг болсонд Монгол Улсын Их Хуралд Засгийн газраа төлөөлж, гүн талархал илэрхийлье ээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ. Харамсалтай нь давааны цаана даваа гэж Монголчууд бид ярьдагчлан цар тахлын шар түвшинд шилжсэнээс хойш 10 хоногийн дараа манай хөрш Оросын холбооны улс болон Украян улсын хооронд хямралт нөхцөл байдал үүсэж, дэлхийн улс төр, геополитик, эдийн засагт нэн хурцадмал нөхцөл байдалд шилжлээ. Энэхүү нөхцөл байдал, эдийн засгийн харилцан авч буй хориг арга хэмжээнүүдээс улбаалж дэлхий даяар зарим олон улсын судлаачдын томьёолж байгаагаар шинэ хүйтэн дайны уур амьсгал бүрдэж, олон улсад, тэр дундаа хөгжиж буй далайд гарцгүй улс орнуудад томоохон сорилтыг учрууллаа.

Дэлхий дахинд түлш, шатахуун, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хомстол үүсэж, үнийн өсөлт огцом нэмэгдэж байна аа. Тухайлбал он гарсаар газрын тосны үнэ дунджаар 50 хүртэл хувь, улаан буудайн үнэ 40 хүртэл хувь, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарим хүнсний нэр, төрлийн бүтээгдэхүүнд хомстол үүссэн нь цаашлаад дэлхий даяар 8-13 сая орчим хүнд өлсгөлөнд нэрвэгдэх бодитой аюул нүүрлэснийг мэдэгдлээ.

Далайд гарцгүй эдийн засаг нь зөвхөн уул уурхайгаас, улсын төсөв нь нүүрс зэсээс, шатахуун, эрчим хүч, 1 улсаас импорт нь дан ганц 1 боомтоос хамааралтай манай улсын хувьд энэ хүндхэн сорилт байна гэдэг нь ойлгомжтой юм аа. Тиймээс ч бид эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг хангах Шинэ сэргэлтийн бодлогоо төр, иргэн, аж ахуйн нэгж, бүх нийтээрээ идэвхжүүлэн хэрэгжүүлэх түүхэн үүрэг та бидэнд ногдож байгаа юм аа. Ер бусын хямралын цаг үе биднээс ер бусын шийдлийг шаардаж байна. Шүүмжлэлд гомдоллоод улс төржөөд энэ хямралыг даван туулж бид чадахгүй нь ойлгомжтой. Энэ хүнд үед Монголчууд бид эвлэлдэн нэгдэж, энэхүү олон улсын хямралт байдлаас аль болох үндэсний аюулгүй байдалд хохирол багатайгаар даван туулах томоохон сорилт та бидний өмнө ирлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн дөрөв дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн энэхүү хуулийг яаралтай горимоор хэлэлцүүлж байна аа.

Энэ хууль батлагдсанаар:

Нэгдүгээрт, Засгийн газраас мах, гурил, газрын тос болон бусад нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход шаардагдах хүүгийн татаасыг төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх, үнэт цаас баталгаа гаргах, газрын тосны бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварыг 5 хүртэлх хувь зохицуулалт хийх, мах, гурил, газрын тосны бүтээгдэхүүний тогтвортой байдлыг

хангах зорилгоор тухайн чиглэлийн аж ахуй нэгжүүдэд эргэлтийн хөрөнгө, урьдчилгаа төлбөрт шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг олгох,

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газраас Монголбанкны валютын нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бий болгох, мөнгө болон сангийн бодлогыг нарийвчлан уялдуулж, хямралт нөхцөл байдлын үед нягт хамтран ажиллах болон зарим нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний импортын татвартай холбоотой зохицуулалтыг Засгийн газар зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх,

Гуравдугаарт, Гадаад валютын улсын нөөц нэмэгдүүлэхийн тулд Монголбанкнаас алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгож, Лондонгийн металлын биржийн үнэ дээр 5 хувийн нэмэгдэлтэйгээр гадаад, дотоодын зах зээлээс алт худалдан авах олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтан тушаах, үүргээ хэрэгжүүлэх зэрэг Засгийн газар цаг алдалгүй хямралын мөчлөгийг сөрж, шуурхай ажиллах боломжтой эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна.

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Их Хурлын эрхэм гишүүд та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Одоо төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, Олон улсын хямралт байдлаас үүдэлтэй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч ард иргэдийн амьдралд хамгийн том нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүн, мах, гурилын хангамж, нийлүүлэлтийн хомсдол үүсэх, үнэ өсөхөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг онцгой журмаар зохицуулах, шийдвэрлэх зайлшгүй шаардлага тулгарч, энэхүү гадаад үнийн огцом өсөлт удаан үргэлжлэх төлөвтэй байгааг харгалзан гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ, хангамжид анхаарсан бодлого барих зорилгоор уг хуулийн төслийг боловсруулан өргөн барьжээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ч.Хүрэлбаатар, Х.Болорчулуун, Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, Н.Ганибал, Д.Бат-Эрдэнэ, Т.Баттөмөр, Ш.Адьшаа нар асуулт асууж, төсөл санаачлагчдаас хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд үнэ тогтвортжуулах хөтөлбөрийг дахин оруулж ирж байгаад шүүмжлэлдээ хандан экспортын орох орлогыг нээх талаар, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг экспортын бодлогыг дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Болорчулуун зөвхөн дотоодын газар, тариаланчид болон гурилын үйлдвэрлэлээ илүү их дэмжих чиглэлээр ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ оруулж ирсэн хуулийн төслийн зүйл заалтыг тодорхой болгох, дотоодын үйлдвэрлэлээ нэн яаралтай дэмжих, хөгжүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэх тал дээр анхаарах, үр тарианы тариалалт, тариалангийн бус

нутгуудад бүрэн дэмжлэг үзүүлэх гэсэн асуудлыг оруулж ирэх, дотоодын аж ахуйн нэгжүүдээ дэмжих бодлого улам сайжруулж ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа зах зээлийн зарчим, эдийн засгийн хөгжлийн агуулгатай зохицсон хууль оруулж ирэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж мөн мах бэлтгэх үндэсний хөтөлбөрүүдийг дэмжих, төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл, уул уурхайн бус экспортыг дэмжих санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлье гэсэн энэ заалтаар үндэсний үйлдвэрлэлийг зах зээлээс шахах тогтолцоо бий болж байгаа тул төрийн мөнгөний бодлого, махны үнэ тогтворжуулах бодлого хоёрыг тусад нь хэрэгжүүлж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үүсэж байгаа нөхцөл байдал гэнэтийн биш ингэж хүндрэхээс сэргийлэх хугацаа байсан, маш оройтсон арга хэмжээ болж байна гэсэн сануулгыг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар мөнгө хэвлэснээр үнэ тогтворжихгүй, мөнгө хэвлэхийг хуулиар зохицуулдгийг анхаарах хэрэгтэй. Импортын гаалийн татварын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газар авах саналыг дэмжихгүй, өмнө нь үнэ тогтворжуулах хөтөлбөрийг шүүмжилж байсан бөгөөд энэ хөтөлбөрт төгрөгийн ханш уналтыг улам хөөрөгдөх, валютын ханш хомсдох эрсдэл үүсэх нөхцөл байдлыг илүү дэвэргэж байсан тул ийм үнэ тогтворжуулах зорилго бүхий хуулийн төслийг дэмжихгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн болно оо.

Олон улсын хямралт байдлын улмаас үүсэж буй гол нэр, төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72,7 хувиар дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Олон улсын хямралт байдлаас үүсэж буй гол нэр, төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

### Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Гэлэнгийн Ёndon, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Эрчим хүчний сайд Нансалын Тавинбэх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Загджавын Мэндсайхан, Эрүүл мэндийн сайд Сээрэжавын Энхболд, Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир алга байна. Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга. Баярдаваа байгаа юм уу. Ажлын хэсэгт нэрийг нь л өгчихсөн юм байна аа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийг бүртгэе.

Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууяа.

**Б.Бат-Эрдэнэ:** Та бүхнийхээ өнөөдрийн амгаланг айлтгая аа. Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Үнэхээр энэ дэлхий нийтийг хамарсан цар тахал, үүний дараа энэ зэвсэгт мөргөлдөөн, дайн, энэ хямралт байдалтай холбоотойгоор дэлхий нийтээрээ ер нь амаргүй ийм нөхцөл байдалтай байх шиг байна аа. Ялангуяа нефть бүтээгдэхүүний үнэ бол ер нь 24 он хүртэл бол нэлээн

**Г.Занданшатар:** Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнд дахиж өгье.

**Б.Бат-Эрдэнэ:** Одоо энэ олон улсын зах зээлийн биржийн байдлыг харах юм болбол, ер нь 95-100 долларын нэг баррель өсөлттэй, тэгээд 24 он руу болбол эргэж жаахан буух 50-60 доллар руу орохоор ийм төлөв байдал харагдаад байна л даа. Тэгээд ийм үед бол энэ нефть бүтээгдэхүүн, гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг сэргийлэх, тогтвортой байлгах, хангамжийг хэвийн байлгах ийм хуулийн төслийг яаралтай горимоор оруулж ирж байгааг болбол дэмжиж байгаа.

Надад нэг цөөхөн хэдэн асуулт байна аа.

1 дүгээрт, энэ нефть бүтээгдэхүүн гаднаас импортолно гэдэг бол валюттай холбоотой асуудал. Тэгээд энэ валютаар худалдаа хийнэ. Энэ нефть импортлогч компаниудад, аж ахуйн нэгжүүдэд төгрөгийн зээл олгоод тэгээд энэ мөн ялгаа байхгүй валютаар авна. Тэгэхээр энэ дээр ер нь тооцоо судалгаа хийж үзсэн зүйл байна уу? Гадаад руу валютын урсгал нэмэгдэх ийм нөхцөл байдал бол нэмэгдэнэ. Үүнийг одоо хэрхэн тооцож байгаа юм бэ? Үүнтэй уялдаатайгаар Оросын холбооны улс бол найрсаг бус харилцаатай ийм улс орнуудтай Оросын холбооны улсаас гаргаж байгаа нефть бүтээгдэхүүн, байгалийн хийг бол зөвхөн рублиэр хийнэ ээ гээд ингээд зарлаачихлаа. Энэ хүрээнд манай Засгийн газар Оросын холбооны улстай рублийн своп хэлцэл хийх, жишээлбэл ийм арга замыг хайж үзэж байгаа ийм зүйл байна уу гэж,

2 дугаар нэг асуух юм болбол өмнө 12-16 онд Ардчилсан нам, шударга ёс эсвэл засгийн эрх барьж байсан. Энэ хугацаандаа бол үнэ тогтвржуулах хөтөлбөр гаргачихсан. Өнөөдрийн яригдаж байгаа Хөгжлийн банкнаас олгогдсон 3,2 их наяд төгрөг, 1,8 нь чанаргүй болчкоод байгаа үүнээс чинь хамаагүй их хэмжээний мөнгийг 4 их наяд гаруй төгрөгийг одоо үнэ тогтвржуулах хөтөлбөр нэрээр Монголбанкнаас мөнгө хэлээд ингээд тараачихсан, мөн л одоо аж ахуйн нэгжүүд рүү олгосон. Энэ маань одоо ямар хор үр дагавар гарсан бэ, үр дүн гарсан юм уу, эсвэл одоо хортой муу үр дагавар гарсан юм уу? Энэ дээрээ тооцож судалж үзэж байгаа, энэ муу үр дагаврыг нь сэргийлэх чиглэлээр одоо энэ шинэ оруулж ирж байгаа хуульд ямар зүйлүүд байгаа юм бэ гэдэг нэг ийм дараагийн асуулт.

Нөгөө талынх нь юм болбол энэ аж ахуйн нэгжүүдэд боломж олгоно оо, мах, гурил үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгч ийм аж ахуйн нэгжүүдэд л одоо зээл олгоно, хөнгөлөлттэй дэмжлэг үзүүлнэ гээд энэ хуулийн зохицуулалт дээр байна.

Тэгэхээр зэрэг цаад талд нь яг үйлдвэрлэж байгаа энэ малчид руу хандсан ямар бодлого байх юм бэ? Энэ талаар одоо юу хэлэх вэ? Нэг хариулт өгөөч, баярлалаа.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ асуултад хариулна аа.

**Л.Оюун-Эрдэнэ:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариульяа. Мэдээж олон улсын ийм нөхцөл байдлыг аль аль нь бүтэн тооцож чадаагүй гэж одоо үзэж байгаа. Хоёр жил дараалан ковидоос болж амаргүй ийм цохилт өгчихсөн байсан олон улсын эдийн засаг дээр дээрээс нь одоо дэлхийн томоохон улс орнууд, хөрш улс орнууд ингээд хоорондоо ийм хямралтай, хурцадмал нөхцөл байдалд орчож байгаа учраас энэ нь өөрөө бас их тийм амаргүй нөхцөл байдлыг дагуулж байна л даа. Жишээлбэл одоогийн байдлаар 8200 гаруй ийм харилцан хоригууд тавигдаад байна. 8200 орчим. Үүнээс үүдээд одоо улаан буудай нэлээн их тийм хомсдол үүсэх нөхцөл байдал үүсэж байна. Наранцэцэгийн тос, жишээлбэл өөрөө Оросын холбооны улс, Украин улс хоёр хоёулаа одоо гол экспортлогч улс орнуудын нэг учраас энэ бүтээгдэхүүн дээр дэлхий даяар амаргүй нөхцөл байдал үүсэх ийм нөхцөл байдал үүсэж байна.

Оросын холбооны улс зөвхөн рублиэр тооцоо хийнэ гэсэн учраас энэ 4 сарын нэгж өртөг одоо манайхаар бол 1000 орчим төгрөгөөр огцом нэмэгдэх. Цаашдаа 5 сарын дундуур одооноос бид нар арга хэмжээ авахгүй бол энэ өөрөө их тийм, цаашдаа үнэ огцом өсөх ийм нөхцөл байдал бол нэгдүгээрт бий болж байна. Тийм учраас үүнийг бид нар одоо урьдчилж ийм эрх зүйн орчин бүрдүүлье, юутай ч одоо түлш шатахуунтай байх, махтай байх, гурилтай байх гэдэг энэ З зүйл рүү л одоо цаг алдалгүй оруул ясан юм бэ гэдэг л ийм зүйлийг л Засгийн газраас оруулж ирж байгаа юм.

Хэсэг ажигласан, тэгээд энэ хурцадмал нөхцөл байдал бол бас өнөө маргаашгүй шийдэгдэхгүй байх ийм одоо нөхцөл байдалд байна гэдгийг манай тусгай албад болон Гадаад хэргийн яамны гол шинжээчид бол үзэж байгаа. Энэ он дуустал бол ер нь энэ хурцадмал байдал бол хэвээр үргэлжилж болзошгүй, хурцадмал байдал намжлаа гэхэд эдийн засгийн хориг арга хэмжээнүүд өөрөө цаашдаа үргэлжлэх ийм нөхцөл байдал үүсэж байгаа учраас энэ дээр одоо нөгөө ниргэсэн хойно хашхирав гэдэг шиг асуудал болж байхаас наана нь бид нар бэлтгэл ажлаа хангаж байх нь бол илүү зүйтэй юм аа гэдэг л агуулгаар энэ асуудлыг оруулж ирж байгаа юм.

Тэгээд нарийвчилсан асуудлыг Хөдөө аж ахуйн сайд, Сангийн сайд хоёр хариулаад явчихъя.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан.

**Б.Жавхлан:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариульяа. Оросын холбооны улс ер нь гадаад төлбөр тооцоо, ялангуяа өөрийнх нь одоо гол экспортын бүтээгдэхүүн байгалийн хий шатахууныхаа төлбөрийг үндэсний валютаараа авна шүү гээд ингээд ер нь зарлачихсан байгаа. Хэрвээ манайд рубль нь байдаг бол одоо энэ шиг таатай нөхцөл байхгүй л дээ. Гэхдээ энэ байдлаас гаражын тулд ер нь бид Оросын холбооны Төв банктай сүүлийн бараг 10 гаруй жил ер нь энэ хүсэлтийг тавьж байгаа юм. Монголын төв банкнаас. Яах вэ, энэ удаагийн үүссэн нөхцөл байдалтайгаа уялдуулаад нэг шийдчих болов уу гэсэн горьдлоготой ингээд хүлээж байна. Гэрээ хэлэлцээрүүдийг хийхийг шамдуулж бид нар өдөр бүр нь л

хандаж байгаа юм. Ингээд хоёр төв банкны хооронд үндэсний мөнгөн тэмдэгтүүдээрээ солилцоо хийчих юм болбол яг энэ хүнд цаг үед бид долларын дарамтаа бас бага ч булуу хөнгөвчлөх ийм боломж байгаа. Боломж байгаа. Нааштай шийдчих болов уу гэж ингэж хүлээлттэй байна аа. Ер нь нэг жилийн хэрэгцээ шатахууны төлбөрт нэг оргил үед 1,8 тэрбум доллароор өссөн. Одоо ингээд үнэ нэмэгдээд 1,4-1,5 тэрбум доллар орчим байна. Тэгэхээр энэ он дуустал нэг тэрбум орчим доллартой тэнцэх рубль, төгрөгийн солилцоо хийчих юм болбол энэ хэмжээгээр одоо бидний валютын нөөцийн дарамт буурна аа гэсэн үг. Энэ тал дээр одоо ажиллаж байгаа.

Тэр үнэ тогтвортжуулах хөтөлбөртэй одоо зэрэгцүүлж ингэж ярих нь бол зөв өө. Одоогийн яг энэ цаг үеийн өнцөг дээрээс. Тэгээд өмнө нь гарсан одоо макро алдсан оносон зүйлүүдтэйгээ харьцуулж ярих нь бол зөв. Энэ удаагийнх бол өөр шүү. Хоёр зүйл дээр бол өөр байгаа юм. Хоёр зүйл дээр өөр.

1 дүгээрт бид Засгийн газар хууль санаачлаад маш дэлгэрэнгүй, маш ойлгомжтой хэлбэрээр юуг зохицуулах вэ. Улсын Их Хурал ямар үүрэгтэй вэ? Засгийн газар ямар үүрэгтэй вэ, Монголбанк ямар үүрэгтэй вэ, төр, хувийн хэвшлийн, ялангуяа одоо тусгай зөвшөөрөл авдаг, тусгай лицензийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагууд, импортлогч нар ямар нийгмийн хариуцлагын хүрээнд оролцох вэ гэдгийг маш тодорхой ингэж зохицуулалт хийхээр хууль тогтоох дээд байгууллагадаа өргөн бариад энд олон нийтийн өмнө ил тод байдлаар ингэж ярилцаж байгаа. Энд эцсийн шийдвэр гарна аа. Энэ бол нэг том, одоо өөр зүйл юм. Энэ юм байгаа юм.

2 дугаарт мөнгөний бодлогын орчин, төсвийн энэ 2022 оны бодлого энэ хуулийн хүрээнд бид ажиллана аа. Энэ хуулиар зохицуулалт хийгдэх зүйлүүд маань макро тэнцвэрийг алдагдуулах хэрхэвч тийм одоо зүйл хийж гаргаж болохгүй. Өнөөдрийн бид нарын гадагшаа төлж байгаа нэг доллар болгон эргээд бидэнд нэг доллар хорин центээс дээш одоо дарамт болж орж ирж байгаа. Инфляцаа ч тэр, төлбөрийн тэнцэл дээр ч тэр, гадаад валютын нөөц дээр ч тэр. Саяхан жишээ нь төв банк мөнгөний бодлогынхoo хүүг өсгөчихсөн, өөрөөр хэлбэл мөнгөний бодлогын хатуу төлөв рүү шилжсэн. Өөрөөр хэлбэл үүнээс хойш нэг төгрөгийн ч нэмэлт мөнгөний нийлүүлэлт хийхгүй ээ гэдгээ зарлачихсан. Боломжит хэмжээгээрээ зах зээлээс мөнгөө эргүүлэн татна аа гэдгээ ингээд зарлачихсан. Үүнтэй одоо төсвийн бодлого уялдуулж явна аа. Төсвийн бодлогууд уялдуулж ингэж явах ёстой. Гэхдээ бас хязгаартай. Хамаагүй хутгалдаж болохгүй. Тэр алтан зааг дээрээ хязгаараа бариад явна аа гэж байгаа юм. Ийм одоо ялгаатай юм шүү. Тэгээд мөн одоо гишууд бас асуух байх. Тэр мөнгө хэвлэнэ гэж нэг ийм асуудал яриад байдаг. Бас энэ бол ингээд улс төрийн ойлголт явдаг, аль ч тусгаар тогтоносон улс төв банктай. Төв банк нь өөрөө үндэсний мөнгөн тэмдэгтээ хэрэглэх эрхтэй, үүрэгтэй. Оросын холбооны улсын төв банк рубль хэвлэх үүрэгтэй. Америкийн нэгдсэн улсын төв банк ам. долларыг хэвлэх үүрэгтэй. Хятадын төв банк ч мөн адил. Манай төв банк ч мөн адил, гол нь хэмжээндээ л байгаа. Эдийн засгийнхаа баталгаа чадамжийнхаа хэмжээнд л үндэснийхээ мөнгөн тэмдэгтийг валютынхаа нөөцийнхөө хэмжээнд хэр баргийн одоо хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг. Ингэж одоо хэвлэж нийлүүлэх өөрөөр хэлбэл мөнгөний нийлүүлэлтийн бодлогоо явуулдаг юм байгаа юм.

Г.Занданшатар: 94. Загджавын Мэндсайхан сайд.

**3.Мэндсайхан:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариульяа аа. Тэгэхээр Засгийн газар өнгөрсөн жил гэхэд бид нар 8 сард төв суурин газрын хүн амын махны хэрэглээг тогтвортой байлгах, тогтвортой хангах, үнийг тогтвортой түвшинд барих зорилгоор 100 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг гаргасан. Энэ хүрээнд 23 аж ахуйн нэгжийн нийтдээ 12,7 мянян тонн мах одоо нөөцөлсөн байгаа. Сая 03 сарын 25-наас зах зээл дээр гарсан. Энэ бол одоо энэ хаврын 07 сарын 10 хүртэлх төв суурин газрын хүн амын хэрэглээг бол тогтвортой, хямд үнээр, чанарын шаардлага хангасан махаар одоо хангах боломжийг бүрдүүлж өгсөн. Тэгэхээр энэ 100 тэрбум төгрөгийн зээлээс 98 тэрбум төгрөг, одоо жишээлбэл энэ 23 аж ахуйн нэгжийн зээлж зах зээл рүү гаргасан байгаа. Энэ бүхэн бол одоо малчдад маань бол орлого болж очиж байгаа.

Нөгөө талдаа энэ махны үнэ маань нийт хэрэглээний үнийн сагсанд инфляциад дангаараа нэг 20-21 орчим хувиар нөлөөлдөг маш өндөр нөлөө үзүүлдэг. Ийм энэ үнийн өсөлтийг дагаад бусад бүтээгдэхүүний үнэ өсдөг өө тэгэхээр бид нар энэ махны үнээ одоо хангамж талаас нь тогтвортой байлгаяа үнийн түвшнийг тодорхой түвшинд нь өсөлтийг нь тогтвортой түвшинд барьяа аа гэдэг зорилгоор энэ хуульд махны асуудлыг тусгаж оруулж ирсэн байгаа.

Нөгөө талдаа одоо Европын улсуудад бас энэ цаг уурын тааламжгүй нөхцөл байна. Үүсээд байгаа энэ нөхцөлтэй холбоотойгоор ургац алдаж байна. Тариалалт мөн гол одоо улаан буудайны нийлүүлэгч 2 орон маань хоорондоо сөргөлдөөнт байдалтай байгаа. Энэ 2 улс маань одоо нийт улаан буудайн зах зээлийн 27 хувийг нийлүүлдэг. Өөрсдийн дотоодынхоо хэрэгцээнээс гадна. Тэгэхээр бид нарт ийм эрсдэл үүсэх нь маш тодорхой харагдаж байна аа гэдэг үүднээс бид нар дотоодын одоо улаан буудайн тариалалтаас өгсүүлээд энэ жил бүх технологийн хугацаанд явагдах үе шаттай ажлуудыг цаг хугацаа алдалгүй тариалалтын хувь хэмжээг нэмэгдүүлье ээ гэдэг хүрээнд энэ шийдвэрүүдийг оруулж ирсэн байгаа. Хуулийн төслийг.

**Г.Занданшатар:** Бадмаанямуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр би юу л асуугаад байгаа юм л даа. Одоо 100 тэрбум төгрөгийн зээл гаргаад тэгээд үүний бол 23 аж ахуйн нэгжид л одоо мах бэлтгэх зориулалттайгаар олгосон юм байна шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ яг одоо малчны хотонд малчид маань өдөр шөнөгүй цагийн хатууд зүтгэж байж тэр мах гэдэг хэрэгцээт энэ чухал бүтээгдэхүүний хүнсний гол бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа юм. Тэгээд тэр малчид руугаа хандсан ямар бодлого байх юм бэ? Яг ийм хүнд нөхцөл байдалд махны үнийг тодорхой хэмжээнд хязгаарлана аа гэдэг чинь бол малчдад л дарамт болно гэсэн үг шүү дээ. Үйлдвэрлэж гаргасан маахаа үнэ оруулж чадахгүй л гэсэн ийм л зүйл байгаа байхгүй юу. Тийм тэгэхээр энэ дээр юу бодож байгаа юм?

Нөгөө талд нь бол энэ одоо суурь хүнд гол нөлөөлөөд байгаа валютынхаа нөөц, валютынхаа ханшийг барих чиглэлд ямар тодорхой бодлого хийх юм.

**Г.Занданшатар:** 83. Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч. Валютын нэмж орж ирэх гэж байгаа урсгалуудаа сайн тодорхой хэлж өгье.

**Б.Лхагвасүрэн:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариульяа. Тэгээд энд 3 бүтээгдэхүүний нэр заагдаад явж байгаа мах, гурил, тэгээд нефть. Нефтийн

бүтээгдэхүүн нь Монгол Улс ингээд Оросын холбооны улсаас 100 хувь импортолж авдаг байгаа. Тэгэхээр бол ерөнхийдөө нефтийн импортын талаар нийт дүнгийн талаар Жавхлан сайд нэлээн дэлгэрэнгүй хэлчихсэн. Ер нь сардаа нэг 60-80 сая долларын хэмжээнд л гардаг юм байна лээ. Төлбөр тооцоо нефтийн, одоо төлбөр тооцоо нь. Тэгэхээр бол ерөнхийдөө энэ бол угаасаа 21 онд ч гэсэн ингэж явж байсан учраас бол энэ хэвийн хэмжээнд хийгдээд явна аа гэж Монголбанк харж байгаа.

Ерөнхийдөө гадаад валютын нөөцтэй холбоотойгоор өнөөдөр бол гадаад валютын улсын нөөц 3,3 тэрбум доллартой байна. Саяхан ингэж одоо ханш дээр ч юм уу энэ эрэлт нийлүүлэлт дээр нэлээн тийм савлагаатай, сандралтай байдал бий болсон. Гэхдээ бол Монголбанк арилжааны банкнуудтайгаа уулзсан экспорт хийдэг компани.

**Г.Занданшатар:** 94. Загджавын Мэндсайхан сайд юугаа махны асуудлаа гүйцээгээд хариулчихъя.

**3.Мэндсайхан:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмж хариулья. Махны экспорт өнгөрсөн жил бид нар энэ ковидын нөхцөл байдалтай холбоотой экспорт зогсихсон, мал, махны одоо борлуулалт бол энэ хэмжээгээр хумигдчихсан байгаа. Тэгэхээр энэ хуулийн үйлчлэл дээр юу вэ гэхээр зэрэг бид нар мах боловсруулах болон энэ нөөцийн мах бэлтгэх аж ахуйн нэгжүүддээ дэмжлэг болгож эргэлтийн хөрөнгийн зээл өгөх гэж байгаа юм. Энэ бол худалдаа бол шууд малчдадаа л одоо мах бэлтгэл болж, тэд нарын орлого болж очно оо гэж.

**Г.Занданшатар:** Ер нь валютын ханш бол төлбөрийн баланс тэнцлээс шалтгаална. Одоо бол валютын орох урсгал, Оюу толгойгоос энэ 4 сард 450 сая доллар, Таван толгойгоос 350 сая долларын оптекийн гэрээний мөнгө, бусад эх үүсвэрүүддээс үндсэндээ тэрбум доллар гаран орох урсгал байгаа учраас валютын тэнцлийн үнэ, валютын ханш бол хиймлээр өсгөх ямар ч үндэслэл байхгүй байгаа юм. Энэ дээр бол Монголбанк болон Засгийн газар, Сангийн яам онцгой анхаарч ажиллаж байгаа. Рублийн ханш ч гэсэн хойд талд тогтвржиж байгаа учраас энэ бол бас эерэг өөрчлөлтүүд бий болох хүлээлттэй байна аа.

Одоо ингээд Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууна аа.

**С.Бямбацогт:** Ерөнхийдөө нөхцөл байдал бол амаргүй байгаа талаар сүүлийн үед нэлээн яригдаж байгаа. Гэхдээ ард иргэддээ бас зөв ойлгуулах нь зөв байх аа. Өнөөдөр ч гэнэт тийм болчихсон юм биш. Сүүлийн хоёр, гурван жилийн ялангуяа сүүлийн үед одоо Оросын холбооны улс, Украины дайнтай холбоотойгоор улам хүндрэлтэй байдалд болж байгаа юм. Тэгээд Монгол Улс хоёрхон хөрштэй. Энэ хоёр хөршөөрөө дамжуулж, хоёр хөрштэйгөө худалдаа эдийн засгийн харилцаа, бараа бүтээгдэхүүнээ экспортолж, импортолж хэрэгцээгээ хангаж амьдардаг. Сүүлийн хоёр, гурван жил одоо Хятад улс маань ковидоос болоод үндсэндээ одоо өөрөө өөрийгөө тусгаарлаад, үүнээс болж импортын saatалд гарч бараа бүтээгдэхүүний өсөж байгаа.

Нөгөө талдаа одоо гаргадаг зэсийн баяжмал, төмрийн хүдэр, нүүрс гээд экспортолж орлого ордог бүтээгдэхүүний saatлаас болоод импортын одоо орлого байхгүй болчихсон, экспортын, үүнээс болж валютын ханшид бас эрсдэл учирч байгаа.

Оросоос бид нар бензин шатахуун, улаан буудай, гурил, тэгээд одоо ургамлын тос, элсэн сахар гээд бараа бүтээгдэхүүнээ оруулж ирдэг. Гэтэл Оросын холбооны улс маань одоо дайнаас болоод олон улсын хориг арга хэмжээнд хамааралгдсан өөрөөр хэлэх юм бол одоо үндсэндээ хоёр улс маань нэг нь өөрийгөө тусгаарлаад, нөгөөдөх нь олон улсын хоригт ороод үүнээсээ болоод дунд нь байж байгаа Монгол Улс ийм одоо хүнд байдалд орчоод байгаа юм. Тийм болохоор бас энэ хүнд байдлаас гарахын тулд яаралтай бас оруулж ирж байгаа арга хэмжээг дэмжиж байгаа, дэмжиж байгаа. Гэхдээ энэ дээр анхаарах нь хэд хэдэн асуудал байгаад байгаа юм.

1 дүгээрт нь, бид нар сая ярьж байгаа гурил, мах, шатахууны үнэ дээр л анхааръяа аа гэчхээр цаад талд нь одоо үлдэж байгаа улсын нөөцийн тухай хууль одоо стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн гэж яригддаг төрөл бүрийн будаа, дээрээс нь ургамлын тос, мөн бусад бараа бүтээгдэхүүн эдгээрийн маань үнэ өсчих вий, үүний хангамж нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх тал дээр ямар одоо бодлого барих юм бэ? Энэ бас онцгой анхаарах ёстой асуудал аа. Өөрөөр хэлэх юм бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй бид бас тодорхой хэмжээнд анхаарах ёстой. Энэ дээр одоо бас бид зөвхөн одоо саяын гурван нэр төрлийн бүтээгдэхүүн гадна яаж анхаарах вэ?

2 дугаарт нь, нийтээрээ бараа бүтээгдэхүүний валютын ханшийн өсөлттөөс, мөн импортын цаад талаас, мөн бензин шатахууны үнийн өсөлттөөс энэ бараа бүтээгдэхүүн өснө өө. Ард иргэдийн орлого нэмэгдээгүй, нөгөө талд нь зардал нь өсөж байгаа энэ тохиолдолд нөгөө бага цалинтай, бага орлоготой нөгөө төрийн үйлчилгээний албан хаагч нар, бага цалинтай улсуудынхаа бас орлогыг нэмэгдүүлэх, энэ эрсдэлээс хамгаалах, энэ чиглэлээр одоо бас ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой вэ? Энэ тал дээр бас бодож байгаа зүйл байна уу? Үүнийг нэг хариулж өгөөч?

3 дугаар асуулт. Энэ өргөн барьсан хуулийн төсөл дээр бас зургаагийн нэгийн хоёр дахь заалт нь төсөв хооронд төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх эрхээ Засгийн газарт өгч байгаа. Үндсэн хуулийн Хорин тавын нэгд улсын төсөв, түүнийг гүйцэтгэлийн тайланг батлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх байна аа. Төсвийн тухай хуулиар бас тийм үү, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд ингэж шийдвэрлэнэ ээ гээд ингээд нэг хуулиуд бас байгаа. Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын бас тодорхой бүрэн эрхүүд Засгийн газар луу шилжих нь ээ. Энэ хууль хоорондын зөрчил үүсчих юм биш байгаа. Үүнийг нэг тодорхой бас хариулж өгөөч, энэ дээр анхаарсан уу? Үүнийг бид нар бас анхаарч байхгүй бол дараад нь одоо юу гэдэг юм, зөрчилтэй хууль өргөн бариад зөрчилтэй хууль одоо Улсын Их Хурал батлаад үүнээсээ болоод асуудал үүсчих вий, үүнийг хариулж өгөөч ээ гэсэн.

Мөн Монголбанкны тухай хуулиар бас Монголбанкны үндсэн зорилт нь үндсэн мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино оо гээд үндсэн зорилт байж байгаа. Энэ зорилтоос гадна одоо энэ хуулиар болбол үндсэндээ тавын нэгийн нэгээс тавын нэгийн зургаа хүртэл нэлээд одоо бас үүрэг хүлээх нь ээ. Энэ одоо үндсэн зорилттойгоо хэрхэн нийцэж байгаа вэ? Үүнийг бас нэг хариулж өгөөч ээ.

Сүүлийн асуулт нь 20 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаад валютыг гадагш нь гаргахыг хориглоно оо гэчихсэн байгаа. Тэгээд 20 саяас их бол яах юм.

Бага бол яах юм. Энэ хуулийн төслийн танилцуулга дээр тэгээд бичсэн байна л даа. 20 сая төгрөгтэй тэнцэх хэмжээг хориглоно. Дээш, доош нь яах нь тодорхой биш.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайдын үүргийг гүйцэтгэгч хариулья.

**Б.Жавхлан:** Бямбацогт гишүүн байдлыг зөв тодорхойлж хэллээ. Хойд хөрш маань одоо ингээд зэвсэгт мөргөлдөөн ингээд завгүй болчихсон. Үрд хөрш маань ковидынхоо учрыг одоо хүртэл олдоггүй. Одоо бүр ингээд дэгдээд, ялангуяа одоо манайтай яг хиллэдэг нутгаараа бүр чиг тохиолдлууд зарим том хотууд нь хөл хорио руугаа яваад биднийг бүр нэг жилийн өмнөх байсан байдал руугаа явж очоод ингээд экспорт маань гардаггүй ийм том хайчин дунд орчихсон. Том зургаараа бол бид нар олон жил потенциалын экспортоо хийж чадаагүйгээ валютынхаа нөөцийг тэр хэмжээнд хангалттай хэмжээнд зузаатгаж чадаагүй байгаагийнхаа өнөөдөр бид нар төлөөсөнд орж байгаа байхгүй юу. Нөхцөл байдал товчхондоо бол ийм эдийн засаг. Ийм, одоо богино хугацааны шокийг бид тэсэж гарах ийм л одоо тулаанд ийм сорилтод орж ирж байна аа гэсэн үг.

Тэгэхээр энэ удаагийн энэ хуулийн зохицуулалт нь болбол зөвхөн энэ богино хугацааны энэ нийлүүлэлтийн шокийг зөвлөж гаргах, ялангуяа бидний зохицуулж чадахгүй шатахууны энэ үнийн нөлөөллийг одоо эдийн засагт аажмаар бууруулж зөвлөж оруулж ирэх ямар боломжууд байна, үүнийг тодорхой болгоё оо гэсэн ийм л одоо хуулийн агуулга юм байгаа юм шүү.

Төсөвтэй холбоотой, цалин мөнгөтэй холбоотой, төрийн албан хаагч нар өрхийн орлогуудыг дэмжих асуудал бол энэ төсвийн бодлого бөгөөд түүний хүрээнд дунд хугацаанд урт хугацаанд бид нар одоо үргэлж байдаг энэ мөнхийн сэдэв зохицуултаараа ингээд явна аа.

Төсөв хооронд гэж байгаа тийм зөв тийм зохицуулалт байгаа. Одоо үргэлжилж байгаа ковидын хууль дотор ч гэсэн байгаа. Тэгэхээр энэ ялгаатай зүйл нь төсвийн ерөнхийлөгч, захирагч нарын хооронд юм байгаа юм, хооронд хаана одоо хэмнэлттэй гаргах боломжтой нөөц байна. Түүнийг одоо шаардлагатай төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв рүү шилжүүлэх замаар одоо ийм боломжуудыг нэмэх ээ л гэсэн үг юм байгаа юм. Ялангуяа одоо энэ удаа шатахуун, мах, гурил гэж байгаа учраас Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд руу нэмэлт төсвүүд шаардлагатай болж ирнэ ээ. Тийм учраас бусад сайд нар, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр ямар одоо хэмнэлт гарч болох вэ. тэр болгоныг тултал ажиллуулна. Ингээд төсөв ерөнхийлөн захирагч нарын хооронд нэмэлт эх үүсвэрийг зохицуулах шаардлагыг энэ хуулиар олгооч ээ гэж байгаа юм. Тэгэхдээ энэ болбол одоо Их Хурлаас эрхийг нь шилжүүлэх гэхээсээ илүүтэй ажиллагааг хөнгөвчилж байна гэж би хэлмээр байгаа юм. Түүнээс биш Их Хурал дээр энэ төсвөө шийддэг, эцэслэн баталдаг эрх байдгаараа байж байна. Харин үүнийг энэ хуулиар хөнгөвчилж түргэн шийдвэр гаргах боломжийг нь олгож байна аа гэж ингэж харж байгаа юм.

Бусад бараа бүтээгдэхүүн гэж байна. Бусад бараа бүтээгдэхүүн гээд халиад аваад явчих юм бол нөгөө ёстой яг ингээд нэг хавтгайрсан нөгөө нэг одоо ёстой үнэ тогтвортжуулах үнэ барих гээд одоо төсөв өөрөө ч одоо дийлж барахгүй ёстой нөгөө хязгаараа даваад мөнгө хэвлэх ажил руугаа явж орох ийм эрсдэлтэй учраас бид одоо чадах хэмжээнд төсвийнхөө чадах хэмжээндээ мөнгөний бодлогоо

хатууруулчихсан энэ төлөвийнхөө хэмжээнд стратегийн хийж болох яг топ гурван ийм инфляцад хамгийн хүчтэй нөлөөлдөг ийм бүтээгдэхүүнүүд дээрээ одоо анхаарья аа. Энэ дээрээ төвлөрье өө гэж байгаа юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ

**Л.Оюун-Эрдэнэ:** Бямбацогт гишүүний асуултад нэмэлт бас байр сууриа илэрхийлье. Үнэн л дээ. Монгол Улс хоригийн хоригт орчоод байна. Хоёр хөрштэй маань ийм нөхцөл байдал үүсээд нэг талдаа цар тахлын том дэгдэлт явж байна. Өдрөөс өдөрт нэмэгдэх хандлагатай ийм байна. Нөгөө талд одоо зэвсэгт мөргөлдөөн болж байна. Агаарын хил ч бай, хуурай замын хил ч бай хоёр хөршөөс маань шууд хамааралтай, өөр байдлаар одоо дамжин орж ирэх ийм зам бидэнд байхгүй. Агаарын тээвэр хэт үнэтэй, ийм нөхцөл байдал дунд одоо бид нар байна. Ер нь дэлхийн хоёрдугаар дайнаас хойш Нэгдсэн үндэсний байгууллагын хувьд ч бай яг ийм сорилт бол одоо хүн төрөлхтөн сая л учирч байх шиг байна. Яг бүх улс татагдан орж байгаа том эдийн засгийн ийм одоо амаргүй сорилтод орчихсон. Манай улсын хувьд бол одоо түдгэлзсэн ийм байр суурьтай явж байгаа нь ч гэсэн энэ амаргүй сорилт дунд Монгол Улсын тусгаар тогтолц, үндэсний аюулгүй байдал, бүрэн бүтэн байдал энэ бүх зүйлээ бид нарын хувьд одоо хэрхэн авч гарах вэ. Мөн одоо улс орнуудад Нэгдсэн үндэсний байгууллагын зүгээс анхааруулж байгаа болзошгүй өлсгөлөн үнэхээр болбол адаглаад бид нар махтай гурилтайгаа шатахуунтайгаа байх энэ зүйл рүү л явж байна гэсэн үг. Одоо шулуухан л хэлэхэд. Тийм учраас мэдээж ингээд л наранцэцэгийн тос, элсэн чихэр, будаа, төмс, сонгино гээд л ингээд явж болох ч гэсэн үндсэндээ Засгийн газрын зүгээс үүнийг тооцож үзээд энэ ачааллаа даахад туйлын хүнд юм байна аа. Ганц боломж нь импортын татварыг тэглэх л байх байх. Тэглээ гээд хэр зэрэг тийм үр дүнд хүрэх вэ. Хилийн чанадад үнэ нэмэгдчихвэл импортын бараа бүтээгдэхүүн, инфляц үрсаад л ороод ирнэ гэсэн үг. Ер нь бол үнэ өөр одоо ямар дунд нь бид нар одоо гааль түүн дээр хөнгөлөлт хийж чадах биш. Тийм учраас ийм амаргүй нөхцөл байдал дунд орчоод байна. Тийм учраас ийм амаргүй нөхцөл байдалд Засгийн газар тов тодорхой байр суурь барих ёстой гэж би ойлгож байгаа юм. Мэдээж аль талаар нь ч авсан улс төртэй, амаргүй нөхцөл байдал гэдгийг би ойлгож байгаа юм. Гэхдээ улс төр болчих болов уу, хожмын нэг өдөр одоо асуудал болчих болов уу гэж бодоод ийм асуудал дээр эс үйлдэл хийж байгаад цаг алдахыг би Ерөнхий сайдын хувьд үнэхээр хүсэхгүй байгаа.

Өнөөдөр мянган төгрөг яах вэ, нэмэгдэнэ л биз гэж хэлж байгаа хүмүүс бас байгаа л даа. Яг энэ цаг үед мянган төгрөг шатахуун дээр нэмэгдэнэ гэдэг бол бас тийм таатай зүйл биш. Дагаад бид нар цалин, тэтгэвэр тэтгэмжээ нэмнэ гэхэд сая бид нар тэтгэвэр 650 орчим тэрбумаар нэмээд одоо бид нарт тийм орон зайд туйлын хүнд л дээ. Тэгээд цаашаа энэ маань өөрөө байнгын зардал болоод төсөв дээр урсгал зардал болоод явчих учраас. Тийм учраас л бидний хувьд одоо тооцож бодож байгаад ийм эрс шийдэмгий арга хэмжээ авах нь бол зүйтэй байх аа гэж Ерөнхий сайдын хувьд бол шийдсэн гэдгээ хэлэх нь зүйтэй.

Өөр нэг зүйл ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд гүйцээж хариулья, нэмэлт.

**Л.Оюун-Эрдэнэ:** Өөр нэг зүйл, би Их Хурлаасаа ямар ч асуудлыг нуухгүй ийм нээлттэй ил тод байх ийм зарчим барина аа гэж бодож байгаа юм. Ирэх долоо

хоногоос Эрдэнэбүрэн цахилгаан станцтай холбоотой асуудлыг оруулж ирнэ ээ гэж бид нар төлөвлөж байгаа. Засгийн газраас. Тэнд бас асуудлууд байна аа. Их Хурал дээрээ нээлттэй яриад болно, болохгүй нөхөн олговор олон асуудлууд байна. Тэр малчдын асуудлаар яриад л шийдье болохгүй бол яах вэ. Болбол тэр л биз, ингээд л явъя.

Улаанбаатар хотын түгжрэлтэй холбоотой LRT хөнгөн галт тэрэгний асуудлыг Их Хуралд оруулж ирнэ гэж бид нарын хувьд төлөвлөж байгаа юм. Энэ асуудлыг ч мөн, тийм учраас Их Хурлаар ярилцаад эрх зүйн орчин бүрдүүлээд явах нь хамгийн зөв гарц юм аа гэж бодож байгаа. Түүнээс биш одоо нэг, дөрөв, таван хүн суугаад л ийм байдалтайгаар ингээд хийчихье гэдэг ийм зарчмаар яваад өмнө нь бол алдаа гарсан гэж би боддог. Тийм учраас цаашдаа ч гэсэн одоо улс орны нийгэм, эдийн засагтай холбоотой Засгийн газар бие даан шийтгэхэд ийм боломжгүй асуудлуудыг би Их Хурал руу оруулж ирнэ гэж бодож байгаа. Энэ бол Засгийн газрын хуулиар олгогдсон бүрэн эрх. Хүлээж авах эсэх нь Их Хурлын хуулиар олгогдсон бүрэн эрх. Шүүмжлэлтэй хандаж, олон ургалч үзлээр хандах нь ардчилсан зарчим. Тийм учраас энэ байдлаараа л бид нарын хувьд одоо асуудлуудаа ярилцаад, тэгээд олон нийттэй нээлттэй мэдээлэлтэй, ил тод асуудлаа шийдээд явах нь бол хамгийн зөв гарц байх аа л гэдэг агуулгаар ярьж байгаа. Юутай ч өнөөдөр зэвсэгт мөргөлдөөн болж байгаа нэн амаргүй нөхцөл байдал руу дэлхий, тэр дундаа манай Монгол Улс одоо энэ бол нэлээн тийм амаргүй сорилттой тулгана аа гэдэг нь бол бодитой учраас үүнийг одоо цаг алдалгүйгээр эрт ярих нь бол зүйтэй юм аа гэж үзэж байгаа юм. Энэ магадгүй одоо бид нарт энэ эхлэл мэдрэгдээгүй ч байгаа цаг үе байхыг үгүйсгэх аргагүй. Тийм учраас эртхэн энэ байдлуудыг ярьж, нэгдсэн ойлголттой байх нь бол зүйтэй юм аа гэж гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд бодож байгаа юм.

**Г.Занданшатар:** Бядрангийн Лхагвасүрэн 83.

**Б.Лхагвасүрэн:** Бямбацогт гишүүний асуултад хариулья. Монголбанкны мөнгөний бодлого, мөнгөний бодлогын шийдвэрүүд нь бол одоо макро эдийн засгийнхаа санхүүгийнхээ нөхцөл байдалтай хамааруулж ийм гардаг шийдвэрүүд байгаа. Өнөөдөр бол Монголбанкны бодлогын хүү бол нэлээн өндөр түвшинд 9 хувь дээр тогтоогдсон. Энэ маань өөрөө олон нийт болон хөрөнгө оруулагчдад бол ямар мессеж болж очдог вэ гэхээр бол төв банкны зүгээс бол мөнгөний бодлогыг хатууруулж байна аа. Санхүүгийн зах зээл дээр эргэлддэг мөнгөний тоог цөөрүүлж байна аа гэсэн бодлого байгаа. Гэхдээ өнөөдрийн энэ орж байгаа хуульдаа энэ гурван бүтээгдэхүүнтэй холбоотой асуудал дээр бол аль болохоор тэр арилжааны банк дээр байгаа хуримтлагдсан эх үүсвэрийг тусгайллан тусгай нөхцөлөөр энэ бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхэд нь чиглүүлж санхүүжилтийг олгох, ялангуяа энэ олгосон санхүүжилтээрээ бас төлбөр тооцоог тасралтгүй хийх. Энэ талаасаа ингээд ороод явж байгаа учраас бол төв банкны хуультай бол зөрчилдөхгүй байгаа.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж асууя, 1 минут.

**С.Бямбацогт:** Тэр нөхцөл байдлаа бас илэн далангүй яриад бас хамтдаа ингээд зовлон жаргалаа хуваалцаад Их Хуралтайгаа ард түмэнтэйгээ хуваалцаад оруулж байя гэж байгаа Ерөнхий сайдын байр суурийг дэмжиж байгаа. Яг бодит байдлыг зөв ойлгуулахгүй бол бол буруу мэдээлэлтэй, буруу хүлээлттэй явж байгаад улам одоо юу гэдэг юм, эрсдэлтэй бас асуудал үүсчих вий. Тийм болохоор бид нар бас ингэж нээлттэй ний нуугүй ярих нь зөв байх аа.

Энэ 12 онд бас нэг Чалкогоос урьдчилж нүүрсээ зараад бас баахан шүүмжлүүлсэн тал байдаг юм. Түүнтэй адилхан одоо бид нар энэ овоороод байгаа гаргаж чадахгүй байгаа нүүрсээ урьдчилж зараад нэг хэдэн тэрбум доллар оруулж ирээд үүгээрээ одоо энэ ханшийнхаа эрсдэл, одоо шатахуун одоо гол нэрийн бараа бүтээгдэхүүн үнийг барих иймэрхүү бодлого явуулж болохгүй юу. Нэг иймэрхүү гарц гаргалгаа байвал ясан юм. Одоо нэгэнтээ л нөхцөл байдал юм чинь. Сая ярилаа шүү дээ Ерөнхий сайд 1945 оноос дэлхийн хоёрдугаар дайнаас хойш одоо үүсээгүй ийм нөхцөл байдал үүсэж байна аа гэж. Ингээд үүнийгээ зөв ойлгуулж байгаад ийм учраас бид нар ийм арга хэмжээ авч байна. 12 онд болбол тийм үед ингэж авч байсан, гэтэл үүнээс өөр нөхцөл байдал үүслээ гэдгээ ярьж байгаад ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна аа.

**Л.Оюун-Эрдэнэ:** Засгийн газар мөнгөний бодлогод бас шууд оролцох ийм боломжгүй. Үндсэндээ ханш валютын нөөц бол Монголбанкны эрх үүрэг гээд ингээд яваад байхаар нөхцөл байдал маань өөрөө ийм стандарт бус, ер бусын нөхцөл байдал болж байгаа учраас Засгийн газар бүх талаар л одоо дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахаас өөр ийм гарцгүй болчож байгаа юм. Тийм учраас энэ хуулийн нэг үзэл санаа нь ч бас тэр байгаа. Бид нар одоо энэ томоохон уул уурхайн компаниуд болон бусад асуудал дээр экспортын бүтээгдэхүүний төлбөрийг урьдчилж авах талаар ийм хэлцлүүд хийж байгаа юм, тэгээд ойрын ирээдүйд бас үр дүн гарах болов уу гэсэн ийм агуулгатай ажиллаж байгаа. Түүн дотор Таван толгой, Эрдэнэт, Оюу толгойтой холбоотой одоо үндсэндээ бүтээгдэхүүн урьдчилж борлуулах ийм ямар боломжууд байна вэ. Мөн хөрөнгө оруулалт оруулах ийм санхүүгийн обьёмыг урьдчилж Монгол Улсад байршуулах талын ийм хэл ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Т.Энхтүвшин:** Энэ хуулийг бол дэмжиж байгаа. Үнэхээр энэ хил, гаалийн асуудал, энэ хажуу хөршийн бас дайн байлдааны асуудал гээд хэзээ ч одоо дуусах нь мэдэгдэхгүй байна шүү дээ. Тийм учраас энэ Монголчуудад одоо хамгийн их хэрэглэдэг энэ гурил, мах, газрын тосны бүтээгдэхүүнийг ингээд үнийн өсөлт хамгаалалт хомсдолоос сэргийлээд ингээд хуульчлаад явах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд би нэг хоёр зүйл дээр бас нэг анхаарал хандуулаач ээ гэж хэлэх гээд байгаа юм.

Түрүүн одоо 11 сар ч билүү 12 сард шатахууны хомсдол гарсан. Оросын холбооноос улсаас орж ирэх тэр үед одоо юу гэдэг юм Замын-Үүд дээр одоо олон жилийн өмнө барьж байгуулсан шингэн түлш шилжүүлэн ачих анги бол одоо нэлээн их тус болсон. Урд хөршөөс одоо бид нар бас бензин шатахуунаа татсан. Яг үүнийг одоо шилжүүлэх, цуглуулах, буулгах бүх зүйлийг бол энэ Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих анги бол ингэж биелүүлсэн. Тэгээд юу хэлэх гээд байна вэ гэхээр цаашдаа эдийн засгийн нөхцөл байдал бол ганц Монгол Улс биш дэлхий нийтээрээ л хүндэрч байгаа юм шиг байна. Тийм учраас энэ шатахууныхаа нөөцлөх улсын мэдлийнхээ савыг бас өргөтгөх ажлыг бас сайтар бас зохион байгуулбал цаашдаа ч гэсэн үр дүнтэй болох болов уу л гэсэн ийм бодолтой байж байна. Замын-Үүдийн энэ том, одоо шингэн түлш шилжүүлэх буулгах анги бол яг энэ бас эдийн засгийн энэ хүнд нөхцөлд бол үнэхээр одоо бас хэрэг болсон. Тийм учраас бас энэ Сэлэнгэ дээр ч гэдэг юм уу, Дархан дээр ч гэдэг юм уу, энэ сав энэ хадгалах савыг одоо бас нэмэгдүүлбэл ясан юм бэ гэж бодож байгаа.

2 дахь асуудал бол яах аргагүй энэ газрын тос, гурил, мах махан бүтээгдэхүүнээс гадна нөгөө эм, эмийн хэрэгслүүдээ бас нэмээд оруулчихвал ясан юм бэ? Эмийн одоо хомсдолд орох уу, эмнэлгийн хэрэгслийн бас хомсдолд орох уу? Манай Монгол Улс чинь ихэнх одоо юу гэдэг юм эм, эмнэлгийн хэрэгслээ бол Оросын холбооны улс болон энэ Зүүн өмнөд Ази, энэ Украян гээд ийм улсуудаас татаж авдаг юм байна аа. Тийм учраас бас энэ эмийн асуудал эм эмнэлгийн хэрэгслийг хомсдолыг бас бий болгохгүй, үүнийг нөөцийг бүрдүүлэх асуудал дээр одооноос эхлээд анхаарахгүй бол цаашдаа бас энэ эмнэлгийн энэ зүйлүүд бас хүндрэх бас магадлал бас гарч магадгүй ээ. Тийм учраас энэ дээр бас нэлээн анхаарч ажиллаач ээ гэж бодож байна.

3 дугаар асуудал бол нэгэнт л ийм цаг хүнд байгаа үед бол энэ Атрын дөрөв дүгээр аянаа бол сайн дэмжээд тултал нь одоо энэ аж ахуйн нэгж байгууллагуудаа дэмжээд явуулчихвал бид бас нөгөө хүнсний ногооны хангамжаа дотоодынхоо хэрэгцээгээ хангах ийм бас бололцоо боломж гарч магадгүй. Дээр нь энэ нэг улаан буудай, гурил гурилан бүтээгдэхүүнээ гадагшаа экспортлох бас ийм одоо бас бололцоо боломж гарч үүгээрээ валют болох ийм бас бололцоо боломж бас гарч магадгүй ээ. Тийм учраас бол энэ Атрын дөрөвдүгээр аянаа одоо сайн дэмжээд, энэ газар тариалан эрхэлж байгаа энэ аж ахуйн нэгж байгууллага, иргэдээ бас сайн дэмжих юм бол одоо бас үр дүн бас гарах юм байна аа л гэж одоо бодож байна. Ингээд энэ хуулийг бас дэмжиж байгаагаа илэрхийлье ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Санал юм даа тийм ээ. Асуулт. Ерөнхий сайд хариулъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Засгийн газар дээр эм, эмнэлгийн бүтээгдэхүүнээ оруулчихъя аа. Элсэн чихэр оруулчихъя одоо гурил болон гурилан бүтээгдэхүүний бас одоо нөгөө орцод их чухал байдаг гэдэг агуулгаар наранцэцгийн тос оруулчихъя гээд ингээд явж байсан юм. Ингээд Сангийн яаман дээр ерөнхийдээ тооцоолол хийж үзээд одоо импортын татвар тэглэхээс өөр байдлаар ер нь бол одоо бид нар яаж ч чадахгүй юм байна аа л гэдэг л ийм одоо дүгнэлтэд л очсон л доо. Нэг үгээр хэлбэл хүлээлт үүсгээд тэгээд олигтой үр дүн гарч чадахгүй, ийм нөхцөл байдалд орох байх аа гээд энэ гурван бүтээгдэхүүн дээр ч бас одоо шууд энэ хууль батлагдсанаар, тэгээд одоо мэдээж үнэ өсөж байгаа энэ зүйл дээр тодорхой хэмжээний зохицуулалтыг л бид нар хийнэ үү гэхээс биш бас одоо ид шидтэйгээр шууд барьчихна гэж байхгүй шүү дээ. Гэхдээ л юутай ч энэ одоо гурван гол бүтээгдэхүүн дээр л одоо гол фокус өгье. Энэ дотор энэ агуулах зоорь болон бусад асуудлуудыг давхар авч явж байгаа юм. Нэг үгээр хэлбэл нефтийн тодорхой хэмжээний үйлдвэрлэл, татан авалттай холбоотой мөн хүнсний өвлүүн зоорьтой холбоотой бараа бүтээгдэхүүнийг ер нь одоо авья, ер нь ийм хямралт нөхцөл байдал үүсвэл Монгол Улс хэд хоногийн л нөөцтэй байж чадах юм бэ гэдэг энэ зүйлийг бас ярья аа. Ер нь бол манайх их л эмзэг юм байна лээ дээ. Яг үнэндээ бол одоо зүгээр тайван цагт ингээд бид нар амьдраад бас сурчихсан. Сэтгэл зүйн хувьд ч их эмзэг, татан авалт болон одоо бусад асуудал дээр ч туйлын хүндрэлтэй. Тэгэхээр одоо бид нар яалт ч үгүй л тэр одоо Шинэ сэргэлтийн бодлогоор дэвшүүлсэн тэр зургаан асуудлаа бид нар шийдэхээс өөрөөр гарцгүй л юм байна лээ. Нефтийн үйлдвэртэй барих ёстой, эрчим хүчний хувьд хараат бус болох ёстой, дотооддоо хүнсээ хангадаг болох ёстой. Зоорь одоо хүлэмжтэй болох ёстой. Энэ бүх зүйлийг бид нар хийхээс өөр гарцгүй, Атрын дөрөв бол бас сайн хийгдэнэ гэж төлөвлөгдөөд явж байгаа. Тэгээд яах вэ Их Хуралд эрх байгаа тэр нь юу вэ гэхлээр, импортын татвартай холбоотой хөдөлгөөнийг Засгийн газар тухайн үед нь ингээд зохицуулаад байдаг ийм одоо түр эрхийг өгөөч ээ гэдэг ийм одоо асуудал болж байгаа хууль дээр, тухайн үед нь дандаа Их Хуралд оруулж

ирэхгүйгээр, энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд энэ дотор бусад энэ бүтээгдэхүүн ороод явчихвал болно. Мөн одоо яах вэ ковидын үеэр бас энэ эм тариа болон бусад зүйлтэй холбоотой манай Эрүүл мэндийн яам бол бас нэлээн тийм холбоо харилцаа сайтай бас тийм л болсон юм байна лээ. Яг энэ хугацаанд. Тийм учраас эм, эмнэлгийн хэрэгсэл гэдэг өөрөө их тийм том агуулгатай учраас бас их тийм олон аж ахуйн нэгжүүд дээр хүлээлт үүсгээд, тэгээд ер нь ингээд обьёмыг нь нэмээд байх тусам л улам илүү их тийм асуудал гарахаас гадна үр дүн их багатай болох ийм одоо бодитой асуудалтай учраас юутай ч түлш, мах, гурил одоо манай гол бүтээгдэхүүн буюу инфляциад хамгийн их нөлөө үзүүлээд байгаа эхний гурван зүйл энэ л юм байна лээ. Одоо манай инфляц нэг 15 орчим хувьтай, үүний бараг 50 орчим хувь нь энэ гурван бүтээгдэхүүн л байгаа. Тийм учраас үүнийгээ л одоо бидний хувьд, ер нь их цаашдаа анхааръя аа гэдэг агуулгаар энэ цаг үед, бас ингээд хийгээд ярилцаад явчих нь бол хамгийн зөв зүйтэй юм аа.

Мэдээж дунд, урт хугацаандаа бол олон асуудлууд байна аа. Түүнийг тэгээд хэдүүлээ ярилцаад, мөрийн хөтөлбөр болон бусад хүрээндээ ингээд яриад явчхаж болно. Үүнийг бол цаг алдаж болохгүй болчож байгаа ийм нөхцөл байдал руу одоо аажмаар нөхцөл байдал шилжиж байгаа учраас цаг алдаад яах вэ эртхэн шиг Засгийн газар бэлтгэл ажлаа хангаж байх нь зүйтэй байх аа л гэж бодож байгаа юм.

**Г.Занданшатар:** Одоо Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

**Ж.Чинбүрэн:** Бүх гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Өргөн хэрэглээний барааны үнэ өдөр цагаар нэмэгдээд өнөөдөр авсан үнээрээ гурил будаа, талхаа маргааш нь авч чадахгүй, үнэ нь нэмэгдсэн байгаа нь бол үнэн. Үнэхээр одоо тулгамдаж байгаа том асуудал аа. Цар тахлын хөл хорионы 2 жилийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгжүүд маань орлого эрс багассан. Зарим бизнес, ялангуяа аялал жуулчлалын чиглэлийн бизнесүүд бол бүрэн дампуурсан. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгаа сэргээх 10 их наядын төлөвлөгөө Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд сэргэж байсан эдийн засаг маань олон улсын энэ хямралт байдлаас үүдэлтэй буцаад хямарч байгаа. Үүний хор нөлөөг одоо ард иргэд л үүрч байна л даа. Энэ үнийн өсөлт инфляцтай холбоотойгоор. Иймд Засгийн газраас өргөн мэдүүлсэн гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн болох газрын тосны бүтээгдэхүүн, гурил, махны үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэхээр өргөн мэдүүлсэн хуулийг бүрэн дэмжиж байна аа.

Бид 20 онд баталсан эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог шинэчлээд энэ хуулиар бол бид ковид цар тахалтай үнэхээр мундаг давж гарч чадлаа. Мөн одоо энэ хуулийн хүрээнд бид эмийн агентлаг байгуулж, эмийн агентлаг одоо яг энэ дельта вирусийн давлагааны үед Ремдесивир гэдэг тариаг маш шуурхай авчирч, бүр тэр битгий хэл одоо дэлхий дээр байгаа үнээс хямд авчирсан шүү дээ. Тийм ээ. Ингэснээрээ одоо Монгол Улс бол энэ гарз хохирол багатай ковид цар тахлыг давж чадсан. Энэ бол одоо том сайн жишээнүүд байж байна. Тийм учраас энэ хууль бол үнэхээр одоо маневарлах хурдан шийдвэр гаргах энэ боломжийг олгож байгаа. Одоо санал нэг байгаа.

Энхтүвшин гишүүний хэлснээр бол бас эмийн хэрэглэхүүний асуудлыг та бүхэн заавал анхаарч өгөөрэй. Яагаад гэхээр зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон эмүүдээ бид яаж болох юм, татвараас чөлөөлж болох юм. Тэгвэл одоо бас энэ үнийн өсөлтөөсөө сэргийлэх боломж байна. Зайлшгүй шаардлагатай эм гэдэг маань одоо архаг хууч өвчтэй эмээ уухгүй л бол болохгүй

гэсэн хүмүүст өгдөг эм учраас үүнийг бол одоо хөнгөлөх боломж бас байгаа. Тийм учраас үүнийг та анхаарч Засгийн газар энэ хуульдаа үүнийг оруулахыг хүсэж байна аа.

Ингээд мэдээж экспортоо дэмжих хэрэгтэй. Валютын нөөцөө нэмэгдүүлэх хэрэгтэй. Та бүхэн бас мэдээлэл авч л байгаа байх. Европын холбоо болон Америк, Оросын холбооны улсын эсрэг одоо ахиад дараагийн санкцуудаа гаргаж байна. Энэ дотор одоо хуурай замаа усан портуудыг бүгдийг нь одоо хааж байна. Тэгээд одоо Оросын холбооны улсын Ерөнхийлөгчийн явж байгаа гол, одоо хийсэн энэ жилүүдэд бэлтгэл хийсэн ажил нь одоо эх орондоо бүтээдэг болгох гэсэн ийм том зорилгоо хэрэгжүүлээд явж байгаа. Тэгэхээр бид бас энэ чиглэлд бас илүү их хийх ажиллах байх аа. Тэгээд хууль батлагдаад хэрэгжихэд хэн нэгэнд одоо давуу байдал бий болгохгүй, хардарт сэргэлтгүй байхын тулд одоо үйл ажиллагаа нээлттэй ил тод явуулах л чухал. Ингэвэл одоо ард иргэд улам одоо Засгийн газар, Их хурал, одоо бид бүгдийг илүү их ойлгож дэмжиж энэ нөхцөл байдалтай илүү ойрхон ажиллах байх аа. Ингээд амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Чинбурэн гишүүнд бас баярлалаа. Би энэ цар тахлын хуулийг сая үгэндээ онцолсон. Цар тахлын хууль бол Монгол Улсын цар тахлын эсрэг тэмцэлд түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Саяхан би одоо цар тахлын хүнд үед яг галын тэргүүн эгнээнд ажилласан эмч нартай уулзаж, энэ олон улсад байгаа цар тахлын энэ том давлагаанууд явж байна. Манай Монгол Улсад харьцангуй бас тайван байна. Энэ нөхцөл байдал цаашид ер нь яаж харж байгаа вэ гэдэг энэ талаар нэлээн бас дэлгэрэнгүй мэдээлэл солилцсон. Энэ цаг үед одоо цар тахлын оргил үе давлагаалаад давхацсан бол энэ үнэхээр бас их хүнд байдалд орох байсан. Тэгээд тэр эмч нар тэгж хэллээ.

1 дүгээрт дотооддоо 10сар алдаагүй нь бол вакцинтай золгох энэ цаг хугацааг авсан тэнгэрээс өгсөн цаг байсан гэж. Энэ дээр одоо манай Сарангэрэл сайд тухайн үед ажиллаж байсан, вакцин хөөцөлдөөд манай Хүрэлбаатар сайд ажиллаж байсан. Үнэхээр тэр 10 сар бол одоо Монголчууд биднийг 40 орчим мяняган хүний одоо амь насыг аварсан ийм том асуудал болж ингээд вакцинтай залгах боломж бүрдсэн. Цар тахлын хууль байгаагүй бол вакцин шууд бас их хэмжээгээр худалдан авах ямар ч боломжгүй байсан. 11 сараас сая вакцин эхлэх байсан шүү дээ. Яг графикаар, үүнийг одоо бид бүгдээрээ мэдэж байгаа юм. Тэгээд бас одоо улс орны Засгийн газрууд хоёр хөршөөс маань эхлээд тусалсан, бид нарт дэм болсон, Америкийн нэгдсэн улс, Энэтхэг тэргүүтэй Засгийн газрууд тусалсан ковакс хөтөлбөр гээд тусалсан. Өнөөдөр бид нар дэлхий дээр ингээд ямар ч хязгаарлалтгүй цөөхөн улсуудын нэг байгаа. Одоо бараг цар тахал ямар байсан хатуу хөл хорионы үед ямар хүнд байсан. Үсчин гоо сайхан ажиллахгүй, барааны захууд хаалттай байсан үеийг бараг бид нар мартчихсан байх шиг байна л даа. Тэгээд дахиад бид нар дөрөвдүгээр вакцинаа бас идэвхжүүлэх хэрэгтэй л болж байгаа юм. Энэ дээр одоо бид нар бас ингээд хамтраад л ажиллахгүй бол манайх ингээд одоо дандаа ийм байх юм шиг бас бодоод л байгаа юм. Яагаад гэхээр энэ вакцин бас л өөрөө нэг 10, 12 сарын дараа дахиж супардаг. Тийм учраас энэ дахиад хийх хэрэгтэй л гэж эмч нар үзэж байгаа юм байна лээ. Үүнийг одоо та хэд маань сайн мэдэж байгаа байх. Тийм учраас энэ цар тахлын хууль түүхэн үүргээ гүйцэтгэсэн шиг энэ хууль ч гэсэн би одоо бас энэ зэвсэгт мөргөлдөөний манай хөрш орон, бүс нутагт гарсан энэ маш амаргүй нөхцөл байдал дундаас хохирол багатай даван гарах бас нэг эрх зүйн том шийдэл болов

уу гэж бодож байгаа юм. Тийм учраас бид нар шуурхай бэлтгэл ажлаа хангаад ингээд явахад бас дараа нь үр дүн нь илүү эерэг гарах байх аа гэсэн ийм одоо хүлээлттэй л байж байна. Үнэндээ өөр гарц бас бид нарт алга. Хараад санаагаар унаад суугаад л даа биш. Мөчлөг сөрж бид нарын хувьд илүү бэлтгэл ажлаа хангаад байж байхаас л өөр гарцгүй шүү дээ. Тийм учраас яг ковидын үед бид нар цаг алдалгүй одоо амьсгалын аппарат татаж байсан шиг тэр олон асуудлуудыг бид нар одоо шийдэж, тэр нэр бүхий зарим эм тариаг түрүүлж татахаас авахуулаад их олон зүйлийг цаг алдалгүй бэлтгэл ажлаа хангаж чадсан шиг одоо ч гэсэн бид нар энэ гол төрлийн нэрийн бүтээгдэхүүнүүд дээр одооноос л ажиллаж байх нь явав ч буруу зүйл биш бодсоноос сайнаар явбал тэр л биз, бодсоноос муугаар явбал бид бэлтгэлтэй байх ёстой гэдэг агуулгаараа энэ хууль маань өөрөө бас туйлын чухал.

Мөн Монголбанктай Засгийн газар хамтарч бас илүү их тийм дэмжиж ажиллах ийм одоо боломж үүсгэх нь туйлын чухал байна аа л гэж үзэж байгаа юм.

### Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас дайны цаг үе, олон улсын хүнд нөхцөл байдалтай холбогдуулж Монгол Улсад ард иргэдээ эдийн засгийн эрсдэл бусад эрсдэлүүдээс хамгаалах зорилгоор энэ хуулийн төслийг өргөн барь барьж оруулж ирсэн. Өчигдөр Эдийн засгийн байнгын хороон дээр бид үүнийг бас тодорхой ярьж, хэлэлцсэн. Энэ асуудлыг одоо Улсын Их Хурал, Засгийн газар, нийт ард иргэд, хэвлэл мэдээллийнхэнд тийм тодорхой мэдээлэл өгч, энэ эрсдэлээс яаж Монголчуудаа хамгаалах вэ, яаж бага хохиролтой гарах вэ гэдэг энэ асуудлыг өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэр гаргах гэж байгаа нь болбол цаг үеэ олсон зайлшгүй шийдэх ёстой асуудал аа. Энэ асуудал дээр улс төрчид эх орноо гэсэн сэтгэлээр, энэ ард түмнээ гэсэн сэтгэлээр аливаа асуудалд улс төржихгүйгээр хандаж шийдэж энэ цаг үеийн энэ хүнд нөхцөлийг давах ийм одоо шаардлага байгаа гэдгийг бас та бүгдэд бас хэлэх нь зүйтэй байх аа.

Өчигдөр Эдийн засгийн байнгын хороо дээр бас 12 хоёр оны Засгийн газрын үед үнэ тогтвортжуулах одоо ийм гэсэн ийм маргааны сэдэв бас нэлээн ярьж байсан. Энэ дээр би бас бодлогын ойлголтоос зөрүүгээс, бас Сангийн сайдтай бас тодорхой санал бодлын зөрөлдөөн гаргаснаа эндээ бас тодорхой уучлалт хүсье. Ер нь өнөөдөр энэ асуудлаар бид ингэж маргаж, түүний үед тийм байсан, одоо тэгнэ гэсэн ийм асуудал гаргаад цаашдаа ямар ч үр дүн гарахгүй байх аа. Үүнийг бол сөрөг хүчинийхэн ч бай, хэвлэл мэдээллийнхэн, эрх баригчид ч бай үүнийг бид сэтгэл санаа нэгтэй, зөв бодлого нэгтэй, байгаа юмаа үнэнээр нь ярьж, зөв бодлогоо тодорхойлж, энэ ард иргэдээ энэ эрсдэлээс хамгаалах энэ асуудал хамгийн чухал байгаа юм аа. Энэ одоо хуулийн төслийг бид зайлшгүй яаралтай горимоор шийдэх ёстой. Энэ ковид гэдэг энэ цар тахлын үед Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам тодорхой зорилтуудыг тавьж вакцинжуулж ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар ажил хийснийг үгүйсгэхгүй ээ.

Гэхдээ бас энд нэг зарим нэг зүйлийг би Ерөнхий сайд байгаа үед асууя гэж бодож байна. Энэ сүүлийн үед энэ Монголбанктай холбоотой мөнгөний бодлоготой холбоотой, валютын нөөцтэй холбоотой олон асуудал өнөөдөр улс төрчид, Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд ярьж байгаа. Энэ Хүрэлбаатар гишүүн одоо удаа дараа ярьж байгаа. Энэ Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн гээд энэ хүн Хaan банкийг Худалдаа хөгжлийн банканд өгчихсөн юм, дээр нь одоо энэ Үндэсний хөрөнгө оруулалтын банкийг бас хууль зөрчөөд зээл

өгчихсөн гэдэг ийм асуудал удаа дараа өөрийн байр сууриа илэрхийлж байгаа. Гэтэл өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Ардын намын дарга Оюун-Эрдэнэ дарга, одоо Монголбанкны Ерөнхийлөгч маш сайн ажиллаж байна, энэ хүнийг цаашдаа ажиллуулна аа, үүнийг дэмжинэ ээ гэсэн ийм одоо байр суурь яваад байна аа, энэ цаг үед энэ Монгол Ардын нам, эрх барьж байгаа та бүхэн энэ бодлогоо нэгтгээч ээ. Одоо энд бас ийм байдлаас чинь үүсээд энэ Монголбанкад итгэх итгэл, энэ банкад итгэх итгэл, алдар бол ямар асуудал болох та нар мэдэж байгаа шүү дээ. Энэ дээрээ одоо нэг тодорхой хариулт өгмөөр байна аа. Одоо үнэхээр энэ Лхагвасүрэн гэдэг хүн тэр Хаан банкийг Худалдаа хөгжлийн банканд өгсөн юм уу? Одоо Хөрөнгө оруулалтын банк нь ... /минут дуусав/

### **Г.Занданшатар: Эхлээд зочин танилцуулья.**

Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн Хурх тосгоны төрийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсэн өрөөе ёө.

Одоо асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна аа.

**Л.Оюун-Эрдэнэ:** Адьшаа гишүүний асуултад хариулья аа. Миний байр суурь маш тодорхой байгаа. Тэр нь юу вэ гэхээр, би ийм хямралтай цаг үед, ялангуяа ийм гол стратегийн албан тушаалтууд тогтвортой байгаасай л гэдэг ийм л байр суурь барьж байгаа юм. Түүнээс одоо тэр банк хоорондын асуудал, эд нар бол хөёрдугаар асуудал болчож байгаа яг энэ цаг үед. Тэр нь тэгээд хууль хяналтын байгууллага тогтооно биз гэж бодож байгаа юм. Би нэг Лхагвасүрэн гэж хүнийг одоо хамгаалаад байгаа нь өмнө нь таньдаг учраас ч юм уу, хамт ажиллаж байсан учраас ч юм уу, тийм зүйл надад огт байхгүй. Таних ч үгүй. Би одоо ч гэсэн, томилоход нь оролцож байгаагүй. Тэр дундаа тэр Хаан банктай холбоотой асуудал дээр бол би хатуу эсрэг байр суурьтай байсан. Түүнийг холбогдох зарим хүмүүс мэдэж байгаа. Харин энэ цаг үе бол өөр цаг үе, энэ цаг үед одоо бид нар хүн солиод дахиж шинэ хүн Их Хурлаар томилогдоод нөгөө хүн нь багаа бүрдүүлээд, тэгээд Засгийн газартай ойлголцоод хамтарч ажиллана гэсээр байтал одоо нөгөө энэ хямралт нөхцөл байдал бүр гүнзгийрч магадгүй ээ гэж л би бодож байгаа юм. Парламент бол ардчилсан парламент, өөр өөрийн дуу хоолой, өөр өөрийн эдийн засагчдын байр суурь одоо байх ёстой газар. Гэхдээ ийм үед илүү тийм одоо тогтвортой ажиллах нь улс орны язгуур эрх ашигт нийцнэ гэж би Ерөнхий сайдын хувьд үзэж байгаа юм. Миний байр суурь маш тодорхой байгаа гэдгээ хэлэх нь зүйтэй байх аа гэж бодож байна.

Мөн одоо Их Хурлаар оруулж ирж байгаа тэр өмнөх хөтөлбөрүүд энэ тэр гээд бас ийм зүйлүүд яригдаж байгаа юм. Миний хувьд энэ маш ялгаатай асуудал аа гэж бодож байгаа юм. Нэгдүгээрт энэ Их Хурлаар яригдаж байгаа асуудал. Өнөөдөр би хууль оруулж ирж байгаа юм. Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээг тогтоох эрх бүхий төрийн дээд байгууллагад. Түүнээс би Засгийн газар дээр ч юм уу, эсвэл Монголбанкны Ерөнхийлөгчийг арын өрөөндөө дуудаж байгаад Их Хурлаас нууц шийдвэр гаргах гэж байгаа юм биш. Би захирамж дээр Засгийн газраар оруулахгүйгээр ганцаараа захирамж сурх гэж байгаа асуудал биш олон асуудлууд энэ том төслүүд дээр гарч ирнэ ээ. Оюу толгойг ч гэсэн бид нар

бүгдээрээ хэлэлцээд шийдсэн. Би энэ зөв болсон гэж боддог, бүгдээрээ ингээд ярилцаад хамтдаа нээлттэй шийдсэн нь өнөөдөр бид нар ийм шийдэл гаргасан нь бас энэ амаргүй үед зэс дээр бас өнөөдөр Монгол Улсыг авч явах томоохон ийм боломж бас гарсан гэж би бодож байгаа юм. Одоо бас ингээд маргалдаад гацчихсан их олон асуудлууд байгаа. Төмөр замтай холбоотой асуудлууд үүнийг одоо удахгүй би бас Их Хурал дээр нээлттэй ярих ёстой гэж бодож байгаа юм. Эрдэнэбүрэнтэй холбоотой асуудал. Би бас Их Хурал дээр ярих ёстой. Улаанбаатар хотын түгжрэлтэй холбоотой асуудал Их Хурал дээр ярих ёстой. Тэгээд л ярилцъя, би юуг ч нуухыг хүсэхгүй байна. Байгаа байдлаа би бодитоор нь л хэлнэ. Цаасыг нь үзүүлнэ, цаасаар нь өгнө. Тэгээд дэмжигдэхгүй бол би ойлгоно оо. Дэмжвэл цөөнхийн саналдаа хүндэтгэлтэй хандаж, олонхын зарчмаар шийддэг Үндсэн хуулийн ардчилсан зарчмын дагуу бид цаашаа урагшлах ёстой л гэж бодож байгаа. Энэ бол өөрөө одоо ард түмний сонгож байгуулсан төлөөллийн төв байгууллага, бага ард түмэн. Тийм учраас бид нар асуудлаа энд ярихгүй өөр хаана ярих вэ. Энэ дээр яг ийм цаг үед бас эрх баригчид сөрөг хүчин гэж талцахгүйгээр асуудлыг илүү өргөн цар хүрээгээр харж байгааг би Ардчилсан намынхандаа талархаж байгаа, ХҮН намынхандаа талархаж байгаа. Адьшаа гишүүн ч гэсэн бас өнөөдөр бас энэ асуудлыг ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо Буланы Бейсен гишүүн асуулт асууна аа.

**Б.Бейсен:** Энэ олон улсын хямралт нөхцөл байдалтай холбоотой гаргасан хуулийн төсөлтэй танилцлаа, бас дэмжиж байна аа. Гэхдээ үүнтэй холбоотой хэд хэдэн асуудал тавиад бас саналаа хэлье гэж бодож байна.

Энэ хойд хөршид маань зэвсэгт мөргөлдөөн дайн гараад урд хөршид маань нөгөө ковидын нэгдэл дахиж гарсантай холбоотой эдийн засгийн хямралт байдал өсчхөөд байна л даа. Үүнтэй холбоотой бас энэ хуулийн төсөл дээр зөвхөн мах, гурил, шатахуун гээд оруулсан байна. Сая Чинбүрэн гишүүн бас ярилаа. Энхтүвшин гишүүн ярилаа. Энэ дээр эм, эмнэлгийн хэрэгслийн асуудлыг бас энд оруулахгүй бол зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл гээд байгаа. Үүнийг бас ялгаад бэлдэхгүй зарим төрлийн одоо хүнд хагалгаанууд байж байгаа. Гэмтлийн гаралтай бусад яаралтай хагалгаанууд, төлөвлөгөөт хагалгаанууд энэ нь тасалдаад хүрч байна. Үүний одоо нөөцийг бүрдүүлэх асуудал дээр анхаарахгүй бол бас болохгүй байна аа. Эрүүл мэндийн сайд үүний нөөц хэр байна.

Нөгөө талаар гадуур одоо хүүхдийн антибиотик гээд байхгүй болчихсон байна. Зарим зайлшгүй шаардлагатай эм тасалдсан байна. Энэ дээр аптек дээр түр вуулаад одоо том агентлаг байгуулагдсан, эм, эмнэлгийн хэрэгслийн агентлаг энэ судалгаа хийх шаардлагатай. Судалгаа хийх шаардлага гаргасныхаа дараагаар аль нь дутагдалтай байна гэдгийг Нийгмийн бодлогын байнгын хороо, Засгийн газарт танилцуулах шаардлагатай. Энэ талаар судалгаа хийсэн үү? Хийгээгүй байвал үүний судалгааг заавал хийх шаардлагатай байна аа.

Энэ эрүүл мэндийн салбар, боловсролын салбарынхны цалин бас хүрэлцээ муу байна. Яагаад гэвэл өргөн хэрэглээний барааны үнэ 2-3 дахин нэмэгдсэн, хүнсний бүтээгдэхүүн нэмэгдсэн. Энэ ковид эдийн засгийн хямралт байдалтай холбоотой. Үүнийг нэмэх үү, Ерөнхий сайд аа, уг нь гүйцэтгэлээр санхүүжүүлнэ гэсэн. Гэтэл бодит байдал дээр тэр юуны эмийн өсөлттэй тухайн холбоотой байна. Илүү орон тоотой холбоотой байна уу? Үндсэн цалин нэмэгдээгүй. Ковидын улаан бүсэд ажилласан улсууд л нэг цалин бас өндөр авч байгаа юм байна. Жинхэнэ

ажиллаж байгаа улсууд нь цалин тэгшсэн байна. Одоо гучин хоёр жил ажил эмч, 1 жил ажилласан эмчтэй ижилхэн цалинтай болсон байна. Энэ асуудал дээр анхаарч шийдэхгүй бол бас болох асуудал гарч байгаа юм байна аа.

Өвчтөн тээвэрлэлтийн асуудал байгаа. Одоо энэ Аэро Монгол баруун алслагдсан аймгууд дээр өвчтөн тээвэрлэхгүй байна. Нэг талын зардал 499 мянга, 500 хүрчихсэн байна. Нөгөө цалин нь 500 хүрэхгүй бол зарим нь 500-700 мянган төгрөгийн цалин авч байна. Энэ тээвэрлэлтийн асуудал дээр яж анхаарах вэ? Газраар тээвэрлэж байна. Зарим нь одоо тээвэрлэх боломжгүй юм дээр ях вэ, яж шийдэх вэ гэдэг асуудал байна.

Хөдөө аж ахуйн сайдаас энэ хүнсний ногоо, тариалалтын асуудал дээр дотооддоо бас зарим байцаа, төмс, лууван, бусад хүнсний ногоо тариалах боломж байна л даа. Энэ ковидын юуг ашиглаад дотооддоо хангах, ер нь цаашдаа ямар боломжтой гадаадаас импортлохгүйгээр, энэ тал дээр төсөл хөтөлбөр, хэчинээн хэмжээний одоо төсөв хөрөнгө тавьж байна. Одоо Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, хуучин төмс тариалаад Орос руу экспортод гаргаж байсан. Гэтэл энэ дээр юу ч тавигдаагүй байна аа, энэ дээрээ би одоо учлаарай, сая эрүүл мэндтэй холбоотой байлаа, танилцаагүй байж болно. Энэ тал дээр нэг тодорхой хариулт өгөхгүй юу?

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Засгийн газраас оруулж ирж байгаа хууль дээр өөрчлөлт оруулах нь бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал аа. Тийм учраас эрхэм Их Хурлын гишүүд та бүхэн маань яриад хэлэлцэн шийдвэрлэнэ биз дээ. Би зүгээр бодит боломж яагаад зөвхөн энэ З бүтээгдэхүүнээр Засгийн газар оруулж ирсэн юм бэ гэдэг үндэслэлээ л тайлбарлаж байгаа юм.

Энэ тээвэртэй холбоотой асуудлыг тэмдэглэж авлаа. Би нэг ойрын үед судалж үзээд хариу арга хэмжээ аваад явъя. Эмч нар болон одоо төрийн албан хаагчдын цалинтай холбоотой асуудлууд байж байгаа. Гэхдээ бид нарын хувьд одоо яг үнэндээ бас боломж одоо байхгүй л байж байгаа. Зүгээр одоо энэ шинэчлэлийн бодлогын хүрээнд гүйцэтгэлээрээ тулгуурлаад нийгмийн даатгалын сангаас санхүүждэг ийм тогтолцооны шинэчлэл рүү бид нарын хувьд бол орсон. Энэ зарим газраа их сайн хэрэгжиж байгаа асуудлууд байна. Тэр Яармагийн эмнэлэг дээр очсон, одоо тэд нар бол бүр ашигтай ажиллачихсан орон сууц барих тухай ярьчихсан сууж байна лээ. Зарим эмнэлгүүд дээр бас асуудал үүсээд байх шиг байгаа юм. Тэгээд энэ шинэ тогтолцоо руу шилжиж байгаа учраас бас мэдээж энэ дээр дахиж ярих асуудлууд гарах байх. Би Сангийн сайдад уржигдар чиглэл өгсөн. Эрүүл мэндийн сайдтай бас би ярьсан байж байгаа. Энэ доголдол үүсээд байгаа эмнэлгийн байгууллагууд дээр нэн даруй арга хэмжээ аваад тогтолцооны энэ шилжилтийн үе гэдгийг бодож та хэд анхаарахгүй бол болохгүй ээ гэдэг дээр Ерөнхий сайдын хувьд бол ийм чиглэл өгөөд явж байгаа. Цаашдаа энэ боловсрол, эрүүл мэндийн салбарт гарч байгаа энэ гүйцэтгэл дээр тулгуурлаж байгаа асуудал маань ер нь бол цалинг илэрхий одоо нэмэгдүүлэх ийм л бодлого. Тэгэхээр энэ шинэчлэлийн бодлогоосоо бол ухраад бол хэрэггүй байх. Тэгээд энэ асуудлуудаа ярих байх. Ер нь ях вэ дээ, Монгол Улс нэг би одоо байнга ярьж байгаа. 40 орчим их наяд төгрөг төвлөрүүлдэг ийм дотоодын нийт бүтээгдэхүүнтэй улс. Түүний нэг гуравны нэг нь бол улсын төсөв дунджаар авч үзвэл, түүний нэг 85-90 орчим хувь нь урсгал зардал. Тийм учраас нэгөө урсгал зардал нэмэгдэхээр өөрөө энэ одоогийн байгаа эдийн засаг маань даахад их хүндрэлтэй ийм төвөгтэй байдал

үүсээд л тэгээд л ингээд явчихдаг. Тийм учраас бид нар одоо эдийн засгаа л болж өгвөл тэлж, нэг 40 орчим их наядын эргэлтийг нэг 80 руу ч юм уу, болж өгвөл 100 руу ч юм уу оруулж экспорт тоо дэмжиж нэмж чадвал бид нар олон асуудлыг шийдэх ийм одоо өргөн боломж бол гарна аа. Гэхдээ энэ бол нэг их тийм хол биш. Мэдээж өнөөдөр одоо ковидтой, бас зэвсэгт мөргөлдөөн, дайн тулаантай амаргүй цаг үе байгаа ч гэсэн ер нь бас та бидний хамтдаа ярьдаг томоохон төслүүдийн 70 орчим хувь, ямар нэгэн байдлаар санхүүжүүлэх эх үүсвэрүүд болон хэрэгжүүлэх механизм, мөн техник эдийн засгийн үндэслэлүүд бол бэлэн болж байгаа гэдгийг бас та бүхэнд хэлэх нь зүйтэй байх. Тийм учраас ээлж өэлжээр оруулаад, нээлттэй, ил тод энэ төслүүдийг хэрэгжүүлээд маш хурдтай явах ийм график төлөвлөгөөтэй ажиллаад явж байгаа. Ерөнхий сайдын хувьд бол ажлын цагийнхаа дийлэнх хэсгийг яг энэ том төслүүд дээр л төвлөрүүлсэн байдлаар одоо фокусалж ажиллаж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье ээ гэж бодож байна.

**Г.Занданшатар:** 95. Сэрээжавын Энхболд Эрүүл мэндийн сайд тодруулж хариульяа.

**С.Энхболд:** Бейсен гишүүний асуултад хариульяа аа. 2021 оны 01 сарын 01-нээс эхлэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Эм эмнэлгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газар гэж агентлаг өнөөдрийн байдлаар 132 хүний орон тоотойгоор бол үйл ажиллагаа явуулж байна. Энэ байгууллагын одоо үндсэн чиг үүрэгт бол ялангуяа эмийн нөөц, ялангуяа энэ эмийн үнэ дээр зохицуулалт хийх гэсэн гол үүрэг чиглэл байдаг. Энэ байгууллага бол өнгөрсөн хугацаанд бол тогтмол энэ Монгол Улсад оруулж ирж байгаа болон экспортлох эм дээр бол байнга судалгаа хийж нөөцийг бүрдүүлэх тал дээр бол онцгой анхаарч ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар надад өгсөн мэдээллээр 04 сарын 04-ний өдрийн мэдээллээр Монгол Улсад вирусийн эсрэг юм бол 6 нэр төрлийн эм 6 сарын нөөцтэй, нянгийн эсрэг эм 9 нэр төрлийн 1-5 сарын нөөцтэй, амилуулах тусламж үйлчилгээний 5 нэр төрлийн юм бол 14 хоногоос 12 сарын нөөцтэй, дуслын шингэн шинж тэмдгийн эсрэг 10 нэр төрлийн эм бол бас ингээд 5 сарын нөөцтэй. Тариур, дуслын систем гэх мэтчилэн 22-74 хоногийн нөөцтэй гээд энэ бүх нөөцийн судалгаанууд бол байгаа. Тэгэхээр цаашид ч гэсэн бид нар үүнийг тогтмол хийж байгаа. Хамгийн гол нь энэ сая бас яг ид ковидыг ид ачаалалтай гуравдугаар давлаганаы үед бол Засгийн газраас бас тусгай төсөв гаргаж шаардлагатай эм тарианы нөөц, түүхий эдийг бол БНХАУ болон Солонгос улсаас бол онгоцоор тээвэрлэж авч ирсэн. Энэ онгоцны төлбөрийг бас улсын төсвөөс гаргаж ингэж зохицуулалтуудыг бол хийсэн. Үүнээс цаашид бас бид нар бас энд бас давхар зохицуулалтуудыг хийж, ялангуяа Замын-Үүдийн юун дээр бол энэ Эм зохицуулалт хяналтын агентлагаас бол тогтмол 1 хүнийг байршуулж энэ тээвэрлэлт татан авалт дээр бол онцгой анхаарч ажиллаж байгаа.

Мөн энэ бид нар бас энэ Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас судалгаа авч, ялангуяа энэ эргэлтийн хөрөнгийг зээл олгох байдлаар Монголбанктайгаа бас хүсэлтүүдээ өгч ярилцсан байгаа. Энэ дээр 39 байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас 45 тэрбум төгрөгийн одоо Репо зээлийн хүсэлтийг өгсөн. Хэрвээ энэ зээл олгогдох юм бол ялангуяа нэг ханган нийлүүлэх байгууллагууд 6 сараас 1 жилийн хугацаатай бас ингэж нөөц бүрдүүлэх ийм боломж байна аа гэдэг ийм чиглэлийг бол өгсөн. Энэ үндсэн дээр Монголбанктай ярилцаад бас энэ нарийвчилсан судалгаануудыг гаргаад өгчихсөн байгаа. Энэ орон үед бас шийдэгдэх байх.

Тэр эрүүл мэндийн байгууллагын ажилчдын цалин дээр та бас сая хэллээ. Сая бид нар бол 03 сарын 09-ний Засгийн газрын хуралдаан дээр энэ эрүүл мэндийн ажилтны TYM болон төр төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод жишгийг тогтоож өгсөн. Эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилт буюу нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжээд жил гаран хугацаа өнгөрч байна. Ялангуяа энэ сая ковидын үед эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт бол бас тодорхой хувиар нэмэгдсэн ийм судалгаа бол гарсан. Ялангуяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт өмнөх онтой харьцуулахад 20 хувиар нэмэгдсэн ийм дүр зураг гарсан байгаа. Сая ингээд Засгийн газрын тогтоолоор доод жишиг тогтоогоод өгчхөж байгаа. Энэ маань өөрөө дээшээ тухайн ажилтан хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх ийм боломж бололцоо нээгдэж байгаа. Та сая бас хэллээ, ингээд олон жил ажиллахисан эмч шинээр орсон эмчийн цалингийн ялгаа алга байна аа гэж байгаа юм. Бид нар цалингийн доод жишгийг тогтоож өгсөн бусад урамшуулал, төрд ажилласан жилийн нэмэгдэл эд нар бол ингээд үүнийгээ дагаад өсөж байгаа. Мэдээж 20 жил ажилласан хүн бол төрд ажилласан нэмэгдлээ 20 хувиар тооцод авах боломжтой. 5 жил ажилласан эмч нь 5 хувиараа нэмэгдээд авах ийм зохицуулалт нь энэ хуульдаа байгаа учир ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн асуулт асууна.

**Т.Аюурсайхан:** Энэ дэлхий нийтийг хамарсан инфляц бол яах аргагүй энэ цар тахал, тэгээд үргэлжлүүлээд энэ олон улсад үүсээд байгаа хурцадмал байдлаас бий болж байна л даа. Тэгэхээр энэ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулж иргэдийн худалдан авах энэ чадварыг нь хамгаалах асуудал бол зайлшгүй хийгдэх ёстай асуудал аа. Тэгээд энэ бол нэн яаралтайгаар хийгдэх асуудал бол мөн. Тэгээд би энэ асуудал дээр нэг хоёр асуудлыг хөндөхийг хүсэж байна аа.

1 дүгээрт, энэ үнэ тогтвортжуулах хөтөлбөрийг бид нар өмнө нь бас хэрэгжүүлсэн юм 2012 оноос 16 он хүртэл. Тэр үед болбол Монгол Улсын Ерөнхий сайд, Монголбанкны Ерөнхийлөгч 2 гарын үсгээ зураад хэрэгжүүлсэн бол одоо бол Улсын Их Хурал хуулийг нь батлаад хэрэгжүүлэх гэж байгаа зарчмын том ялгаа мөн л дөө Ерөнхий сайд хэллээ. Гэсэн хэдий ч үүний цаана хэрэгжүүлж байгаа арга хэлбэр болон үүнийг хүртэж байгаа хүмүүс нь ижилхэн байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас би юу гэж хэлэх гээд байна гэх юм бол энэ өмнөх хөтөлбөрөө дүгнэх хэрэгтэй. Үүнийгээ хаах хэрэгтэй. Үүнийг одоо хүртэл хаагаагүй байгаа. 4,8 их наядын одоо төрийн дэмжлэг, нэн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Үүнээс яг хэдэн хувийг нь эргэж төлсөн бэ? 1 дүгээрт Лхагвасүрэн дарга аа,

2 дугаарт энэ зээлийг эргэж төлөөгүй, зориулалт бусаар ашигласан, нэгдүгээрт эргэлтийн хөрөнгөөр ашигласан, хоёрдугаарт барилга байгууламж барьчихсан, гуравдугаарт улс төрд нөлөө бүхий этгээд хамаарал бүхий компанидаа авчихсан, барилга дээр хүнсний энэ бүтээгдэхүүн дээр, зөндөө юм байгаа шүү дээ. Тэгээд үүнийг Үндэсний аудитын газар дүгнээд гаргачихсан. Нэр устай нь, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, би даргаар нь ажиллаж байхдаа гаргачихсан, бэлэн байж байгаа, ямар хариуцлага тооцох юм бэ? Энэ хариуцлага тооцохгүй болбол ингэж одоо завшиж болдог юм байна, зарцуулж болдог юм байна гэсэн юм чинь арилахгүй. Үүнийг зөв хийхийн тулд, хуулийн дагуу хариуцлагатай хийхийн тулд өмнөх юмыг нь хариуцлага тооцож байж дараагийн юм явах ёстай. Тэгэхгүй бол төрөөс бодлого явуулдаг, доогуур нөхдүүд нь бужигнуулаад эргээд улс төрчид хариуцлага хүлээдэг, улс төрийн нам нь одоо нэр

хүндэд нь одоо суурь суудаг ийм л асуудал явна шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ одоо би энэ асуудал дээр онцгой анхаарал хандуулмаар байна аа.

2 дугаарт болохоор энэ нөхцөл байдал болбол өмнөөс явж байсан зөвхөн олон улсын хурцадмал нөхцөл байдал биш, энэ улс орнууд чинь ковидоос болоод протекшн бодлогууд явуулж байсан ойлгомжтой бүгд дотооддоо үйлдвэрлэе. Бүгд хамааралгүйгээр одоо эдийн засгаа явуулья, манай улсын хувьд тийм боломж байхгүй шүү дээ. Тэгэхээр манай улс яах вэ, валют хэрэгтэй, төгрөг нь үнэ цэнтэй байх ёстой. Тэгээд төсөв хэлэлцэх үед мөнгөний бодлого дээр бас зөндөө л ярьж байсан даа. Энэ хөгжиж байгаа улсууд, хөгжингүй улсууд АНУ бодлогын хүүгээ өсгөнө шүү дээ. Инфляциаас болоод тэгээд л яг хэлсний дагуу энэ чинь 2018 оноос хойш анх удаагаа энэ өнгөрсөн сард холбооны нөөцийн сан АНУ-д бодлогын өсгөчихлөө шүү дээ. Эргээд яах вэ, валютын ханш өснө, төгрөгийн ханш унана, төгрөгөө яаж хамгаалах юм. Тэгээд одоо баруун солгойгүй зээл аваад л одоо ингээд зээлийн хязгаартаа ингээд тулгачхаж байгаа юм, цухуйлгаад. Тэгэхээр тэр Засгийн газарт одоо юу төгрөгөөр үнэт цаас гаргах, бонд гаргах ямар боломж байна вэ? Уул нь энд нөөцийг нь хадгалаад энэ тохиолдолд төгрөгөөр үнэт цаасаа гаргаж байдаг. Төгрөгийнхөө эрэлтийг нь нэмж байдаг. Монголбанк бодлогын хүүгээ инфляциын түвшинтэй ойртуулмаар байна. Хадгаламжийн хүү өсөж төгрөгийн эрэлтийг нь нэмэгдүүлмээр байна. Эргээд яах вэ нөгөө зээлийн хүүг бууруулах, бидний одоо явж байгаа бодит ажил, тодорхой хэмжээгээр сэв суух ч гэсэн энэ нөгөө 10 их наядын бас хөтөлбөр хэрвээ зорилтот бүлэгтээ хүрч чадаж байгаа юм болбол бас тодорхой зээлийн бид нар бодлогыг бас давхар аваад л явж байгаа шүү дээ. Тийм учраас энэ бодлогыг дэмжмээр байна, авч хэрэгжүүлмээр байна.

Үүний дараагаар валютын хадгаламж дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Валютын хадгаламж дээр би одоо өөрийн чинь өмнөх Монголбанкны Ерөнхийлөгч дээр удаа дараа хэлж байсан. Энэ валютын хадгаламжийг хязгаарлай аа, валютаар орлогоо олдоггүй л юм бол хувь хүн, хуулийн этгээд тэр хадгаламжийг нь хязгаарлах хэрэгтэй шүү дээ ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт хангалтгүй бол авна. Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Аюурсайхан даргатай санал нэг байна аа. Ер нь бид нар арга хэмжээ авдаг, нэгдүгээрт Их Хурлаасаа нууж арга хэмжээ авах гэж байгаад бурууддаг байсан нэг ийм жишиг байгаа юм. Энэ бол ингээд цаашдаа Их Хуралдаа илүү нээлттэй, олон талаас нь ярьдаг ийм жишиг рүү одоо орох нь бол хамгийн зөв зүйтэй зүйл юм аа гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, яг үнэндээ тэгээд манай улс төрчдийн шуналаас л болж байгаа зүйл шүү дээ. Одоо энэ Хөгжлийн банктай холбоотой асуудал гээд л нэг ийм асуудал үүслээ. Зөв зүгээр гаднын мэргэжилтэн мэргэжлийн ТУЗ бүрдүүлээд байж байхад нь тэгээд л нөгөө бонд босгосны дараа бүх сайдууд ороод л, тэгээд л хуваагаад л авчихсан юм байна лээ шүү дээ, ер нь бол. Тэр Засгийн газрын тогтоол дээр тов тодорхой байж байгаа. Тэгээд өнөөдөр ямар зүйлд хүрэв ийм л зүйлд орчоод байж байгаа. Тэгээд энэ дээр хуулийн дагуу арга хэмжээнүүд авагдах байх. Одоо цаашаа Эрдэнэс Монгол-той холбоотой асуудлыг бас Их Хуралд олон нийтэд нээлттэй бас гаргаж тавих асуудлууд байна гэж үзэж байгаа. Хөдөө аж ахуйн сайдад би хэлсэн байгаа. Тэр нөгөө сангүүд байгаа, тийм ээ, сангүүдтай холбоотой бас манай улс төрчид гарч ирэх л юм байна лээ. Тэрийг нь

би одоо бас олон нийтэд бэлдээд наадахаа зарла гэж байгаа юм. Тэгээд ийм юманд одоо оролцохоо л больчихмоор байгаа юм. Тэгээд л асуудал шийдэгдэж байна шүү дээ. Тэгээд олон нийтийн ёс зүйн шаардлага, олон нийтийн хараа хяналт, манай хэвлэл мэдээллийнхэн ч гэсэн 4 дэх засаглал бас их сайн ажилладаг болж байгаад би их талархалтай байгаа. Одоо тэгээд нэр хүндээ бодоод улс төрч байх уу, эсвэл бизнесмен байх уу гэдгээ шийдэх л цаг болж байна л даа. Ийм л зүйл рүү олон нийт өөрөө шахаж байна. Ардчилал төлөвшиж байна гэж харж байгаа. Шинэ 30 жил өхөндж байна. Тийм учраас илүү нээлттэй, ингээд хянаад өмнөх зүйлээ дүгнээд, шаардлагатай бол хариуцлага тооцоод, гэхдээ мэдээж одоо цаг үеийн ийм асуудал дээр Улсын Их Хурал, Засгийн газар шийдвэрээ гаргаад л явах нь зүйтэй л болно л доо. Тэгж байж л бид нар өмнөө тавьсан, дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа хэрэгжүүлээд явна. Тийм учраас Улсын Их Хурлаас хуулиар одоо хяналт шалгалтын том эрх, үүргийг Үндсэн хуулийн дагуу хэрэгжүүлдэг болсон. Бүх асуудал руу одоо нээлттэй оролцох ёстой. Ингээд л хамтдаа хэдүүлээ хариуцлагаа тооцоод л орооцолдсон нөхдүүдийг нь одоо олон нийттэй хамт улс төрөөс шахаж гаргаад л явчихвал тэгээд л дороо л цэвэршинэ шүү дээ. Манайх ямар нэг тийм олон парламентын гишүүнтэй ч биш, олон оролцогч байгаа ч биш. Хэдхэн л хүмүүс байж байгаа. Тийм учраас энэ дээр бид нар одоо өөрсдөөсөө өхлээд ингээд үлгэр жишээ үзүүлээд өмнөх асуудал дээрээ хариуцлага тооцоод, цаашдаа хянаад явчихвал юм цэгцрэх болов уу л гэсэн ийм бодолтой байж байгаа. Энэ дээр ч гэсэн Ерөнхий сайдын хувьд одоо улс төрийн манлайлал гаргаж ажиллана аа. Авлигын индексийг 2 оронд тоо руу бууруулах тал дээр одоо ахиц гаргаж чадвал хөрөнгө оруулалтын орчинд маш том нөлөө үзүүлнэ ээ гэдэг ийм итгэл үнэмшилтэй байгаа. Нэмээд ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Нэмээд Монголбанк, 83 Бядрангийн Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

**Б.Лхагвасүрэн:** Аюурсайхан гишүүний асуултад хариульяа. 2012-16 онд одоо тэр хэрэгжүүлсэн үнэ тогтвортжуулах гээд хөтөлбөрийн хүрээнд бол тэр хөтөлбөрт нь бол Монголбанкны зүгээс бол олон улсын хөндлөнгийн аудит оруулсан. Кэй Пи Эм Жи гэж хөндлөнгийн аудитын компаниар бүх дүнг нь бол гаргуулж юу болсон бэ, ямар арга хэмжээ болсон бэ гэдэг дүгнэлтийг нь гаргуулсан байгаа. Тэгээд ч энэ хөндлөнгийн аудитын дүгнэлтийг бол олон улсын байгууллагууддаа ч гэсэн хүргүүлсэн. Нийт Кэй Пи Эм жи-ийн гаргасан дүгнэлтээр бол нийт энэ хөтөлбөрийн хүрээнд бол 7,2 их наяд төгрөгийн ийм хөтөлбөр хэрэгжсэн байна аа. Тэгээд тэр дотроо бол үнэ тогтвортжуулах, ипотекийн зээл гээд л “сайн хашаа”, “сайн хувьцаа” гээд маш олон ийм хөтөлбөрүүд зэрэг зэрэг явсан. Mash хөнгөлөлттэй хүйтэй зарим хүн, зарим нь бол бүр 1 хувийн хүйтэй ч ийм зээлүүд гарсан байгаа.

Үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд бол Монголбанкнаас гаргасан нийт санхүүжилтээ бол буцаагаад авсан. Гэхдээ тэр хөтөлбөр бол амжилттай явсан гэсэн үг биш. Яагаад гэвэл банк руу нь олгоод болсон учраас банкнаасаа буцаагаад төлүүлж авсан байгаа. Тэгэхээр бол банкан дээрээ цаад зээл нь төлөгдөөгүй үлдсэн бол тэр банк нь өөрөө түүнийг бол одоо хохирол алдагдал болж хүлээсэн. Үүний хамгийн том жишээ нь бол Капитал банк байгаа. Капитал банк үнэ тогтвортжуулах хөтөлбөрт орж байсан. Тэгээд Монголбанк өөрөө эх үүсвэрээ татаад авчихаар Капитал банк өөрөө нөгөө санхүүгийн төлбөрийн чадваргүй болоод л ингээд л харьцангуй. Тэгэхээр ерөнхийдөө бол яг үнэ тогтвортжуулахаар олгосон санхүүжилтээ бол Монголбанк өөрөө буцаагаад авсан.

**Г.Занданшатар:** Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн тодруулж асууя, 1 минут.

**Т.Аюурсайхан:** Засгийн газар нөгөө төгрөгөөр үнэт цаас гаргах цаг нь мөн үү гэвэл бас мөн шүү дээ. Эсвэл одоо ойрын саруудад үүснэ, тийм ээ, дунд хугацаанд энэ хямрал чинь үргэлжлэх нь л дээ. Тэгэхээр ийм орон зай хэр байна аа? Сангийн сайд аа,

Хоёрдугаарт, Ерөнхий сайд аа, энэ өмнөх үнэ тогтвортжуулахаар гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийн жагсаалт нь байгаа. Эд нарт ерөөсөө дахиж дэмжлэг өгч болохгүй. Тийм учраас энэ бол хариуцлагын нэг хэлбэр мөн. Үүний дараагаар та нөгөө валютын хадгаламж дээр хариулсангүй валютын хадгаламжийг яаж хязгаарлах юм бэ? Валютаар орлогоо олдоггүй л бол аж ахуйн нэгж, иргэн валютын хадгаламжтай байх ямар хэрэг байна? Түүний одоо татварыг нь өсгөдөг, эсвэл валютын хадгаламж нэмэгдэх тусам энэ банкны харьцаа үзүүлэлтийг нь одоо багасгадаг, муутгадаг ийм зохицуулалтуудыг авах хэрэгтэй шүү дээ. Төгрөгийн хадгаламжаа эсвэл дэмжих эсвэл үнэт цаасны зах зээлийг дэмжих. Ингэж байж валютаас хамааралгүй зах зээлээ дэмжиж байж энэ хямралтай ч бас уялдаж явна шүү дээ.

**Г.Занданшатар:** 83 Бядрангийн Лхагвасүрэн тэр юуг гүйцээж хариулья.

**Б.Лхагвасүрэн:** Ерөнхийдөө одоо бодлогын хүү маань 9 болчихсон учраас Засгийн газраас дотоодын үнэт цаас гаргах юм бол энэ 9 хувийн орчимд л гарагаас өөр замгүй. Яагаад гэвэл төв банкны үнэт цаасан дээр 9 хувиар байршуулах учраас. Тэгэхээр зүгээр Сангийн сайд бол энэ дээр бас хариулах байх гэж бодож байна. Яагаад гэвэл Засгийн газар өөрөө үнэт цаасаа гаргахаа өөрөө шийдвэрээ гаргаад явдаг учраас.

Төв банкны зүгээс бол мэдээж Засгийн газартай хамтраад хүүг нь буулгах ямар боломжтой байна. Банкууд дээр байгаа чөлөөт эх үүсвэрийг тэр Засгийн газрын үнэт цаасанд шилжүүлэх асуудлыг бол хамт дэмжээд шийдээд явах боломжтой байгаа.

Валютын хадгаламжтай холбоотойгоор Монголбанк бол өнгөрсөн оны намраас эхлээд энэ валютын долларжих үзэгдэлдээ нэлээн бас арга хэмжээгээ аваад явж байгаа. Төгрөгийн одоо эх үүсвэр дээр нь заавал байлгах нөөцдөд тооцоотой 9 хувиар тооцож байгаа. Харин валютын заавал байлгах нөөцийг 15 хувиар тооцож байгаа. Тэгэхээр хэрвээ банк нь өөрөө валютын эх үүсвэр татаж харилцах хадгаламж ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулья. Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан, Сангийн сайд.

**Б.Жавхлан:** Аюурсайхан гишүүний асуултад нэмж хариулья аа. Энэ жил бид батлагдсан төсвийнхөө хүрээнд 2 их наяд төгрөгийн хүртэл Засгийн газрын үнэт цаас гаргах боломжтой байгаа. Шаардлагатай бол 2 их наяд төгрөг. Энэ хуультай холбогдуулж нэмэлт эх үүсвэр болон ер нь бол ер нь бид зарчим аль болох мөнгөний нийлүүлэлтийг нэмэхгүйгээр мөнгөний бодлогын хатуу төлөвийнхөө энэ орчинд одоо зохицуулж бодлогын шийдлүүдийг гаргаад явъя гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл төсөв дээр бас нэмэлт ачаалал гаргахыг бол үгүйсгэхгүй. Тийм учраас энд бол би хэмжээ заагаагүй. Засгийн газрын үнэт цаас

Засгийн газрын баталгаа гэж тодруулж оруулсан юм байгаа шүү. Засгийн газрын баталгаа. Өөрөөр хэлбэл төв арилжааны банкууд өөрсдийн эх үүсвэрээрээ, тухайлбал одоо том таталт авалт, импорт хийдэг шатахууны компаниуд, нөгөө банкны хязгаарлалт нь 20 хувь зээлийнхээ түүнийг хэтрэхээр болбол хэтэрсэн тэр хэмжээнд ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна.

**Ж.Ганбаатар:** Иргэд, аж ахуйн нэгжүүд өрөнхийдөө юу хүсэж байгаа вэ гэхээр тайлбар бас сонсохыг хүсэхгүй байгаа юм аа. Дайн байлдаан ч гэдэг юм уу, ковид ч гэдэг юм уу, хил хаалттай гэдэг асуудлыг бол одоо та нар шийдчихсэн байх ёстой шүү дээ. Та нар үүний төлөө ажиллаж байгаа биз дээ, гүйцэтгэх засаглал, Их хурал, Эдийн засгийн байнгын хороо, Сангийн яам, Монголбанк тэгээд их тайлбар бол нэг их сонсохыг хүсэхгүй байгаа юм. Тэгэхээр бид одоо яаж энэ ард иргэдийнхээ амьдралыг хэвийн болгох вэ? Ядаж одоо өмнөх оны одоо 10, 11 сар шиг болгох вэ гэдэг талаар л одоо бас нэг бодитой хариултуудыг өгөөд явах нь л одоо гол асуудал байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт одоо инфляцыг яаж тогтоон барих вэ? Хэрэглээний үнийн индексийг яаж одоо бид тогтоон барих вэ гэдэг зүйл, хоёрдугаарт гол тулгамдаж байгаа асуудал байна аа. Мөнгөний бодлогыг чангараулаад явчихсан тохиолдолд сөрөг нөлөөлөл маш их байгаа гэдгийг Сангийн сайд мэдэж байгаа. Сая ярианд дурдагдаж байна. Сөрөг нөлөөллүүд нь ажилгүйдэл бий болно. Олон олон төлөвлөсөн ажлууд чинь одоо хумигдана. Төсвийн бодлогоор мөнгөний бодлогоор хийх гэж байсан олон ажлууд чинь одоо хойшоо ухарна, тэгээд үүнийг яаж даван туулах вэ гэдэг асуудал бидний өмнө ирнэ ээ. Тэгэхээр бид өрөнхийдөө өнгөрсөн амьдралдаа дүгнэлт хийгээд үзэхэд бол үнэхээр санхүү мөнгөн дээр замбараагүй байж ирсэн энэ л зүйл байгаа юм. Би яах вэ, өчигдөр Байнгын хороон дээр тодорхой илэрхийлчихсэн учраас үүнийг бас давтаж яриад яах вэ.

Монголбанкнаас нэг, хоёр, гурван зүйл асууя аа. Энэ тан дээр нөгөө энэ чинь юу гэж нэрлэдэг билээ? Үнэт цаасны үлдэгдэл тийм ээ, Монголбанкны үнэт цаасны үлдэгдэл 8 их наяд бараг 10 их наяд руу нэг хэсэг хүрсэн, одоо хэд болчихсон байна аа. Энэ хүү 6,5-9 хувь болсон бодлогын хүү, зээлийн хүү дээр ямар нэгэн өөрчлөлт анхаар анзарагдаж байна уу? Одоо яах вэ? Монголбанк энэ дээр ер нь ямар одоо юу гэж бодож байна? Ер нь бизнес хийгээд хэрэггүй гэж бодож байна уу, үгүй юу, жоохон байж байгаач ээ гэж байна уу? Одоо яг бид нарт бас одоо энэ газар тариалан эрхлэх гэж байгаа, яг өнөөдөр тулгамдчихсан энэ гадаа байж байгаа энэ хүмүүс чинь яг одоо би ер нь яг яах вэ гэдгийг бас төр засгаас асууж байна шүү дээ. Газар тариалангaa хийх үү, ногоогоо тарих уу, барилга байшиঙгаа барих уу, эсвэл яах вэ гэж. Тэгэхээр төр бас энэ талаас нэг ер нь бол яг ийм байна шүү гэдэг талаас нь нэг их тийм тодорхой хариултуудыг өгөх хэрэгтэй байна л даа. Тэгэхгүй бол доллар олдохгүй байна, аж ахуйн нэгжүүд чинь хэвийн гүйлгээ хийх боломжгүй байна. Бүх зүйл тодорхойгүй байна. Тайлбарыг бол бид өгөхдөө болохоор нэг л дайн, хил, гааль, ковид гээд л өгч байгаа. Энэ чинь бүр хуучирчхаад байна л даа. Үүнийг чинь сонсоод тайлбарыг бол одоо бүрэн дүүрэн хүлээж авахгүй л байна.

Тэгэхдээ өнөөдөр энэ хууль бол зөв л дөө. Одоо хийхээс өөр арга байхгүй. Сая Ерөнхий сайд хэлж байна. Хараад суугаад байлтай нь биш хийх ёстой, өшөө ямар байдлаар үүнийг даван туулах вэ, яаж болохгүй бол тэр том том төслүүдээсээ урьдчилаад одоо мөнгө олж ирэхээс өөр арга байхгүй болов уу даа.

Эс үгүй бол одоо гүйж түүж байгаад ч хамаа байхгүй. Түүнийгээ бол зоригтой хэрэгжүүлэх л хэрэгтэй байгаа. Би бол одоо гүйцэтгэх засаглалд хэрвээ ажиллаж байсан бол энэ талаар одоо улаан нүүрээ улалзуулаад л гүйх л байх л даа. Тайлбар тавиад байх биш, хийх ёстой, би хийж чадна аа гээд сонгогдсон бол үүнийгээ хийх л ёстой. Асуултдаа хариулт авчхаад тодруульяа даа, баярлалаа.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ. Улсын Их Хурлын гишүүн асуултад хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Засгийн газар нэг их шалтаглаад байгаа ч зүйл байхгүй. Энээдээр шийдэл л оруулж ирж байна, бодитой ийм нөхцөл байдал үүссэн байна. Олон нийт юу гэж ойлгож байгаа вэ гэдэг бол нэг асуудал. Бодит байдал дээр нөхцөл байдал хүндэрвэл өөр асуудал. Тийм учраас өнөөдрийн энэ хуулийг одоо оруулж ирж байна. Тов тодорхой байр суурь илэрхийлж байгаа гэж ойлгож байгаа юм.

Энэөдрийн үүсэж байгаа нөхцөл байдал мэдээж одоо 100 хувь гэвэл 70 хувь нь бол одоо шууд хамаарахгүй нөхцөл байдал үнэхээр байна л даа. Гэхдээ 30 хувшиа 100 хувь гэж үзвэл үүнийг бид нар гүйцэтгэлээ маш өндөр хувьтай хийх л ийм л сонголт бид нарт үлдэж байгаа юм. Мөн дипломат одоо улс төрийн арга хэмжээгээ маш сайн авч хэрэгжүүлэх ийм л нөхцөл байдал бид нарт бодитоор байна. Гэхдээ миний хувьд Ганбаатар гишүүн одоо асуусан учраас, бас хувийн хэвшилд ажиллаж байсан хүн. Их зөв асуулт хөндлөө гэж бодож байна. Мэдээж нөхцөл байдал хүнд байгаа ч гэсэн бид нар сөрж гарахаас өөр сонголт байхгүй. Тийм учраас би Ерөнхий сайдын хувьд өөдрөг засаглалтай байгаа. Маргааш эдийн засгийн форум болж байгаа ковидын дараа 2 жилийн дараа хийгдэж байгаа бид нар түүгээр үндсэндээ одоо том төслүүдээ яаж урагшлуулах вэ гэдэг шийдлийн талаар хамтдаа ярилцана, гадна дотноос бас зочид төлөөлөгчид их ирнэ.

Оюу толгойн төсөлтэй холбоотой асуудал дээр өр тэглэгдэж, алдаанууд засагдаж, Их Хурал дээр тодорхой шийдэл гарсан бол дэлхийд бас эерэг ийм мессежийг өгсөн. Энэ бол одоо бодитой. Сүүлийн үед хөрөнгө оруулагчид Монгол руу зорьж ирэх байдал нэлээдгүй ихсэж байна. Ялангуяа одоо манай гурав дахь хөрш орнууд баруунаас. Олон төсөл хөтөлбөрүүдийг бас сонирхож байгаа ийм зүйлүүд болж Ерөнхий сайд ч гэсэн их олон уулзалтуудтай байгаа. Тийм учраас мэдээж амаргүй байгаа ч гэсэн бид нарыг бас эерэг харж байгаа. Мөн Монгол Улстай бид нар урт хугацаанд түншлэн ажиллаж болдог юм байна аа гэдгийг хөрөнгө оруулагчид харж Монгол Улс руу зорин ирэх бас одоо хөрөнгө оруулагчдын урсгал идэвхжиж байгаа. Мэдээж одоо валютын нөөц болон бусад асуудал дээр Монголбанк илүү одоо Засгийн газартайгаа хамтраад явахад асуудлыг бас шийдэж болох болов уу гэсэн ийм бодол байгаа.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулаад бас валютын урсгал гадагшлах ийм одоо хөдөлгөөн бол ажиглагдаж байна аа гэдэг зүйлийг бол надад бас холбогдох албаны хүмүүс хэлж байгаа. Энэ дээр бидний хувьд шийдлээ гаргаад ингээд явах боломжтой. Сая Ганбаатар гишүүний хэлдгээр бид нар зарим томоохон хөрөнгө оруулалтууд Монгол Улсын газар нутаг дээр хэрэгжихтэй холбоотой валютын эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлэх асуудал дээр бол ажиллаж байгаа. Ойрын ирээдүйд 4-5 шийдэл бол гарна. Түүнийг би тухайн үед нь хэлэх нь зүйтэй байх аа гэж бодож байгаа. Яагаад гэхээр бүтээгүй юмыг бас хэт урьдчилж зарлаад бас яах вэ. Тийм учраас энэ валютын энэ шоктой холбоотой асуудал дээр Засгийн газрын хийж хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээ бас төв

банканд зохих хэмжээний дэмжлэг болох болов уу гэсэн ийм бодолтой байж байгаа. Байнга бид нар урд хөрштэй холбоотой л байгаа. Бас ихэнх халдвартынх нь дийлэнх нь Өвөрモンголд гарч байгаа ийм нөхцөл байдал байгаад байгаа юм. Харьцангуй ковидын нөхцөл байдал манайд тогтворжсон учраас бас эерэг хүлээлттэй байгаа. Та бүхэн статистик үзээрэй. Хилээр гарч байгаа бараа бүтээгдэхүүний эргэлтийн хамгийн их нь Монгол л байгаа. Одоо бусад боомтуудтай харьцуулахад бид нар тэр статистикийг байнга авч үзэж байгаа юм. Энэ цаашдаа мэдээж ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** 83 Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч хариулья.

**Б.Лхагвасүрэн:** Ганбаатар даргын асуултад хариулья аа. Төв банкны үнэт цаасны үлдэгдэл өнөөдрийн байдлаар 5,4 их наяд байна. Бидний нөгөө анх одоо хувь бууруулах гээд ярьж байсан 10 их наяд байснаас бол ингээд бараг 2 дахин бууучхаад байж байгаа. Тэгээд төв банкны үнэт цаасны хүү ингээд 9 болж өссөнтэй холбогдуулаад мэдээж зээлийн хүү өсөж эхэлж байна, хадгаламжийн хүү ч өсөж эхэлнэ. Нэгэнт 2,5 хувиар алхам хийгдэж байгаа учраас бол зээл, хадгаламжийн хүү дээр бол өсөлт бол энэ 2,5 хувиар л өсөх л ийм л бид нарын төсөөлөл гарч ирж байгаа. Ер нь бол яг ингэж эхэлж байна аа гэдэг одоо түрүүчийн гэрээнүүд хийгдээд эхэлж байгаа гэрээнүүдээс ингээд харагдаж байгаа.

Валютын ханштай холбоотойгоор валютын нөөцтэй холбоотойгоор Монголбанк арилжааныхаа банкнуудтай уулзаад энэ онд одоо гаднаас орж ирэх одоо зээл эх үүсвэрүүд нь хэр хэмжээтэй юм байна аа гээд тооцоо хийсэн. Ямар ч байсан банкууд бол Монголбанктай авч байсан эх үүсвэрээр урт хугацааны своп хэлцэл хийх боломжтой. Тэр нь бол 600-аад сая доллар. Богино хугацаатай своп хэлцэл бол нэг 100 сая доллар, тэгээд олон улсын байгууллагуудаас бас татаж ирэх мөнгө нь 100-200 сая доллар гэж яригдаж байгаа. Тэгээд түрүүн бас Их Хурлын дарга бас тод дурдаж байсан. Ялангуяа манай экспортын томоохон компаниуд Оюу толгой, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс таван толгой гээд эдгээр компаниудын хувьд бол урьдчилсан байдлаар бүтээгдэхүүнээ борлуулах үүднээсээ хэрвээ борлуулж зарах юм бол бас 400-600 сая долларын ийм хэмжээтэй тоо яригдаж байгаа. Тэгэхээр бидний хувьд бол одоо богино хугацаандаа бол ер нь нэг тэрбум доллар орчмын ийм эх үүсвэрүүд татагдаж орж ирэх боломжтой тэр хэмжээгээр нөөц нэмэгдэнэ. Энэ нь өөрөө бол ханшийн тогтвортой байдалд бол эерэг нөлөөтэй л гэж харж байгаа юм.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Монголбанк тэгээд саяын ярьж байгаа зүйлүүдийг бас ярьж л байх хэрэгтэй л дээ. Хэрвээ үнэн л юм бол. Ийм мөнгө ойрын үед орж ирнэ ээ гэдгээ хэлж байх хэрэгтэй. Тэгэхгүй бол бүх хүн багасаж байна, бууж байна гэдэг мэдээлэлдээ бүр автчихаад байна шүү дээ. Тэгээд Ерөнхий сайд бол энэ цаг үед бол одоо Ерөнхий сайдын ажлыг танаас энэ мундаг хийчих хүн байхгүй л дээ. Тэр бол одоо чи үнэн. Засгийн газрын кабинет нь их зоригтой орж яг зөв зүйлээрээ тэ зоригтой хүн шиг ярьж, одоо өөрсдийгээ салбар болгоноо ойлгуулдаг л байх хэрэгтэй юм болов уу л гэж би харж байгаа шүү дээ. Тэгэхгүй бол тэгээд л бас Ерөнхий сайдад загнуулчих болов уу, эс үгүй бол яачих бол гэдэг юм уу, энэ талын байдлууд чинь сул байгаа, эс үгүй бол Сангийн яам одоо нэлээн санаачилгатай ажиллах хэрэгтэй. Би одоо бүлгийн хурал дээр ч гэсэн хоёр гурван удаа ирсэн. Эдийн засгийн байнгын хороон дээр чинь ярьсан. Оройтож байна аа

гээд. Одоо уул нь бид нар ингээд сөрсөн зүйлүүдийг хоёр гурван удаа хийчихсэн байх л ёстой байсан гэдгийг хэлье. Асуулт асуусангүй ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** Баярлалаа. Үнийн өсөлтийн эсрэг хууль, үнэ тогтворжуулах тухай хууль гэж хэлэлцэж байна л даа. Яг үнэхээр үнийг тогтоочиж болдог болбол одоо үүнээс сайхан зүйл ч гэж юу байх вэ. Гэтэл яг энэ үнийг тогтоох, тогтворжуулах гэдэг оролдлого бүхэн дандаа цаанаа эдийн засгийнхаа системийг дандаа хорлож байдаг, устгаж байдаг. Тэр тусмаа дунд уртыг больё. Бүр дунд хугацаандаа ч гэсэн дандаа л явж байдаг. Одоо жишээ нь яг бодит байдал дээр үнэхээр тогтоочиж болдог болбол энэ Монгол төгрөгийн үнэ цэнийг тэр доллартой харьцах ханшийг тогтоочих л доо. Энэ чинь болохгүй учраас л шууд далд эдийн засаг, хар зах үүсэж байна шүү дээ. Арван хувийн зөрүүтэй. Тэр чинь болдоггүй учраас л цаана нь гэтэл одоо бид нар үүнийг ингээд үнэ тогтоох тухай ингээд л ярилцаж байна л даа. Үндсэндээ зүй нь болбол хүний бие өвчнөөр халуурлаа, халууны шилээ гучин долоогоос дээш заахгүй болгочихъё гэдэг ийм л зүйлтэй л бид нар одоо ярилцаад явж байна. Яг одоо бодит байдал дээр ер нь бүхий л салбарын бараа бүтээгдэхүүний үнэ одоо ямар байна вэ? Энэ нэг ширхэг A4 бичгийн цаас боодол нь нэг 13-15 мянган төгрөг юм байна. Нэг ширхэг нь бараг 30 төгрөг болчож. Энэ 30 төгрөгийг нь нэг A4 цаасан дээр Монгол төгрөгийг нэг нэгтийн төгрөгийг ингээд байршуулахаар 10 ширхэг орж байна. 600 сантиметр квадрат нэг нь 60 сантиметр квадрат, үнэхээр A4-ийн цагаан цааснаас хоёр талдаа үнэт цаас хэвлэсэн Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй Монгол төрийн сүлд соёмботой энэ мөнгөн тэмдэгт хэд дахин ингээд үнэгүйдчихсэн. Яг одоо бодит бид нарын хэн нь ч гэх үү бодит бид нарын одоо байгаа байдал энэ цагаан цааснаас хэд дахин хямд Монголын мөнгөн тэмдэгт. Тэгэхээр одоо эндээс, мэдээж энэ хууль ингээд батлагдаад явах л байх, тэгэхдээ ер нь эндээс бас тодорхой, арай өөр асуултууд байна.

Ерөнхий сайдаас ер нь одоо бид нар олон зүйл ярьж байсан ч явсаар явсаар байгаад энэ үнэ болоод олон зүйл валютын ханш, олон зүйл энэ урд хилээс хамаарах болж таарах байх л даа. Урд хилийг хэзээ нээгдэх, хэвийн горимд хил гааль нь шилжих гэдэг дээр 4 сар гэдэг нэг тоо явж байсан, нэр байхгүй болчихлоо, хэдэн сар, зургаа, найм, арван сар хэзээ хүртэл гэдэг дээр ер нь энэ эдийн засгийн энэ төсөөлөл, арга хэмжээнүүд хийгдэж байгаа вэ? Ямар хүлээлт байгаа вэ?

Хоёрдугаарт нь, эдийн засагт төрийн өмчийн оролцоо, төсвийн оролцоо нийлээд бараг далаад хувь болчихлоо. 2013 онд 260 орчим төрийн өмчит болоод орон нутгийн өмчит аж ахуй нэгж байсан юм байна лээ. Одоо 10 жилийн дараа 400 гаруй болчихсон. Төрийн өмчийн оролцоо жилээс жилд л нэмэгдээд байдаг, мөнгөн дүн нь ч нэмэгдээд байдаг. Хоёр жилийн өмнө Ерөнхий сайд томилогдож байхад төрийн өмчид шинэчлэл хийнэ, олон нийтэд нээлттэй болгоно, хувьчлал хийнэ гэж байсан нь одоог хүртэл үүнээс ямар ч сураг алга. Харин одоо энэ хөтөлбөрүүд үнэ тогтоохоос эхлээд энэ хөтөлбөрүүд чинь улам л төрийн оролцоог цаагуураа нэмнэ. Жилийн дараа одоо үүнийг зориулалтын дагуу зарцуулсан уу, зарцуулаагүй юу, буцаан төлсөн үү, төлөөгүй юу гээд л нөгөө алдарт хэрүүл эхэлнэ. Тэгэхээр энэ зах зээлээ эдийн засгаа арай зөв зүйтэй жам ёсных нь дагуу одоо удирдах төрийн оролцоогоо багасгах та үүн дээр хоёр жилийн хугацаанд үндсэндээ бас эс үйлдэл хийчихлээ. Төрийн өмчит аж ахуйн нэгжид шинэчлэл

хийнэ гэсэн одоо нөгөөдөхөөс нь сураг байдаггүй ээ. Үүн дээрээ бас нэг тайлбар өгөөч ээ.

Дараа нь энэ Сангийн сайдаас яг энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарт эрх өгөөд төсөв шилжүүлэх эрхийг нь хуулиар өгчих юм байна. Нөгөө батлагдсан төсвийн хууль маань яах вэ. Тэгж бид нар бие бие хуурч нэг зүйл заалт нэртэй тэр төсвийн хуулийг үгүйсгэж биш үүн дээрээ одоо тэр төсвийн тодотголоо хийвэл яадаг юм, одоохон ингээд л баахан компаниуд чинь тендерт зарим нь орно, орохгүй, орсон нэг нь тэгээд л наадам өнгөрөөд төсөв нь хүрэхгүй байна, төсвөө нэмүүлнэ гээд л нэг баахан гурвалжин дөрвөлжин юм л одоо болоход л бэлэн болж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр тэр төсвийн тодотгол гэдэг зүйлийг ер нь үүнтэй хамтагж ярих нь өөрөө яг одоо саяын тэр төсвийн шилжүүлэг хүү, татварын хөнгөлөлт, олон зүйл үнэхээр хийх гэж байгаа болбол ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Цогтгэрэл гишүүнтэй би санал нэг л байдаг л даа. Эрчим хүчнийхээ үнийг чөлөөлмөөр л байна, хүнд байна. Таван толгойн тулшийг зах зээлийнх нь үнэ дээр ашиг нэмээд зармаар байна. Төрийн албан хаагчдын одоо тоотой холбоотой асуудал дээр бид нар томоохон ийм реформ хийгдэх ёстай. Тэгээд бид нарын хувьд илүү тийм либералчлах бодлого бариад явах нь бол илүү чухал. Шинэ сэргэлтийн бодлогын гол цөм ч энэ. Та өөрөө үүнийг мэдэж байгаа, олон удаа бас санал солилцож байсан. Гэхдээ өнөөдрийн нөхцөл байдлууд бас бидний бодож байгаатай адилхан шууд ингээд яваад байхад дийлэхээргүй л болчхоод байна л даа. Сая ахмадын тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудал ч гэсэн үнэхээр л одоо амьдрал хүндэрсэн учраас л тэр нөгөө Оюу толгойн гэрээний дараа жоохон эерэг үр дүн гарангут л тэгээд л боломжтой бүх зүйлээ гаргаад л бид нар төсвийн тодотгол хийгээд л өгсөн. Ийм л асуудлууд байж байна. Эрчим хүчний үнэ Тавинбэх сайд байнга нэмье л гэж байгаа юм. Тэгээд нэмэх гэхээр яг энэ цаг үед бас хүнд л байна. Өнөөдөр ч гэсэн мэдээж одоо үл үзэгдэгч гар зохицуулна аа гээд орхичих нь хамгийн зөв шийдвэр л дээ дараа нь асуудал дагуулахгүй гэдэг талаасаа. Гэхдээ дөрвөн сарын өмнө таван сарын өмнө энэ нөгөө эдийн засгийн хориг арга хэмжээтэй холбоотой асуудал дээр мянга мянга таван зуун төгрөгөөр нэмэгдэх нөхцөл байдал руу орчоод байна л даа. Тэгэхээр бид нар аажмаар одоо газардуулах ийм зүйл рүү төр оролцохоос өөр аргагүй л нөхцөл байдалд орчоод байна.

Нөгөө талаараа одоо яг үнэндээ жишээлбэл урд хөршид болж байгаа ковид, хойд хөршид болж байгаа энэ зэвсэгт мөргөлдөөнийг би энд санаснаараа шийдэж чадахгүй байгаад байна л даа. Дээрээс нь энэ төрийн өмчит үйлдвэрийн газар мадагтай холбоотой асуудлууд яригдаж байгаа. Шууд хувьчилна гээд оруулж ирэхээр өмнөх аваад идчихсэн ах нарын асуудал босож ирээд олон нийт итгэхгүй болчхоод байна л даа бас. Тийм учраас үүнийг олон нийтийн хяналтад ямар байдлаар оруулах вэ гээд өмнөх 30 жилийн баасыг цэвэрлэх гэж бас аргаа барж л байна л даа. Тийм учраас бас цаг тодорхой хэмжээнд орж байна, энэ Хөгжлийн банкнаас авахуулаад. Босгосон бондоо аваад тараагаад хуваагаад авчихсан хүмүүсийн хойноос хөөцөлдөх гэж бас цаг орж байна л даа. Ийм л нөхцөл байдал үүсээд байна. Харин ч цэгцлээд явж байгаа гэж байж ойлгож байгаа.

Төрийн өмчит үйлдвэрийн газруудтай холбоотой асуудлууд тун удахгүй Их Хурлаар орж ирнэ ээ. Харин түүн дээр та улс төржихгүй дэмжихийг хүсье. Тэгээд бид нар зөв гэж байгаа зүйл дээрээ улс төржихгүй дэмжээд ингээд явбал Монгол

Улс урагшлах байх аа гэж бодож байна. Бусдыг нь манай сайд нар шаардлагатай бол хариулчихна байх.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл асуултад хариульяа аа. Ер нь зах зээлийнхээ зарчмаар явж байгаа зүйлдээ төр оролцох буруу гэдэгтэй би тантай 200 хувь санал нийлж байна. Харин энэ удаа нөхцөл байдал арай өөр байгаа гэдгийг та бас сайн ойлгож байгаа. Оросын холбооны улсаар дамжиж орж ирж байгаа энэ олон давхар санкцууд шууд бус биш шүү. Шууд замаар бид нөлөөлж орж ирж байгаа юм. Үүнийг одоо зах зээлийн жам гэж та хэлэхгүй байх гэж бодож байна.

Ковидын нөхцөл байдлаас болоод урд хөрш маань хойд хилээ хаачхаад байгааг бас л зах зээлийн ямар болж байгаа зүйл гэж хэлэхгүй байх аа гэж таныг одоо бодож байна. Өнөөдрийг хүртэл бид нар хангалттай төв банкныхаа нөөцийг одоо экспорт хийж зузаатгаж чадаагүй юм байна. Түүний горыг өнөөдрийн энэ үеийнхэн маань одоо энэ хүнд нөхцөл байдалд хатуу амсаж байна гэдгийг одоо та ойлгож байгаа гэж бодож байна. Үүнийх нь одоо хүнд тусгалыг ард түмэнд өнөөдөр шууд зүгээр ингээд ямар ч бодлогын арга хэмжээ авахгүй зүгээр үүрүүлчихнэ гэж байж болохгүй зүйл. Тийм учраас бид нар энэ хуулийн зохицуулалтыг хийж байгаа. Таныг би дэмжин энэ утгаар нь одоо энэ өнцгөөр нь дэмжинэ байх аа гэж найдаж байна.

Тэр тодотголтой холбоотой асуудал. Бид нар 22 оныхоо төсвийг батлаад дөнгөж одоо хоёрдугаар улирал маань эхэлж байна. Өнөөдрийн гурван сарын байдлаар төсвийн гүйцэтгэл ямар ч асуудалгүй явж байна. Үүнийг би бүр нүүр бардам хэлье. Эхний улирлын байдлаар төсвийн орлого 100 хувь биелж гарсан 100 хувь шүү. Гагцхүү АМНАТ-ын орлого дээр нэг жоохон тасарсан. Яагаад гэвэл бид нар түүхий эдийнхээ экспортыг хангалттай хийж чадахгүй байгаа учраас энэ жил эхний улирлын байдлаар одоо 657 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 628 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа. 20 гаран тэрбум төгрөгийн л тасалдалтай явж байгаа. Өмнөх жилүүдийнхээ өрүүдийг төлүүллээ, татварын төлөгдөөгүй байсан хуримтлагдсан өрүүдийг төлүүллээ, том аж ахуйн нэгжүүд маань маш хариуцлагатай ажиллаж ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Яах вэ хуулийг ер нь нэг бүрчлэн харж л байна л даа. Тэгээд бид бүхэн өнөөдөр энэ хуулиар том том асуудал яриад дайн дажин ковид тэгээд хомсдол, валютын хомсдол гээд олон том асуудал ярьчхаад. Яг хууль дээр нэг гурван асуудлыг л бид нар яриад байгаа юм. Нэгд нь мэдээж одоо бензин шатахууны үнийг барих, хоёрт нь гурилын үнийг тогтоох, гуравт нь махны үнийг тогтоох. Энэ асуудлыг ингээд бид нар бүгдээрээ яриад байсан. Нэг наяд онд хүүхэд байхад нэг социализмын үед махандaa очерлож очерлож нөгөө гүя дагуулж хүзүү гээд нэг мах авдаг. Тэгээд нэг гурилтай шөл, цуйван, буузaa холиод иддэг энэ юм руу бид нар явах гээд байгаа юм уу даа гээд бүр тийм бүр бодол надад төрж байна л даа. Тэгээд энэ хуулиудын заалтуудыг харахаар махны үнийг тогтвржуулахад Монголбанкнаас аж ахуйн нэгжүүдэд зээл өгнө гээд байгаа юм. Тэгээд үүнийг би ер нь нэг тодруулаад асуучихмаар байна аа. Яг хэнд өгөх гээд байгаа юм. Яг юунд өгөх гээд байгаа юм, ямар хүмүүс авах гээд байгаа юм. Үүнийг бүр тодруулъя. Тэр махны нөөц бүрдүүлсэн тэр компаниуд өнөөдөр махныхаа үнийг тогтвржуулахад хүрэлцэхгүй байгаа юм уу.

Хоёрт нь гурил. Саяхан хэрэгжүүлсэн 10 их наядын хөтөлбөрөөс газар тариалангийн салбар 190 тэрбум төгрөгийг л авсан байна. Өнөөдөр бас маш их мөнгө шингээдэг салбар маань хүчин чадал нь 190 тэрбум байгаа. Тэгээд өөр одоо бусад ямар хүмүүст энэ мөнгийг өгөх гээд байгаа юм бэ. Ямар хүмүүс тэр мөнгийг аваад үнийг чинь тогтворжуулах гээд байгаа юм бэ? Үүнийг нэг тодорхой хэлээд өгөөч. Мэдээж Монгол Улсын хэмжээнд энэ жил саяхан, өнөөдөр одоо Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр газар тариалангийн талаарх нөхцөл байдлын цаг үеийн мэдээлэл ирсэн. Үрийнхээ асуудлыг бид нар 100 хувь шийдэж байгаа гэсэн мэдээлэл ирсэн байна лээ. Мөн 22,5 мяанган тонн шатахууныг бид нар энэ жил хэрэглэх юм байна гээд ингээд тодорхой мэдээлэл ирсэн. Бүгд боломжоор бид нар нөхцөл байдалд бид нар 100 хувь үүнийгээ өөрсдөө чадна аа гээд ийм мэдээллийг бид хүлээж авчхаад байгаа. Тэгэхээр яг, яг хэн энэ мөнгийг авах гээд байгаа юм бэ гэдгийг бас хэлээд өгчхөөрэй.

Алтан дээр алтыг бид нар тодорхой хоёр нөхцөл тавиад нэг нь таван хувийн одоо татвар байхгүй болно, роялтийг авахыг нь болиулж байгаа юм шиг байгаа юм. Хоёрт нь одоо санхүүгийн жилдээ алтаа тушаагаагүй компаниудыг алтаа тушаах юм бол хариуцлага үүрүүлэхгүй ээ гээд ингээд ийм хоёр заалтаар бид нар алтыг би алттай болоод түүндээ, одоо дүйцүүлэх валютыг бид нар бий болгоно оо гэсэн ийм л нэг заалт орж ирсэн байгаа шүү дээ. Валютын нөөцийг нэмэгдүүлнэ гэдэг дээр. Өнөөдөр дэлхийн зах зээл дээр алдах хамгийн үнэтэй байгаа. Цаашдаа бас өсөх магадлалтай байна. Харин бид нар яаж алтаа олборлох тухай яагаад ярихгүй байгаа юм бэ энэ хууль дээрээ. Бид нар энэ алтыг олборлоход одоо саад болдог маш олон санкцууд байгаа, нөгөө урт нэртэй хууль байгаа. Мөн одоо энэ алтны компаниудын үйл ажиллагааг нь, тэр ажиллах боломжоор нь хангуулах энэ асуудлыг бид нар хууль дээр оруулж ирэх юм бол бид нар алттай болох байх аа. Энэ асуудлууд дээрээ хариулт авьяа аа. Тэгээд ер нь мөнгө хэн авах гээд байгаа юм бэ гэдгийг бүр нэг тодорхой сонсмоор байна. Ард түмэн өнөөдөр Хөгжлийн банк л гэнэ, ЖДУ л гэнэ, тэр үнэ тогтворжуулах өмнөх хөтөлбөр л гэнэ. Хэн нэгэн хүмүүс авчихсан, тэгээд хариуцлага алддаг. Тэгээд нийт иргэд болон бизнесменүүдийн хооронд одоо харилцан адилгүй давуу эрхээс болоод л өнөөдөр нийгмийн хардалт байдаг. Үүнийг л бид нар нээлттэй ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд.

**Л.Оюун-Эрдэнэ:** Гишүүн их зөв зүйл хөндлөө. Тэр өмнө нь байгаа Аюурсайхан гишүүн ч хөндлөө. Тэр хариуцлагагүй байгаа асуудал дээр бол бид нар ингээд маш хариуцлагатай л хандаад явахгүй бол мэдээж ийм амаргүй нөхцөл байдалд ордог. Бид нар тэгээд нэг ийм хэлбэр байдлаар аргалсаар байгаад л бас өнөөдөр ийм зовлонтой л ойр ойрхон нүүр тулаад байна л даа. Нефтийн үйлдвэрээ барьчихсан байсан бол ийм асуудал харьцангуй өөр л байх байсан байх. Хүнсээ бүгдээрээ яг одоо импортлохоо оролддог болчихсон байсан бол арай л өөр асуудал л явах байх. Тэгээд Монгол нэг их том эдийн засагтай биш дээ, дахиад л нэг хэдэн компанийн л нүүр тулах байх. Одоо шатахууны импортлогчид гээд хэдхэн л компани байгаа. Тэд нартай л ярьж таарах байх.

Харин Аюурсайхан гишүүний түрүүний хөндсөнөөр үнэхээр одоо өмнөх удаа ямар нэгэн байдлаар одоо жишээлбэл, хариуцлагагүй хандсан аж ахуйн нэгжүүдийг бол бид нарын хувьд их тийм хатуу хянах нь зүйтэй. Хоёрдугаарт яах вэ, ер нь мэдээж энэ амаргүй зэвсэгт мөргөлдөөн, ийм амаргүй нөхцөл байдал байгаа ч гэсэн энэ дээр илүү их тийм ил тод явах энэ орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Энэ хууль батлагдсаны дараа л одоо Засгийн газар илүү их ширээний ард сууж

ярилцаж эхэлнэ л дээ. Түүнээс эрх зүйн орчин бүрдээгүй байхад бид нар урьдчилж ярина гэж юу байх вэ. Түүн дээр хүсвэл манай Ардчилсан намын гишүүд бас оролцоод хянах талаас нь яваад хамтдаа ил тод ингээд явчхад бол асуудал үүсэхгүй байх аа л гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууна. 94 Загджавын Мэндсайхан сайд мах хэн авах гээд байгаа юм бэ гэсэн.

**3.Мэндсайхан:** Ганибал гишүүний асуултад хариульяа. Энэ мах, гурилын нөөцийг бүрдүүлэх чиглэл рүү бид нар нийлүүлэлтийн тогтвортой байдлыг л хангая гэж байгаа юм. Тэгэхээр энэ чиглэл дээр мах бэлтгэн нийлүүлдэг аж ахуйн нэгжүүд, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгж үйлдвэрүүдтэй арилжааны банкаар дамжуулж тэд нарын эх үүсвэрийг хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр олгоё. Өнгөрсөн онд одоо хэрэгжүүлсэн 10 их наядын хөтөлбөрийн зээлийн хүүгийн зөрүүг нь Засгийн газар олгодог энэ зарчмаар санхүүжүүлье ээ гэж. Түүнээс биш ямар нэгэн аж ахуйн нэгжүүдийг сонгоод мөнгө өгөх гээд байгаа бол асуудал биш. Яаралтай бид нар энэ хаврын тариалалт эхлэх, мөн одоо энэ өнгөрсөн жилийн нөөцийн байх бол 07 сарын 10 гээд бид нар тэр хүртэл нийлүүлнэ. Ингээд шинэ мах гарч ирээд 8 сар гэхэд бид нар нөөцийн махаа бэлдье ээ. Үүнээс өмнө аж ахуйн нэгжүүддээ хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг арилжааны банкан дахь эх үүсвэрээс санхүүжүүлье ээ. Тэр эх үүсвэрийг нь Монголбанк, Засгийн газар хүүгийн зөрүүг нь өгье өө л гэдэг ийм л шийдэл гаргаж байгаа юм.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя, 1 минут.

**Н.Ганибал:** Ер нь тэгээд маш ойлгомжгүй юм. Өнөөдөр махны экспорт бүгдээрээ зогсчихсон. Бид нар өнөөдөр өөрсдөө өөрсөдтэйтгөө тулалдаад, нөөцийн мах бэлдэнэ гээд мөнгө гаргаад тэгээд махны үнийг өсгөөд байгаа шүү дээ. Үүнийгээ ингээд сайн ойлгомоор байна аа. Өнөөдөр адууны мах маань ч бас экспортод гарахгүй болчихсон. Тэгэхээр тэнд одоо тавиад тэрбум тонн мах өнөөдөр зооринуудад хадгалаастай гээд захын нэг ченж яриад байна шүү дээ. Өнөөдөр салбарын яам энэ асуудлуудыг жаахан нухацтай энгийнээр ойлгомоор байна аа. Харин тэр адууны махаар дэлхийн тэр хүнсний хомсдол үүсэх гээд байвал тэр консерв хийдэг эцсийн бүтээгдэхүүн хийдэг тэр юундаа бүгдийг нь өгөөд харин тэр тэнд одоо нийлүүлэлт хийх тэр боломж байвал тэрийг судлаадахаач. Тэгэхгүй эргэж битгий мөнгө гарга л даа. Тэгвэл махны чинь үнэ буурчихна шүү дээ. Дотоодын хэрэглээнээсээ бид нар илүү нийлүүлэлттэй байгаа юм чинь. Тэгэхээр үүнийгээ л зүгээр энэ ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Загджавын Мэндсайхан сайд, 94.

**3.Мэндсайхан:** Мал, махны экспорт, энэ импортлогч орны хорио цээрийн нөхцөл, энэ ковидын нөхцөлтэй холбоотой л гацчихсан байгаа. Тэгэхээр экспортыг нэмэгдүүлэх, нэгэнт экспортын энэ хүндрэлтэй нөхцөл дээр бид нар дотоодын мах бэлтгэлийн аж ахуйн нэгжүүдээ дэмжиж малчдынхаа орлогыг нэмэгдүүлье л гэж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бид нар махны нийлүүлэлтийг тогтвортой болгоё, үнээ тогтвортой байлгая гэдэг бодлого орж байгаа. Тавин тэрбум төгрөгийн юу тавин тэрбум тонн мах байхгүй ээ, тийм байх. Тэр адууны махны асуудлыг бол хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөр шийдчихсэн экспортод гаргах эрхийг нь аж ахуйн нэгжүүддээ өгч байгаа. Бусад махыг нь бол одоо яг экспортод гаргахыг хориглосон байгаа.

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар гишүүн асуулт асууна.

**Ч.Хүрэлбаатар:** Энэ үнэ тогтвортжуулах хуулийн төслийг уншсан. Яг энэ битийн хэлбэрээр бол 2013-2016 онд хэрэгжүүлсэн яг тэр хэлбэрээр бичсэн, бичигдсэн байгаа. Тавдугаар зүйл дээр бол Монголбанк, Монголбанк саяын тэр дурдагддаг бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг юм уу, түүнтэй холбоотой бизнес хийдэг аж ахуйн нэгжүүдэд мөнгө өгнө өө гэж байгаа юм. Монголбанк мөнгө өгнө өө гэж. Тэгээд Монголбанк өөрөө ямар мөнгөтэй юм, татвар цуглуулагч биш, баялаг бүтээгч биш. Тэгэхээр олгож байгаа мөнгө бол Монголбанкны мөнгө бол мөнгө хэвлэж олгож байгаа юм. Энэ өөрөө яг тэр 13-16 оны үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн алдааг яг дагаад давтаж байгаа. Тэгээд тэр үнэ тогтвортжуулах 13-16 оны тэр үнэ тогтвортжуулах хөтөлбөр дээр хийгдсэн дүгнэлтүүд нь маш ойлгомжтой ганцхан л дүгнэлт хийсэн. Энэ бол төсвийн үйл ажиллагаа байна аа, буруу зөв гэж яригдаагүй, төсвийн үйл ажиллагаа байна аа гээд аудит болон бүх төрлийн дүгнэлт нь гарчихсан энэ зүйл дээр бид нар дахиад алдаа хийж байгаа байхгүй юу. Энэ өөрөө зах зээлд аягүй буруу сигнал өгнө. Угтаа бол яаж хийх ёстай вэ гэхээр саяын гурван төрлийн бүтээгдэхүүнүүддээ зээл өгөх ажиллагаа нь бол болох л байх. Гэхдээ арилжааны банк өгөөд хүүгийн зөрөөг нь төсөвтөө суулгаад өгчихнэ. Ингэвэл мөнгө хэвлэх энэ үйл ажиллагаа болохгүй. Mash зөв. Мэндсайхан сайд бол өөрөө яг тэгж тайлбарлаад байна шүү дээ, өнөөдрөөс хойш. Яг бичиж оруулж ирэхдээ мөнгө хэвлэж өгөхөөр хийгээд өгчихсөн. Энэ чинь өөрөө аягүй тийм буруу. Өмнө нь гарч байсан тэр аудит эд нарын дүгнэлтээрээ бүх дүгнэлтийнхээ эсрэг зүйлийг бичээд өгчхөж байгаа байхгүй юу. Энэ бол өөрөө үнэ хөөрөгдөх үнэ өсөх, валютын ханш унах, валютын нөөц рүү дайрах ийм бололцоог бий болгож өгнө өө. Тийм учраас үүнийгээ та нар зас аа, тэр урьд өмнө нь хийсэн алдааг засаад бичээд оруулчхаж болно шүү дээ. Ийм алдаа дээр л яваад байгаа байхгүй юу. Үүнийг засах бүрэн боломжтой. Мэндсайхан сайд бол сая ер нь өөрөө бол зөв л тайлбарлаачхаж байна. Гэхдээ бичсэн зүйл нь 100 хувь эсрэгээрээ.

Дараагийн нэг хэлэх гэсэн зүйл бол нийт үнийн өсөлт. З бүтээгдэхүүнээ орхиё. Бусад үнийн өсөлтөө яах юм. Тэгэхээр Монголбанк 9 хувь болгож бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн. Зөв. Би бол харин ч илүү нэмэх ёстай байсан. 9 хувь бах вэ болж байна, гэтэл үүнийг зэрэгцүүлээд ямар арга хэмжээ авах ёстай юм вэ гэхээр төсвийн тодотголоо яаралтай өргөх ёстай. Төсвийн алдагдлаа бууруулаад, төсвөө болж өгвөл баланслуулаад өргөөд барьчих. Тэгэх юм бол бусад бүх барааны үнийн өсөлт хязгаарлагдаад ирнэ. Энэ үнийн өсөлтийг чинь яаж яаж явагддаг вэ гэхээр эрэлтийг бий болгоод байгаа учраас л тэр үнийн өсөлтүүд явагдаад байдаг. Тийм учраас энэ алхмыг дагуулаад хийчих юм бол болно. Ингэж бид нар энэ асуудалд хандахгүй бол яг тэр урьд өмнө шүүмжлээд тэр Бат-Эрдэнэ гишүүн миний ам асууж байна лээ шүү дээ. Үйлийн үр гэж байдаг юм аа, Хүрэлбаатар аа. Та нар их улс тэр хийж байсан, бид нарыг эрх барьж байх үед та нар улс тэр хийж байсан гэж. Тэгж ам асууж байна лээ. Гэхдээ би бол түүнд Бат-Эрдэнэ гишүүн ээ, тэр бол бодитой л доо. Тэгээд янз бүрийн эмзэглэж хариу хэлж байгаа юм биш. Яг л ингүүлэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр эд нарын гаргаж байсан алдааг давтахгүйгээр өөрсдөө засаад явуулчих юмыг өөрсдөө цэвэр алдаа хийгээд ороод ирэхээр л би шүүмжилж байгаа юм.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

**Б.Жавхлан:** Хүрэлбаатар гишүүний асуултад хариулья. Төсвийн байнгын хорооны даргын хувьд ингэж болгоомжилж байгааг бид хүндэтгэлтэй хандаж байна. Хүндэтгэлтэй хандаж байна. Энэ хуулийн үр дүн маш чухал. Үр дүн маш

чухал. Бид дунд хугацааны, урт хугацааны зорилго тавиагүй. Энэ богино хугацааны шийлүүдээ л энэ хуульчилж гаргая гэж байгаа юм. Мэдээж үр дүнгүй олгох эрсдэлүүд байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ энэ мөнгө хэвлэнэ гэдэг маань өөрөө үндсэндээ эдийн засгийн ойлголт нь бол байж болох хэмжээнээсээ мөнгөний нийлүүлэлтийг хэтрүүлж гаргах л асуудал шүү дээ. Тэгээд энэ хуулиар бол тийм боломж, тийм буруу зүйл гаргахыг бол хязгаарлана аа. Тийм эрсдэл гаргахгүй байхыг бид хичээж ажиллана аа. Уг нь тайлбарлаад л хичээгээд байгаа юм. Гэхдээ энэ хуулийн бичвэр дээрээ бид нар таны хэлснээр бид нар эргэж анхааръя. Түүн дээр банкаар дамжуулж гэж уг байгаа юм. Тэр ингээд жоохон буруу салаа утгаар ойлгогдоод байх шиг байна. Өөр нэг газраас эх үүсвэр гээд банкаар дамжаад тэгээд зээлдэгчид очих юм шиг ингэж ойлгогдоод байгаа юм. Уг нь бол энэ бүх бодлого бүх юм маань банкаар дамжиж хэрэгжинэ ээ л гэсэн бодлого юм байгаа юм. Санaa юм байгаа юм. Тэгэхээр түүнийг бичвэр дээрээ банкны эх үүсвэрээр гэдэг юм уу ингэж тодруулж оруулж өгөөд ойлгомжтой болгоход бол бид нарт хугацаа байна. Өнөөдөр бол хэлэлцэх өсөхээ шийдэж байгаа учраас. Тийм учраас мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх, багасгахаас болоод гол том макро зорилтоо байгаа онохгүй байх, богино хугацаанд үр дүнгээ саармагжуулах ийм эрсдэл гаргахгүй байх тал дээр онцгой анхаарч ажиллана аа. Ингээд Их хурал нэгэнтээ хэлэлцээд явчих юм чинь бичвэр дээрээ анхааръя.

Тэр тодотголын хувьд ингэсэн шүү. 2 ч гишүүн асуулаа, Хүрэлбаатар Төсвийн байнгын хорооны дарга бас хэллээ. Энэ жилийн хувьд төсвийн бодлого мэдээж одоо мөнгөний бодлогын хатуу төлөвтэй уялдаж ажиллахаас өөр арга байхгүй. Өөр орон зайд байхгүй. Гэхдээ төсвийн тодотгол маань өөрөө хуультай, хуулттай. Тэр нөхцөл болбол арай бүрдээгүй байна. Эрт байна тодотгол хийх. Гол зүйл бид орлогоо харна аа. Орлогоо харна. Энэ жилийн орлого ямар байх нь вэ. 1 дүгээр улирлын байдлаар болбол орлого хэвийн байгаа. Энэ болбол ковидын хүнд үеэ бид нар амжилттай давсны үргэлжлэл энэ эхний улиралд орж ирж байгаа юм. Энэ зэвсэгт мөргөлдөөний одоо энэ нөлөөлүүд, ингээд хоёр, гуравдугаар улирлын нөлөөлөл одоо орж ирэхийг үгүйсгэхгүй. 03 сарын 01-нээр бид нар одоо өмнөх жилүүдэд байгаагүй өндөр түвшинд төсвийнхөө бэлтгэл хөрөнгө оруулалтын одоо урьдчилсан бэлтгэл ажлыг сайн хангасан учраас бараг 80 хувьдаа зарласан шүү дээ. Зарласан байгаа. Ингээд 04 сард одоо аж ахуйн нэгжүүд ямар бэлтгэлтэй хангаж орж ирэх нь вэ. 05 сард одоо төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авалтын гэрээнүүд ямар түвшинд хийгдэх нь вэ. Орлого ямар байх нь вэ. Энэ төв банкны бодлогын үр дүнгүүд ямар гарах нь вэ. Энэ хуулийн үр дүнгүүд ямар гарах нь вэ. Ойрын хугацаанд бид нар төв банкныхаа валютын нөөцийг одоо нэмэгдүүлэх, Засгийн газраас хийж чадах бүх арга хэмжээнүүдийг авна. Энэ бол одоо түр зуурын энэ богино хугацааны шок гэж харж байгаа. Ингээд бас нааштай үр дүнгүүд гарахын төлөө бид ажиллана.

Ингээд хэд хэдэн зүйлүүдийг харж байгаад одоо орлогоо бас харж байгаад ингээд одоо төсвийнхөө асуудлыг мэдээж Төсвийн байнгын хорооны даргад Их Хурал дээрээ өргөн барьж, түүнээс өмнө ч ярилцана. Удахгүй одоо хэдхэн хоногийн дараа бид нар 23 оны төсвийн хөрөөний мэдэгдлээ өргөн барина. Төсвийн хүрээний мэдэгдэл өргөн барихад харин энэ жилийн гүйцэтгэл ямар байх вэ гэдгийг бид нар маш одоо зөв тооцоолж ингэж байж оруулж ирэх учраас тэнд одоо их олон юм харагдана аа гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар гишүүн тодруулж асууя.

**Ч.Хүрэлбаатар:** Энэ ийм шүү. Хятадын хил бол энэ 22 ондоо нээгдэхгүй биз дээ. Үүнийг удаа дараа хэлж байгаа. Хойно Оросын тэр Украина болж байгаа дайн байгаа, дайнтай холбоотойгоор энэ хоригууд улам л чангарна. Тэгэхээр тэнд бас асуудал тийм их амар зүйл болохгүй. Ийм байж байхад бид нар төсвөө тодотгож байна. Ядахдаа баланслуулахгүй бол тэр их олон хөрөнгө оруулалт дээр тавьчихсан байгаа зүйлүүд чинь эдийн засаг руу нэмж эрэлт оруулж ирнэ. Тэгээд энэ бүгдийг гаднаас тээвэрлэх гээд нөгөө тээврийн компаниуд чинь хоорондоо уралдаж байна. Тэгэхээр одоо 2 хил хэцүү. Дээр нь тээвэр ложистик нь болохгүй байж байхад нөгөөх дээр улам их ачаалал өгөөд нэмээд байвал хэвийн орж ирэх ёстой бусад энгийн бараанууд чинь орж ирж чадахаа больчих юм байгаа юм. Ийм учраас яаралтай тэр төсвийн тодотголоо бараг өргөсөн нь дээр дээ. Одоо хэдүүлээ бол бодитой л амьдарцаасан дээр. Ингэсээр байгаад юмаа хүндруүлчих вий.

**Г.Занданшатар:** Тайлбар хэллээ. Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр энэ олон улсын хямралт байдлаас үүдэлтэй гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомсдолоос урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагаврыг нь бууруулах талаар оруулж ирж байгаа хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм. Мэдээж бидэнд авч хэрэгжүүлэх гэж байгаа тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнүүд байна. 2 нь бол бид дотооддоо нийлүүлэлтээ хангах бололцоо байна. Тэгэхээр зэрэг хамгийн гол барьж авч ноцолдох ёстой зүйл бол үйлдвэрлэгч, хэрэглэгч хоёрыг хооронд нь яаж нүүр тулгаж, завсрын үнэ өсөлтуүдийг тодорхой хэмжээнд бууруулж чадах вэ гэдэг асуудал бол энэ үнэ өсөлтөөс ч урьдчилан сэргийлэх нэлээн том зүйл байх байх аа, үүнд нэг их учиргүй хөрөнгө мөнгө гаргаад байлгүйгээр зохицуулалт, зохион байгуулалтын түвшинд шийдчихэж болохоор зүйлүүдийг давхар авч үзэж чадах юм бол бид нарын өнөөдрийн энэ яриад байгаа зүйлүүд жинхэнэ үр дүнд хүрэх болов уу гэж би бodoод байгаа юм. Төв суурин газрын энэ махны хэрэглээ хангах асуудал дээр малчид, энэ гэр хорооллын гэдэг юм уу, энэ төв суурин газрын айл өрхүүд рүү чинь яаж махаа нийлүүлчихдэг, төвөгт багатай нийлүүлчихдэг өөрсдөө нүүр тулаад борлуулчхаж чаддаг тийм арга замаа бид хайвал нэлээн тийм зохистой үр дүн наашаа эргэх болов уу.

Дээр нь бэлтгэн нийлүүлж нөөцийн мах бэлтгэх гээд байгаа аж ахуйнууддаа хөнгөлөлттэй зээл олгох хэлбэрээр нөөц бүрдүүлэлтээ нэмэгдүүлье гэж зорьж байгаа явдал бол зөв өө. Энэ бол хугацаа ямар хэмжээнд үргэлжлэхээс үл хамаараад бид бас нэг стратегийн нөөцтэй байх ёстой гэдэг тал дээр бол зөв байна гэж.

Дээр нь энэ хуулиар нэг их том зүйл орж ирж би зөв гэж бodoод байгаа юм. Тодорхой хэмжээний дэмжлэг гэдэг юм уу, тэр хүрээнд хамрагдчихсан аж ахуйн нэгжүүд хариуцлага үүрч өгөхгүй, үнэ хөөрөгдөөд болж өгөхгүй байгаа юмнууд бий. Гаал НӨАТ тэглэчхээд байхад тэгээд гэрэл цахилгаан тэглэчхээд байхад тэжээлийн үнийг өсгөж давхиад үймүүлээд байсан гурилын үйлдвэрүүд олон байсан. Тэгвэл одоо энэ нөхдүүдэд тодорхой хэмжээний хөнгөлөлттэй тэр тодорхой тодорхойлоод байх юм байхгүй. Бараг далаад хувийг нь дааж байгаа энэ зээлийн хүүгийн зөрүүг бид даагаад байгаа учраас энэ нөхдүүд ямар үүрэг хүлээх юм гэдэг юмыг их тодорхой болгож барьж эзэмшиүүлж байж сая энэ асуудал нэлээн биеллээ олох ёстой юм, би тийм учраас тэр мах бэлтгэж байгаа, гурил үйлдвэрлэх гээд байгаа тэр аж ахуйн нэгжүүдийн асуудлыг нэлээн цэгцтэй бodoх ёстой. Зөв зүйл ээ гэж ингэж харж байна аа. Энэ гэрээг харин нэг бодитойхон шиг хийж

дүгнэж чаддаг байх энэ асуудлаа бид нэлээн онцгой анхаарах ёстой болов уу гэж ингэж хараад байна.

Дараагийн нэг зүйлд шатахууны импортын асуудал байна. Нөөцөө нэмэгдүүлэх ёстой. Хамгийн түрүүн давын өмнө нэмэгдүүлэх ёстой нөөц дизель түлш байгаа. Бид нарын уул уурхай дизель түлш дээр голлож явж байгаа. Хөдөө аж ахуй маань дизель түлш дээр тулгуурлаж явж байгаа. Авто ачаа эргэлт тэр чигтээ дизель түлшин дээр явж байгаа. Тийм учраас дизель түлшний үнэ хийгээд нөөц хангалтыг нэмэгдүүлэх асуудлыг бид бүр онцгой авч үзэх ёстой. Ингэж чадах юм бол бид энэ хүндрэлийг бага давах бололцоо, боломж байгаа юм. Арга замын хувьд би их л зөв л явж байгаа юм байна, явах ёстой юм байна. Үүнийгээ, өнгөрсөн жил бид нар хийсэн гэж ингэж ойлгоод байгаа, банкнуудын түгжигдсэн активыг бодит эдийн засаг руугаа оруулаад, тэгээд тэр хэмжээгээр бас тодорхой хөнгөлөлттэй зээлийг нь олгоод зөрүүг нь төр өөрийнхөө нуруун дээр, хүүгийнхээ зөрүүг өөр дээрээ л авч байгаа.

Тэгэхээр зэрэг харин нэмж бид нар бодууштай зүйл бол энэ эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал, бүх төрлийн будааны асуудлыг авч үзэхэд гэмгүй ээ. Үүнийг бол би нөөцөө нэмэгдүүлэх, бас үнэ ханшийг тогтвортой байлгахад энэ хоёр төрлийн бүтээгдэхүүнийг бол онцгой авч үзэх ёстой. Энэ бол яалт ч байхгүй бид нарын өмнө цагаа тулахад нэлээн ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Санал юм даа тийм ээ. Асуулт байсангүй ээ. Гочоогийн Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Хуулийн төслийг бид нар бүлэг дээр дэмжсэн. Тэгээд өнөөдөр яах вэ, сайдын зарим нэг хариулт дээр жаахан эргэлзээ төрж байна л даа. Бид нар бол бензин бол 100 хувь гаднаас экспортоор авч байгаа учраас энэ болбол зайлшгүй хийх ёстой ажил. Мах, гурилын хувьд бол дотоодоосоо бид нар 100 хувь хангадаг юмны хувьд заавал одоо нөөц бүрдүүлэх гээд байхаасаа илүүтэй сая Батжаргал гишүүний хэлдэг малчид одоо яг энэ төв суурин газрынханд махаа ямар нэгэн түрээс татваргүйгээр дундаа ямар нэгэн ченжийн дамжлагагүйгээр зarah тэр бололцоо, боломжуудыг л нээж өгөх ёстой л доо. Тэгэхгүй бол бид нарын одоо яг энэ хуулиар чинь болбол дунд нь нөгөө малчдаас худалдаж аваад ирж зардаг ченжийн маягийн аж ахуйн нэгжүүдэд л дэмжлэг үзүүлэх юм болохоор зэрэг энэ өөрөө жаахан буруу болох гээд байна аа.

Гурилын хувьд бол бас л одоо 100 хувь хангана. Гэхдээ энэ болбол урт хугацаанд учраас энэ жилийн тариалалтаас маш их хамаарна аа. Тэгэхээр зэрэг одоо тэд нарт дэмжлэг үзүүлэхээс гадна одоо байгаа боломжтой энэ талбайнууддаа улаан буудайгаа өөрсдийн одоо үрийн нөөцийн хэмжээнд тултал нь тариалах, тэгээд бусад төрлийн одоо арабс ч юм уу тосны ургамал, бусад одоо тариалалтуудыг жаахан хязгаарлах чиглэлээр явах юм болбол ирэх жилийнхээ нөөцүүдийг бид нар бүрдүүлээд авах боломжтой гэж үзээд байгаа юм. Тэгэхээр одоо Улаанбаатар хотын ч юм уу орчин үеийн хэрэглээ болбол зөвхөн гурилаар хязгаарлагдахгүй будааны хэрэглээ болбол гурилаасаа ч бараг зарим газар давчихсан байгаа шүү дээ. Гэтэл бид нар бол будаагаа 100 хувь экспортоор авч байгаа юм, импортоор. Тэгэхээр зэрэг цагаан будаа бол дэлхийн бүх улс орнуудад бол стратегийн хүнс нэг л өдөр дэлхий дээр хүнс хязгаарлах юм болбол бүгдийг нь хориод хаячихна. Одоо өнөөдөр бол Монгол Улсын нэг будааны хэрэглээг нэг, хоёр, гуравхан одоо аж ахуйн нэгж л 100 хувь хангаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ одоо нөөцөө бүрдүүлэх тал дээр энэ хуульдаа нэг жаахан юм оруулж, тэр аж

ахуйн нэгжүүдэд ядаж нэг долларыг нь одоо албан ханшаар нь өгчихдөг, тэгээд татаж ирж байгаа вагоны хүрэлцээ хангамжийг нь нэмэгдүүлэх, тэгээд будааныхаа нөөцийг нэмэгдүүлэх тал дээр энэ хуулийн төсөлд жаахан оруулж онцгой анхаарахгүй болбол дотоодоосоо 100 хувь хангадаг юмнуудаа бид нар оруулчхаад гаднаас 100 хувь авдаг юмнуудаа жаахан орхиод байгаа нь бас жаахан учир дутагдалтай юм уу. Энэ дээр одоо яг сайд ямар бодолтой байгаа юм? Будааны нийлүүлэлт ер нь ямар байгаа юм. Дэлхийн улс орнууд энэ будааны экспорт дээр яж хандаж байгаа талаар танаас нэг асуух гээд байгаа юм аа?

Дараагийн асуудал бол энэ хуульд нэг нэг зүйл оруулмаар юм шиг Ерөнхий сайд бас юу гэж бодож байгааг би мэдэхгүй байна л даа. Энэ ханшийн зөрүү Монголбанкны одоо валютын албан ханш, хар захын валютын ханш хоёр болбол асар их зөрүүтэй болчихлоо. Өмнө нь болбол энэ ханшийн зөрүү маш өндөр. Эндээс одоо баахан банкныхан л нэг тав гурван төгрөг хийдэг ийм л одоо зүйлүүд нийгэмд дүүрэн шүүмжлэл байдаг шүү дээ. Тэгэхээр энэ хуульдаа оруулаад ер нь түр зуур энэ ченжийн захуудыг жаахан хязгаарлаад нэг ханштай болбол боломж байгаа юу? Зөвхөн одоо Монголбанкны банкнуудын ханшаар авдаг өгдөг. Тэгэхгүй болбол өнөөдөр энэ хар зах руу гарч байгаа доллар болбол банкнуудаас л гарч байгаа шүү дээ. Түүнээс иргэд гаднаас одоо доллар кармалж ирээд зарж байгаа зүйл бараг байхгүй шүү дээ. Тэгээд энэ зөрөөг одоо арилгах чиглэлээр энэ хуульд нэг тодорхой, одоо хязгаарлалт хугацаатай зүйл оруулаад энэ ханшаа нэг болгоод явахгүй болбол хэт зөрүүтэй, тэгээд энэ байдал дээр бас иргэдийн зүгээс нэлээн бухимдал байгаа юм болов уу, энэ цаашдаа бас зөрүү нэлээн нэмэгдэх хандлагатай болоод яваад байгаа юм аа. Энэ дээр одоо бас ямар бодолтой байгаа вэ гэж асуух гэсэн юм.

**Г.Занданшатар:** Загджавын Мэндсайхан сайд 94.

**3.Мэндсайхан:** Ганболд гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр түрүүн би хэлсэн, мах бэлтгэгч аж ахуйн нэгжүүдийн зээл банкан дээр байгаа эх үүсвэрийг цааш нь хөнгөлөлттэй нөхцөлөөр гаргана аа гэдэг зарчмаар явна. Улаанбаатар хотын төв суурин газар малын генетик нөөцийн тухай хуулиар хоёр бид нар энд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махыг хүн амынхаа хэрэгцээнд хэрэглэх ёстой. Тэгэхээр одоо Засгийн газар энэ ажлыг дэмжээгүй биш дэмжиж байгаа. Өнгөрсөн өвөл одоо бид нар төв суурин газрынхаа иргэдийг идшээр хангах энэ үйл ажиллагаануудад зохион байгуулсан. Гэхдээ эрүүл ахуй гэдэг асуудал хөндөгдөж байгаа учраас бид нар мэргэжлийн эрх бүхий үйлдвэрүүдэд энэ үйл ажиллагааг нь дэмжиж зах зээл нь явж байгаа. Тэгэхээр малчид маань энэ л үйлдвэрүүдэд мал, маахаа нийлүүлээд явах боломж нь нээлттэй байгаа.

Цагаан будааны хувьд бол одоо үнийг нь бол Засгийн газар цаашдаа бид нар тогтвортой барина гэдэг ойлголт бол байхгүй л дээ. Энэ гадаад зах зээл, импортоор орж ирдэг бүтээгдэхүүн. Гадаад зах зээл дээр тухайн энэ бүтээгдэхүүний энэ үнэ өсөхөд Засгийн газар энэ дээр ямар нэгэн зохицуулалт хийх боломж байхгүй. Харин би зүгээр өнөөдрийн байгаа байдлаар бол бид нар хэвийн нөөц буюу нэг жараас дээш хоногийн нөөцтэй байна. Цагаан будаан дээр ер нь гол дүр, нэр төрлийн бүтээгдэхүүн дээр нөөцийн хувьд асуудал үссэн асуудал байхгүй. Бид эрсдэлээс сэргийлье гэж байгаа юм. Цаашдаа цагаан будаа болон ер нь гол нэр нэрийн төрлийн бүтээгдэхүүн импортлож байгаа аж ахуйн нэгжийн тээвэр зохицуулалтын асуудлыг бид нар Зам, тээврийн яамтайгаа, Гадаад хэргийн яам хамтраад шийдвэрлээд явж байх. Нийт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн 25 хувь нь зөвхөн хүнсний бүтээгдэхүүн орж байгаа. Тэр

дундаа энэ стратегийн хүнс бол импортоор орж ирж байгаа. Нөгөө талдаа энэ хүнсээ харин бид нар хойш нь энэ одоо дайн тулаан болж байгаа газрууд руу экспортод гаргачихгүйн тулд энэ хууль дээр зохицуулалт бас орж ирж байгаа.

Гурилын үйлдвэрүүдэд бид нар эргэлтийн хөрөнгийн зээл өгье өө гэж байгаа юм. Энэ хавар Засгийн газар дотооддоо хүнсээ бүрэн ханган Атрын дөрөвдүгээр аяны хүрээнд эх орны эрүүл хүнсээр дотооддоо хангая аа гэдэг хүрээн дор хүнсний ногоогоо дэмжсэн. Нэлээн хэд хэдэн шийдвэрийг гаргасан. Тариалалтыг нэмэгдүүлэх боломжийг нь бүрдүүлж өгсөн. Өнгөрсөн оны ургацаас авч чадаагүй илүү үйлдвэр аваагүй 45 мянган тонн улаан буудайг нөөц бүрдүүлэх зорилгоор авахаар шийдвэрүүд гарсан. Тэгэхээр бид нар тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр бол Засгийн газар шат дараатай арга хэмжээ авсан. Одоо харин тэр боловсруулах үйлд үйлдвэрүүд нь буюу гурил дээрэмдэх үйлдвэрүүддээ бид нар эргэлтийн хөрөнгийн зээл олгох намрын тариалалтаас нь бий болсон бүтээгдэхүүнийг нь худалдаж авах эх үүсвэрийг нь хуулиар нээж өгч байгаа юм аа.

### Г.Занданшатар: Одоо Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Баярлалаа. Үгүй ээ яах вэ, гурил мах чухал. Тэгэхдээ бас зарим нэг нэр төрлийн юмнууд дээр бас асуудал үүсгэнэ ээ гэж хараад байгаа юм. Элсэн чихэр, эм тариа, эм тариа ялангуяа, эм тариан дээр асуудал үүсвэл нэлээн хүнд нөхцөл байдал үүснэ ээ гэдгийг бас та бүгд анхаарна биз.

Тэр тариалангийн компаниудад өгөх ёстой юм биш үү? Тэнд бол нэлээн суп будаанууд бас байгаа юм байна лээ. Тийм учраас түүнийг нөөцөд авмаар байна. Тэгээд би яагаад тариалангийн компаниуд гурилын үйлдвэрт өгснөөс дээр гээд байвал Украинд энэ жил бол мэдээж тариалалт хийгдэхгүй учраас болбол улаан буудайн хомсдол ирэх жил явагдана аа. Тийм учраас харин газар тариалангийн компаниудынхаа тэр будааг нөөцөд аваад тэд нартаяа тэр түлш шатахуун авч өгөөд одоо хямд байгаа дээр нь авч өгөөд харин тариалалт дээр нь дэмжлэг үзүүлбэл бид нар өөрөө өөрсдийгээ аврах юм биш үү? Гаднаас аврал хайж байсанд орвол өөрсдөө тариагаа тариад тэгээд ирэх жил ургацаа хурааж авахад энэ талдаа анхаарсан нь дээр. Би бол дэлхий нийтээрээ бол нэлээн одоо улаан буудайны асуудал бол гурил бол хүндэрнэ ээ гэж ингэж бодож байна. Украин тарихгүй учраас. Тийм учраас та нар газар тариалангийн компаниуд, хоёрт тэр одоо энэ нэг шатахууны компаниудад валютын татаасыг чинь Алтанхуягийн Засгийн газрын үед бас хэрэглэсэн байхгүй юу. Тэгэхдээ энэ яг цаг үеийн л арга хэмжээ байдаг юм. Өсчихсөн валютыг тэртээ тэргүй нь татаас өгөөд хөөж гүйцэхгүй шүү дээ. Нэг өдөр тэр өсчихсөн валютаар л бензин аваад л зах зээл тэр үнээр л зарна. Тэр үед шок болчихдог байхгүй юу. Тэгэхээр шокийг өнөөдөр авах юм уу, хэдэн сарын дараа авах юм уу гэдэг л асуудал. Жавхлан сайд тэр үед бол Монголбанкны дэд ерөнхийлөгч байсан өөрөө сайн мэдэж байгаа. Тэгээд наад арга чинь зөв юм уу гэдгээ та нар сайн бодоорой. Яагаад гэвэл хэзээ нэг өдөр дахиад л тэр өссөн валютаар бид нар бензин зарна шүү. Тийм учраас энэ бол төгс шийдэл биш цаг хугацаа аргалж байгаа хэлбэр гэдгээ бас одоо та бүхэн бодоорой.

Бас би энэ хүнсний компаниуд дээр нэг юм бодоод байна аа. Валютаар зээл өгөхөөр чинь тэд нар эрсдэлд орчихно шүү дээ, ханшны. Тэгэхээр тэд нар нийлүүлэх үү, үгүй юу, үүнийг нь сайн бодоорой. Тэгээд дараа нь нөгөө валютаа төлөхийн тулд нөгөө хямдхан төгрөгөөр хүнсээ зарчихдаг валют нь өсчихсөн байдаг. Тэгэхээр энэ ханшийн эрсдэлээс болоод одоо энэ компаниуд бол хүндрэлтэй байж магадгүй. Энэ асуудал ер нь 24 он хүртэл үргэлжилнэ ээ. Тийм

учраас бид нар одоо нүүрснээс хамааралтай энэ 50 хувь нүүрснээс хамааралтай эдийн засгаа арай нэг жоохон анхаарах ийм юмнуудыг хайхгүй бол болохгүй байх гэж би бодоод байгаа юм. Зүгээр мэдээж хэрэг дэлхийн зах зээл дээр болбол одоо энэ зэвсэглэлээр нэлээн хөөцөлдөх ийм хандлага гарчхаж байгаа учраас болбол Европын холбооны мэдэгдлүүд ч гэсэн тийм байна шүү дээ. Тэгэхээр зэс, төмрийн хүдрийн үнэ бол унахгүй нь ойлгомжтой. Тэгэхээр энэ зэс, төмрийн үйлдвэрийн чиглэлийн юмнуудаа гангийн үйлдвэрийн чиглэлийн юмнуудаа бас нэг жоохон анхаарвал яасан юм бэ гэж ингэж бодоод байгаа юм. Мэдээж хэрэг нүүрсний үнэ болбол унахгүй л дээ. Одоо Европт болбол өвөлжилтийн асуудал энэ газаас болон хүндэрч байгаа учраас заавал тэнд дулааны асуудал, тэгээд энэ цахилгааны асуудал бол үүсчихсэн учраас болбол нүүрсний үнэ болбол нэг их буурахгүй байх. Тэгэхдээ нүүрсээ одоо бид нар зөвхөн нүүрсэндээ ингээд хамаараад байвал хүндрэх нь ээ гэж. Тэгэхээр валютын нөөцөө юугаар нэмэгдүүлэх, яаж одоо зохицуулах вэ гэдэг талаар яг ямар бодол байна гэдгийг би нэг Монголбанкийг нэг сонсьё. Тэгээд Гадаад харилцааны яам одоо маш сайн ажиллах хэрэгтэй. Маш хариуцлагатай ажиллах ёстой. Тийм учраас одоо бол та бүгд болбол юу одоо унтах нойргүй ажиллах юм болбол Гадаад харилцааны сайд шүү, би Гадаад харилцааны сайдад нэг юм хэлээд байгаа шүү дээ. Яг Орост ямар нөхцөл байдал үүсээд байгаа юм бэ? Бидэнд танилцуул гэж. Ойрын үед үүнийг танилцуул, бүлэгт танилцуул. Одоо зүгээр алхуулахгүй шүү та нарыг. Тийм учраас болбол одоо л бид нар шаардана, шаардаад болохгүй бол сайд нарын асуудлыг Ерөнхий сайд аа бид нар тавина шүү. Үнэхээр одоо ажлаа хийж чадахгүй бол ийм хүнд нөхцөлтэй ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Монголбанк Бядрангийн Лхагвсүрэн Ерөнхийлөгч 83. Товч тодорхой 2, 2 минутад хариулаад явчихъя.

**Б.Лхагвасүрэн:** Даваасүрэн гишүүний асуултад хариулья. Түрүүн бас Ганболд гишүүн асууж байсан. Энэ ханштай холбоотой ямар зохицуулалт хууль дээр байна аа гээд. Монголбанкны энэ форворд своп арилжааны журам байгаа. Энэ журмын дагуу бол одоо богино хугацааны ийм хэлцлүүдийг хийж болно. Тэгэхээр өнөөдөр байгаа ханшийг бол энэ хоёроос гурван сараас зургаан сарын хооронд бол ийм тогтвортой байхаар ийм хэлцэл хийх ийм боломжтой журам байгаа. Тэгэхээр энэ журмынхаа дагуу, ялангуяа тэр нефть импортлогч нар бол ингээд тогтвортой ханшаар зөвхөн төлбөр тооцоонд зориулж л энэ ханш үйлчилж байгаа учраас бол төлбөр тооцооны хувьд бол одоо ингээд асуудалгүй явчихна аа л гэж харж байгаа.

Нөөцийн хувьд бол одоо Монголбанкны валютын нөөц өнөөдөр 3,3 тэрбум доллар. Ойрд одоо ер нь энэ 4 сардаа ч юм уу, энэ хоёр сарын дотор орж ирэхээр тэрбум долларын ийм хэлцлүүд бас байж байгаа учраас ерөнхийдөө бол ханш бол ингээд тогтвортыхи боломжтой гэж харж байгаа юм.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

**Ц.Даваасүрэн:** Наад нефтийн компаниудад өгсөн бол би хэллээ шүү дээ. Алтанхуягийн хувьд яасан. Тэгэхдээ түр зуур аргалаад дараа нь шоконд оруулчихсан шүү. Одоо валютын ханшийн өндөр үнээр нь бензин зараад л эхлэнгүүт нийгэм ахиад л шоконд орчихсон шүү дээ. Тэгэхээр наадах чинь түр хугацааны юм байдаг юм шүү гэж. Тэгээд ер нь бол одоо манай сайд нар хариуцлагатай ажиллах ийм цаг ирсэн, нөхцөл байдал бол амаргүй. Цаашдаа улам одоо хүндрэх ийм нөхцөл байдал бол гарч ирнэ. Энэ бүгд бэлэн байх

хэрэгтэй. Эрчим хүчнийхэнд би хэлж байгаа. 2 онд болбол одоо оройн цагаар болбол тог тасалж эхэлнэ. Тэгэхэд одоо тэр үед л нэхнэ шүү дээ. Яагаад юугаа хийгээд сууж байсан юм бэ гээд л бид нараас асууж эхэлнэ шүү дээ. Ийм хүнд нэхцэл байдлууд гарна аа. Одоо бол бид нар сайд нараас болбол хариуцлага нэхнэ, Их Хурлаараа чөлөөлөгдөхгүй болчоор одоо сайн ажиллана л гэсэн шүү дээ. Их Хурлаас айгаад ажиллаж чадахгүй байгаа юм аа л гэсэн. Одоо тэгээд айхгүй сайн ажиллаж байгаа нь хаана байна. Тийм учраас хэрвээ сайд нар дээр энэ хариуцлагагүй хандсан юм гарах юм бол бид нар сайн ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

**Б.Энх-Амгалан:** Хуулийн төслийг дэмжиж байгаа юм аа. Энэ дэлхий нийтэд үүсээд байгаа нэхцэл байдлаас үүдээд энэ гол нэрийн бараа, бүтээгдэхүүнийхээ хангамж, нийлүүлэлт, хомсдолоос, урьдчилан сэргийлэх үүднээс ийм арга хэмжээ авч байгаа нь бол зөв. Тэр дундаа манай улс шиг одоо нефть, шатах тослох материалаас 100 хувь хамааралтай байдаг улсын хувьд болбол маш их хэрэгтэй. Тэгээд би нэг хоёр гурван зүйлийг л хэлэх гээд байна л даа.

Одоо ингээд Монголбанкнаас, Засгийн газраас, улсаас ингээд эргэлтийн хөрөнгийнхөө асуудлыг шийдүүлж авчхаад, санхүүгийн дэмжлэг, хүүгийн хөнгөлэлт эдэлчхээд, тэгээд нөгөө оруулж ирж байгаа импортлогч компаниуд маань зохиомлоор үнэ өсгөх вий дээ. Үнийн хөөрөгдөл бий болгох вий дээ. Зохиомлоор одоо хомсдол үүсгэх вий дээ. Энэ нэхцэл байдал дээрээ хуулийн заалт дээр нэлээн сайн зүйл оруулж өгөхгүй болбол тогтоон барьж чадахгүй мөнгө өгөөд байдаг, дээр нь хомсдол үүсвэл хэцүү шүү гэдэг нэг нэхцэл байдлыг хэлж байгаа юм.

Хоёрдугаарт нь, нөгөө саалиа бэлдэхээр саваа бэлд гэж. Одоо энэ нефть, бензин тос, шатах тослох материалынхаа хадгалдаг агуулах савыг нэлээн сайн бэлдээч ээ. Тэгэхгүй болбол бас нөгөөх нь хэмжээтэй дамжаатай учраас бас хэцүү байгаа юм аа.

Дараагийн нэг асуудал болбол одоо бид нар ингээд Монголбанк валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор банкаар дамжуулаад алт бол худалдаж авах тухай ярьж байна. Түүний том хөшүүрэг нь болохоор зэрэг энэ Лондонгийн биржээс таван хувийн нэмэгдэлтэйгээр худалдаж авья, далд байгаа алтыг гаргаж ирье, аж ахуйн нэгжийн нэгжүүд болон хүмүүсийн гар дээр байж байгаа өмнө нь тушаагаагүй тухайн жилдээ санхүүгийн жилдээ тушаагаагүй байгаа алтыг одоо авья гэдэг ийм санаачилга гаргаж байгаа юм. Энэ нэг талдаа зөв байх. Нөгөө талдаа одоо бид нар чинь энэ лиценз, патент нэрээр нэг баахан газар нутгаа өгөөд түүнээсээ болоод одоо энэ ойн сан, усны их ундарга, ургамлын ай сав сүйдсэн сүйрсэн, улаанаараа эргэлдсэн байгалийн гамшиг болсон ийм нэхцэл байдал олон байгаа шүү дээ. Яг ингээд эргэлтийн хөрөнгө өгөөд ирэхээр зэрэг эд нар маань ингээд алтны төлөөх дайн болоод бүгдээрээ ингээд алтан хошуураад ингээд явчих вий дээ. Одоо нэхцэл байдлыг анзаарч байхад бол Говь-Алтай аймгийн Тонхил суманд одоо энэ 9 зүйлийн гол дээр ингээд хууль бус алт олборлогчид орчихсон, ухаад төнхөөд иргэд одоо мессеж захидал занаяа ирүүлээд ингээд байдаг. Мөн одоо энэ мөнгөн амсартай алтан тэвшийн хөндийд бас одоо ингээд хууль бусаар олборлогчид яваад байна, дээрээс нь аймгийн удирдлагууд тэнд нь зохион байгуулалттайгаар хүн амьтан оруулаад тэндээсээ болж зодолдож нүдэлдээд, тэгээд аваар осол гаргасан, архи дарс уусан юм асуудал гаралтад байна гээд байна. Ийм хууль бус үйл ажиллагаа гаарчих вий дээ гэдэг дээр онцгой

анхаараарай. Ийм юмаа давхар хаагаарай хуулиараа. Тэгэхгүй болбол нөгөө мөнгө болоод нүд цагаан гэдэг шиг, ингээд нутаг орон руугаа ингээд алт ухах гээд дайраад орчих вий дээ гэдэг нэг ийм болгоомжлол байгаа юм аа.

Дараа нь бол бас энэ валютын нөөцөө нэмэгдүүлэхийн тулд төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхийн тулд энэ бидний гол одоо экспортын нэрийн бүтээгдэхүүн, зэс, төмрийн хүдэр, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарах шаардлага, хэрэгцээ байна аа. Энэ дээр нэг тийм бас 2 талтайгаа нэлээн сайн ярьж, ямар арга замаар тэр коронавирусийн нөхцөл байдлыг давж одоо өгөх үү гэдэг асуудал их чухал байгаа юм. Ялангуяа ямар арга замаар түүнийг одоо хүлээж авбал одоо ингээд чөлөөтэй хүлээж авах юм. Заавал манай жолооч нар тийшээ ороод байх хэрэгтэй юм уу, үгүй юм уу, нөгөө жолоочгүй тээврийн асуудлууд нь юу болох юм, энэ мэтчилэн одоо тэр төмөр замын гарцуудаа яаж явуулах вэ гэдэг тал дээр нэлээн анхаараарай гэж хэлэх гэж байна. Би санал хэллээ.

**Г.Занданшатар:** Санал хэллээ. Дашдандогийн Ганбат гишүүн асуулт асууяа.

**Д.Ганбат:** Ер нь нөхцөл байдал бол амаргүй л байх шиг байна л даа. Тэгээд бас бид нар өнөөдөр ийм асуудал хэлэлцээд сууж байгаа нь нэг бодлын гунигтай, нөгөө бодлын эмгэнэлтэй л байна. Монгол Улсын Ерөнхий сайдыг бол би энэ Монгол Улс энэ улс орныг бол Азийн хөлөг улс болгох гээд л ингээд л хичээгээд л яваад байгаа ийм л хүн гэж ойлгодог л доо. Гэхдээ урьд нь одоо хураагдсан нөхцөл байдлаас болоод өнөөдөр бол Монгол Улс Азийн гөлөг улс л болчоод байна л даа. Товч бөгөөд тодорхой хэлчхэд.

Энэ хуулийг бол дэмжихгүй байна аа, энэ магадгүй Ерөнхий сайдын хэлээд байгаагаар бол арга ядсаны ядсан арга, богинохон хугацаандаа бол ашиг тусаа өгч мэдэх юм. Гэхдээ урт хугацаандаа бол энэ явцгүй ээ. Энэ одоо олон жил хуримтлагдсан юмны үр дагавар ингээд гарч байна л даа. Олон улсын хямралт байдал л гэж. Энэ хуулийнхаа эхлээд нэрлээд орж ирсэн байна. Хямрал байгаа ч юм уу, үгүй ч юм уу, мэдэхгүй байна. Хэн ийм нэр томьёо олчихсон юм. Гэхдээ хямрал байгаа бол энэ бол боломж. Энэ боломжийг ашиглах ёстой. Боломж гэж харах ёстой. Гэтэл өнөөдөр нөхцөл байдал ямар байна. Гурил, мах бол асуудалгүй байх аа. Тэр тэнгэр хангай ямар байдаг юм. Байгаль дэлхий ямар байдаг юм түүнээс шалтгаалах байх. Одоо бэлчээрийн мал аж ахуйтай бараг 60, 70 сая малтай, тэгээд малын өвчин тархсан байгаа, тийм учраас нэг, хоёр, гурван жилдээ бол гадагшаа бид нар мах гаргалтгүй. Энэ өвчтэй малынхаа махыг янз бүрийн байдлаар бид нар л идэж таарах байх л даа. Нэг тиймэрхүү л юм болох байх.

Гурилынх нь тэр цавуулаг нь ямар байдаг юм, тэр шаардлага хангадаг. Үүнийг нь одоо явдаг юмыг нь явдгаар нь явуулсан нь дээр байх аа.

Газрын тосны асуудал бол үгүй ээ, энэ чинь бас Энэтхэг улс чинь 65 доллароор авч чадаад байна шүү дээ. Оросын холбооны улсаас рушигээрээ. Тэгээд манайхан яагаад чаддаггүй юм. Энэ чинь нэг олон оронд нийлүүлж чадахгүй л байгаа шүү дээ. Хэдхэн оронд л нийлүүлнэ. Оросын холбооны улс. Энэ дээр анхаарах хэрэгтэй байх аа.

Энэ хамгийн гол юм бол валютынхаа энэ гадаад валютын албанаас өнөөдөр ямар байна вэ? 4,9 тэрбумд хүрч байсан. Өнөөдөр одоо он гараад л

хэдхэн сарын дотор 3,6 болчхов уу, хэд болчхов, цаашдаа одоо энэ судалгаа юм хум байна уу, хэд болох юм. Бүр чаддаг юм бол та нар хуулийг юанийг тэд байна, долларыг тэд байна гээд л гаргачих л даа. Тэгээд бид нар чинь импортоос хамааралтай шүү дээ. 80, 90 хувь нь одоо импортоор авдаг. Тэр янз бүрийн хэрэглээ хасаж байна, барьж байна гээд хоёр гурван захтай болгоод энэ чинь одоо буруу бодлогын чинь илэрхийлэл үүнийгээ больсон нь дээр байх. Ер нь Монголбанк бол хараат бус ажиллах ёстой. Засгийн газартай нэг хөл толгойгоо нийлүүлээд гүйгээд байж болохгүй байх. Энэ дээрээ аль аль нь анхаарсан нь дээр байх аа. Тэгээд үүнийг чинь инфляцыг чинь төлбөрийг Монголын ард түмэн төлнө өө, угаасаа төлж байна. Бодлого бол буруу байна. Сүүлийн 6 жилд, энд ер нь 2010 онд байна уу, 12 онд ч байна уу эдийн засаг хөгжөөд л бүх сайхан болж байсан шүү дээ. Одоо нүүрсээрээ бол бид нар Саудын араб шиг болчих нь ээ гээд л хувийн хэвшилд маань төмөр замаа олон улсын стандартынх нь дагуу тавьчих гээд л. Тэгээд одоо энэ байдал болоод түүх болоод үлдчихсэн. Одоо бид нар нүүрсээ гаргаж чадахгүй байна. Сүүлийн 6 жил та нар бол одоо хэнтэй ч хуваалцахгүйгээр төр засгаа олонхоороо барьчихсан.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна аа.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би уг нь Ганбат гишүүнийг танкчин гэж ойлгоод байдаг. Олон улсад хямралт байдал үүсээгүй гээд танкчин хүн улаан цайм дайн болоод хүмүүс бие биеэ одоо их амаргүй нөхцөл байдал байхад танкчин хүн ийм дүгнэлттэй байна гэдэг ч одоо бас амаргүй л юм л даа. Яах вэ улс төржиж болно оо. Та бас нэг танкчин гэдгээ мартаад хэрэггүй шүү дээ, Та.

Хоёрдугаарт яах вэ, мэдээж улс орон мөрөөдөлтэй байлгүй яах вэ. Үүнийг харин запруулаад дэмжээд хамтраад л явмаар байх юм. 17,5 хувь эдийн засагтай байсан үнэн л дээ. Нэг жилийн дотор тэг хувь болгосон шүү дээ, та хэд. Бонд босгоод бүгдээрээ нийлээд сайдууд чинь орж байгаад л хуваагаад авчихсан байна лээ шүү дээ, сая. Тэр өрийг чинь төлөх гээд л балраад явж байгаа шүү дээ, яг үнэндээ. Би ерөөсөө улс төржихгүй байхыг хичээгээд л байгаа. Улс төржөөд яриад байвал ч та хэд ч ер нь дуусгасан юм байна лээ дээ шулуухан л хэлэхэд. Энэ улс орныг. Харин ч бас Монголын ард түмэн бас ч гэж хүнд үед ингээд тийм нэгдмэл байдалтай байх энэ сонголтыг хийгээд явж байна. Түүнээс яг энэ үед та засаглаж байсан бол ч одоо юу болох байсан бол гэж хааяа бодохоор шулуухан хэлэхэд айдас төрдөг шүү, эрхэм танкчин ах минь.

**Г.Занданшатар:** Хариулт хангалтгүй л гэвэл. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Тодруулья гэж та хэлээгүй шүү дээ. Та чинь уг хэлчихсэн юм чинь, асуулт асуугаагүй юм чинь.

1 минут Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Би тэр гадаад валютын албан нөөцийн талаар асуусан. Түүнийг яагаад хариулахгүй байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт тэр нефтийг яагаад бензинийг арай бага үнээр авч болохгүй байна түүнийг асуусан. Яах вэ, дайн биш байх аа. Та нар ихэнх нь мөргөлдөөн гэж яриад байх шив дээ. Би тэр олон улсын хэллэгээр нь л мөргөлдөөн л юм болов уу гэж ойлгоод байгаа шүү дээ, тийм. Яах вэ, таны хэд хэдэн юмыг бол би дэмжиж байгаа. Тухайлбал тэр Оюу толгой бол зөв байсан. Тэр вакцины асуудал бол зөв

байгаа. Хамгийн сүүлд тэр 200 мянган доллар Украян улсад хандивалаа. Энд бол талархаж байна. Mash зөв зүйтэй ажил хийлээ. Хэдийгээр удаж байсан боловч. Тэгээд энэ бодлогоо та үнэхээр судалгаан дээр хийсэн үүнийгээ зөв гэж бодож байгаа юм уу? Үр дүнтэй гэж үзэж байна уу? Яг үүнийг хэн санаачилсан юм бэ? Засгийн газар уу? Эсвэл хэн нэгэн сайд нь уу?

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Одоо их зөв ярьж эхэлж байна, танкчин шиг ярьж байна. Тийм ээ, үүнийг бид нар хямралт байдал л гэж тодорхойлж байгаа. Хямралт байдал юм аа гэж бид түдгэлзсэн санал өгөөд үндсэндээ одоо бид нар төвийг сахиж ажиглаж байгаа. Энэ байдлаар явах нь Монгол Улсад хэрэгтэй гэж үзэж байгаа. Украян улсад хүмүүнлэгийн дэмжлэг үзүүлсэн. Та сая хэллээ, богино хугацаанд үр дүн гарна, алсдаа хүндрэх байх аа гээд. Шулуухан хэлэхэд богино хугацаанд үр дүн гарах нь өнөөдрийн нийгэм өнөөдрийн амьдралд илүү чухал байна аа гэж бидний хувьд үзэж байгаа. Энэ дээр би мэргэжлийн багийнхантай суусан. Ингээд богино хугацаанд энэ хүндрэлтэй хямралыг даван туулахад бага ч атугай хувь нэмэр оруулна аа гэж үзэж Ерөнхий сайдын хувьд итгэл үнэмшил авч оруулж ирсэн.

**Г.Занданшатар:** 83 Бядрангийн Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

**Б.Лхагвасүрэн:** Ганбат гишүүний асуултад хариульяа. Өнөөдөр Монгол Улсын валютын нөөц 03 сарын 31-ний байдлаар 3,3 тэрбум доллартой тэнцүү байна. Энэ нь бол Монгол Улсын импортын 6-7 сарын ийм хэрэгцээг хангах нөөц. Энэ бол олон улсын стандарт. Одоо жишгээрээ бол одоо хангалттай нөөцөө гэж байгаа. Монгол Улсын валютын нөөц 4,9 тэрбум доллар байсан. Одоо өнгөрсөн оны 4 сард. Тэгээд одоо манай урд хөрш БНХАУ ковидын ийм хатуу хөл хорио тавиад манай экспорт гаражгүй байгаатай холбогдуулаад ингээд нөөц бол ерөнхийдөө буурч явж байгаа. Тэгэхдээ тэр бараа бүтээгдэхүүн байхгүй болоод нөөц буурч байгаа биш, одоо бараа бүтээгдэхүүнээ хүргэж, одоо зарж борлуулж чадахгүй байгаатай л холбоотой гэдгээрээ энэ нөөц дээр дарамт үүсэж байгаа. Тэгэхдээ энэ дунд ерөнхийдөө энэ тодорхой бус байдалд нь одоо нөөцөө тодорхой хэмжээнд барих, одоо ханшийг тогтвортой байлгах үүднээсээ одоо олон улсуудаас бас ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Нөөц бол эргээд өсөөд өхэлсэн байна шүү дээ. 3,2-оос ирээд 3, одоо 4 гээд л явчихна. Одоо Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Тэр шатахууныг. 92 Гэлэнгийн Ёндон сайд хариулчихъя. Одоо бас хямдруулах асуудал яригдаж байгаа болохоор тийм ээ. 92.

**Г.Ёндон:** Ганбат шинэ асуултад хариульяа. Ер нь энэ хуулийн зориод хууль дотор газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой 3 асуудал байж байгаа. Нэгдүгээрт эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл, хоёрдугаарт урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлттэй зээл. Үндсэндээ энэ 2 дахь төрлийн зээлийг бол яг таны хэлж байгаа нэхцэл байдлаар бид нар бас урьдчилж байж л урьдчилсан байдлаар хоёр, гурав, дөрөв, таван сараар ч байдаг юм уу, урьдчилж оптима гэж ярьдаг бид нар тийм ээ, тийм бөөний байдлаар нь худалдаж авах байдлаар үнийг хямдруулах ийм л зорилготой орж ирсэн заалт. Яг л эндэхтэй одоо ярьж байгаатай адилхан гэсэн үг. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хүрэлбаатарын Булгантuya гишүүн.

**Х.Булгантuya:** 2019 оны 01 сараас ковид гараад л бид нар хилээ хааснаас хойш ер нь бол яг чөлөөт эдийн засгийн гол гол механизмууд ажиллахаа байж эхэлсэн л дээ. Эрэлт нь байлаа гэхэд нийлүүлэлтээ хийж чадахаа байсан. Ерээд онд тэр битгий л өөрсдөө Эрээн яваад аваад ирдэг байсан бараа бүтээгдэхүүнээ ч авч чадахаа байсан. Тээвэрлэгчид нь хамгийн хоорондоо үнээрээ өрсөлдөөд ядаж нэг тээврээ хийгээд зуучлаад хийчихдэг байсан тэр ажиллахаа байсан. Ерөнхийдөө бол өнөөдөр ингээд зах зээл рүү эдийн засаг руу чөлөөт эдийн засаг руу гар дүрэхэд мэдээж гэсэндээ хэцүү байгаа үнийг ингээд одоо нийлүүлэлтийг барья гэж зорьж байгаа нь хэцүү байгаа ч гэсэн дээ ингэхээс өөр бол одоо аргагүй байх аа. Одоо Орос, Украины энэ одоо дайныг байдаг юм уу, мөргөлдөөнийг хэзээ дуусна гэж бид нар харах уу. Дууссаны дараа бүх юм нормалжина гэдэг тийм хүлээлт ч гэсэн бид нарт бас байхгүй байгаа. Хил нээгдлээ, хил нээгдсэний дараа ч гэсэн дээ дэлхийн худалдаа бүх зүйл сайн сайхан явна гэдэг дээр бид нар ч гэсэн дээ бас одооноос эхэлж бodoх л хэрэгтэй. Тэр бол миний бодлоор ахиад, магадгүй нэгээс хоёр жилийн л дор хаяж хил нээгдсэний дараа ч гэсэн дээ. Дэлхий даяараа юм буцаад нормалдаа ортол нэгээс хоёр жил болно оо. Бүх юм одоо дайн дуусаад ковид гайгүй болсны дараа гэдэг тийм л хүлээлттэй байгаа шүү дээ ер нь.

Сая 22 оны 03 сард энэ бензин шатахууны хомсдол үүсгээд АНУ тэгээд 30 улс нийлээд 60 сая баррель стратегийн нөөцөөсөө дэлхийн зах зээл дээр гаргасан. Одоогийн дэлхийн зах зээл дээрх үнийг барих гэж, ахиад энэ дэлхийн зах зээл дээр ингээд гаргаад байх стратегийн нөөцтэй улс орон хэд байгаа юм бүү мэд. Тэгэхээр энэ бол ахиад нэмэгдэх одоо магадлалтай.

Хоёрдугаарт, энэ дайнаас үүдээд Орос, Украин хоёр бол дэлхийн улаан буудайн экспорт, дэлхийн одоо экспортын 30 хувь, өөрсдөө хэрэглээд ахиад цаана нь дэлхийн зах зээлд 30 хувийг экспортолдог. Наранцэцэгийн тосны 80 хувийн экспортлогч, ингээд ерөөсөө дэлхий дээр бол хүнсний үнэ нэмэгдэх нь тодорхой гээд дэлхийн улс орон болгонд л тодорхой хэмжээний тактик гаргачихсан байна, үнээ яаж барих вэ энэ тэр гээд Англид бол бензин шатахуунтай холбоотой татварын зарим нэг бодлогод татаас иргэдэд буцааж олгоно гэх гэх мэтчилэн. 2022 оны 02 сард НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага өмнөх оны хоёр сартай харьцуулах юм бол хүнсний гол нэрийн барааны үнэ бол 20,2 хувиар, 20,4 хувиар өссөн байна аа гэсэн ийм тоо баримтууд тооцоо судалгаанууд гаргасан байна аа. Тэгээд одоо бид нараас үл хамааран нэгэнт л дэлхий даяар ийм юм болж байгаа нь үнэн. Тэгэхээр бид нар үүн дээр одоо аль болохоор бэлтгэлтэй байгаа л одоо юмыг яаж мэдэх вэ, мэдээж юм сайнаар эргэвэл үүнийг заавал ашиглах албагүй, гэхдээ аж ахуйн нэгжүүд магадгүй 6 сарын дараа та нар яагаад үнээ нэмээд байгаа юм гээд Шударга өрсөлдөөний газарт өгч шалгуулж улс эх орноороо бүгдээрээ бухимдаж байснаар одооноос эхлээд арга хэмжээ авч байх нь төр засгийн хийх ёстой ажил шүү дээ. 6 сарын дараа жилийн дараа яагаад хийгээгүй юм бэ гээд ард түмэн асуухаар юу гэж хэлэх юм. Зах зээлийн эдийн засгийн ингээд хар гарпт бид нарт итгээд тэд нар зохицуулчих байх аа гэж бодож байсан юм аа гэж хэлэх юм уу. Өнөөдөр манай Нарантуулын наймаачид ч урагшаа яваад бараагаа авч чадахгүй шүү дээ. Тэгэхээр зах зээл, эдийн засаг ажиллахгүй байна гэсэн үг шүү дээ. Нөгөө бүх араа шүд механизмууд нь ойлгомжтой. Тэгэхээр одоо бид нар өнөөдөр төр засгаас гар дүрж харамсалтай нь оролцож, хамгийн наад зах нь одоо наад захын хэдэн бараа бүтээгдэхүүнүүдийнхээ үнийг барихаас л өөр аргагүй болж байна аа.

Тэгээд би Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас, одоо иргэд олон нийт үүнийгээ дагаад үйлдвэрлэл хийх сонирхолтой байна аа. Гэтэл одоо ингээд агуулах зорь нэмэгдүүлэх дээр ямар ажил хийж байна вэ. Дээрээс нь нэмээд хүлэмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх дээр ямар ажлууд хийж байна вэ? Хийх гэж төлөвлөж байна аа. Үүн дээрээс бид нар одоо төсөв дээр ч байдаг юм уу, зохицуулалт хийгээд дэмжлэг үзүүлэх боломж бий юу? Манай Баянзүрх дүүргийн иргэдээс үүнийг маш их хүсэлт тавьдаг. Улаанбаатар хотод нийлүүлэх хүсэлт байна. Зээл тусlamж одоо ямар юм, одоо зохицуулалт хаана байна вэ гэж их асууж байна аа. Үүн дээр Мэндсайхан сайдаас асуух гэсэн юм.

**Г.Занданшатар:** 94 Загджавын Мэндсайхан сайд.

**3.Мэндсайхан:** Булгантая гишүүний асуултад хариулъя. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хүнсээ дотоодоор хангах, мөн энэ дэд бүтцийг бий болгох, мөн энэ агуулах нөөцийн сүлжээг бий болгох энэ зорилтууд тусгачихсан байгаа. Тэгээд хүндрэл бол мөнгө л байгаа шүү дээ. Бид нар хүлэмж хийхээр бүх талаар судалж байна. Өвлийн хүлэмж өөрөө өртөг өндөртэй. Манай дээр одоо бидэнд хэрэгцээтэй байгаа 50 га дээр хүлэмж хийсэн тохиолдолд бид нар дотоодынхoo төв суурин газрынхаа нарийн ногооны дотоодын хэрэглээг хангана гэж тооцож байгаа. 1 га хүлэмж өөрөө 2,5-3,5 сая долларын өртөгтэй. Тэгээд энэ мөнгөний л асуудал байгаа. Тэгээд энэ дээр бид нар одоо Монголд байх зохимжтой аль бус нутагтаа байх ёстой юм. Энэ дээр бол загвар зураг төсвөө гаргаад ТЭЗҮ-гээ хийгээд бэлэн болчихсон. Зүгээр одоо үүнийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг бид нар хайж байна.

Зоорин дээр бол Польшийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд бас нэг энэ газар тариалангийн бус нутагт 8 мяняган тонн агуулах зоорийг барьчих гээд хөөцөлдөж байна. Одоо Польшийн талаас энэ зээлийнхээ хэлэлцээрийг сунгана аа гэх юм бол энэ ажлыг энэ онд нь багтаагаад эхлүүлчхээр л хөөцөлдөөд явж байна. Ер нь энэ хальсан хүлэмжийн хувьд бол бид нар өөрсдийнхөө бололцоогоор шийдвэрлээд явж байгаа. Энэ дээрээ бол одоо бид нар аж ахуйн нэгж, иргэддээ хөнгөлөлттэй нөхцөлөөр мөн одоо энэ хальсан хүлэмжийг нийлүүлэхэд бол одоо боломжтой байгаа. Өвлийн хүлэмж бол одоо хүндрэлтэй байгаа. Үүнийг бол одоо хийчихнэ ээ гэж хэлэхэд бол хүнд байна.

**Г.Занданшатар:** Хүрэлбаатарын Булгантая гишүүн тодруулж асууя.

**Х.Булгантая:** Сангийн сайдаас бас манай Мэндсайхан сайдын энэ ажил дээр жоохон дэмжлэг үзүүлээд нэгэнтэй эрэлт нь байгаа нийлүүлэлт нь бол энэ одоо зарим төрлийн ногоон дээр бол байхгүй болсон. Хот дагаад өнөөдөр энэ захын хороод дээр ажилгүй иргэд бол маш их байгаа, ийм өрхийн бизнес одоо нэг ногоо цагаахан тариад бид нар бас нийлүүлээд амьдарч бол болохоор байна аа гэж ярьж байна. Сая өнгөрсөн хагас сайн, бүтэн сайнд манай Баянзүрх дүүргийн хорьдугаар хороо Гачуурт руу явах зам дагуу байдаг маш том хүлэмж байдаг. Та бүхэн бас харсан байх иргэд зам дагуу, тэгээд энэ хүлэмж бол бүгдээрээ шатсан. Энэ цахилгааны асуудлаас болсон юм шиг байна лээ. Шатсан. Ингээд л иргэдийн маань зүгээс өмнө нь явж байсан энэ жоохон бизнес нь ч гэсэн дээ яг үнэнийг хэлэхэд үгүй болоод байгаа юм аа. Тэгэхээр Мэндсайхан сайд аа, яг хаана очиж энэ за бүр хальсан агуулах ч хамаагүй, хүлэмж ч хамаагүй барья гээд байгаа юм аа. Тэгэхээр хаана энэ асуудлыг хандах ёстой вэ? Нөгөө 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд банк дээр очно гэх үү? Тэгэхээр одоо бичиг цаас, хамаг юмнуудаа ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Мэндсайхан сайд 94.

**3.Мэндсайхан:** Засгийн газраас энэ хүнсний ногоо нарийн ногоо тариалалтыг нь нэмэгдүүлэхээр З хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл гаргасан байгаа. Өнөөдөр хүү, хүүгийн зөрүүгийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар эцэслэн шийдвэрлэгдсэн. Тэгэхээр энэ зээл олгогдох боломжтой болж байгаа. Хүнсний ногоо тариалагчдад зориулаад Засгийн газраас 50 тэрбум төгрөгийн эх үүсвэр гаргасан. Хоёр жилийн хугацаатай энэ зээлд одоо хамрагдаад явах боломж нь байгаа гэж хэлэх байна аа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Батсүхийн Саранчимэг гишүүн.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Тэгэхээр цар тахлын үр нөлөө одоо энэ Украян, Оросын энэ зэвсэгт мөргөлдөөн тэдгээрт бас авч байгаа энэ дэлхийн улс орнуудын арга хэмжээнээс шалтгаалаад Монгол Улсад үнэхээр одоо хүнсний болон энэ шатахууны үнийн асуудал бас тулгараад байгаа. Тэгээд саяхан би бас Баянзүрх дүүргийнхээ бүх хороодоор явж иргэдтэй уулзлаа. Тэд нарын гол одоо хэлж байгаа зүйл өнөөдөр өргөн хэрэглээний барааны үнэ бүр үнэхээр хэцүү, цалингаас хэтэрсэн хэтэрхий үнэтэй болоод байна аа. Ямар арга хэмжээ авах гэж байна аа гэдгийг бол их асууж байсан. Тэгвэл өнөөдөр бас энэ Засгийн газраас энэ асуудлыг шийдэх гээд энэ нөлөөллийг бууруулах гээд энэ хуулийн төсөл өргөн барьж байгааг бол дэмжиж байна аа.

Тэгэхээр ер нь энэ хуулийн төсөлд голчилж газрын тосны бүтээгдэхүүн, мах, гурилын хомсдол үүсэх, үнэ өсөхөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах нөөц бүрдүүлэх үнэ хангамж, нийлүүлэлтийн тусгай зохицуулалтыг оруулсан байгаа. Тэгэхээр энэ бол одоо хамгийн чухал. Одоо иргэдийн хувьд өнөөдөр бас ингээд хууль, эрх зүйн орчныг бүрдүүлээд өгөх юм бол бас их том дэмжлэг ээ гэж харж байгаа юм аа.

Манай улсын хүнсний бүтээгдэхүүний импорт 2021 он гэхэд одоо 962 сая ам. долларт хүрсэн байгаа. Үүнийг одоо Европ улсаас 57,3 хувийг, Оросын холбооны улсаас 35,8 хувийг бас импортолсон байгаа. Тэгэхээр жилд бол 700 гаруй нэр төрлийн энэ хоёр зуун дал мянга гаруй хүнсний бүтээгдэхүүн одоо бид импортолдог. Тэгэхээр үүнийг бол одоо Замын-Үүд болоод Алтанбулагийн боомтуудаар л авдаг. Тэгвэл энэ нөхцөл байдлаас шалтгаалаад өшөө одоо тээвэр ложистикийн өөр гарцын асуудлыг энэ хуульд бас тусгасан байгаа юу? Бид нар одоо саяхан л Эрээний хилийг хаахад бид нарын хувьд ч гэсэн бас ямар хэцүү боллоо. Тэгэхээр энэ тал дээр бас төсөлдөө оруулсан байгаа юу гэсэн нэг ийм асуулт байна.

Нөгөө талаар энэ валютын ханш 3000 гаруй болчихлоо. Валютын ханшийн энэ өсөлт бүх л төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ өсөхөд бас нөлөөлж байгаа. Тэгэхээр валютын ханшийг тогтвортой байлгахад энэ тал дээр бас төсөлд ингэж тусгаж өгсөн үү? Арга хэмжээ авахаар ингэж тооцоолж байгаа юу? Монголанкнаас энэ талаар асууя.

Юуны өмнө бас иргэдийнхээ өмнөөс яг өнөөдөр бас ингээд Засгийн газар яг шаардлагатай үед хурдан хугацаанд энэ арга хэмжээ авах гээд хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж байгаад бас талархаж байна аа. Амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Монголбанк, 83 Бядрангийн Чулуунбат Ерөнхийлөгч.

**Б.Лхагвасүрэн:** Саранчимэг гишүүний асуултад хариульяа. Тийм ханш жилийн өнгөрсөн оны мөн үүнтэй харьцуулах юм бол 5,5 хувиар супларсан байна л даа. Тэгэхээр ер нь бол Монгол төгрөгийн ханш бол жилдээ өрөнхийдөө бас нэг ийм 4-5 хувиар, 2018, 19, 20 онуудад ингээд суплраад явж байсан. 21 он, 20 оны хоёрдугаар хагасаас хойш бол ер нь нэлээн тогтвортой байсан. Тэгэхээр бол төгрөг бол өөрөө бас яг энэ хатуу валют буюу тэр АНУ-ын доллар ч юм уу энэ олон улсын нөөцийн валютын эсрэг бол мэдээж тодорхой хэмжээгээр ингээд суплраад явдаг л ийм Монгол улсын эдийн засгийн өөрийнх нь ийм тогтолцоо одоо зүй тогтол бол байгаа юм. Тэгэхдээ бидний хувьд бол 5,5 хувиар супларсныг бол ийм огцом супларсан гэж үзэхгүй байгаа Төв банк. Ер нь бол энэ бол байх л одоо жилийн хугацаанд бол ийм хэмжээний суплралт бол байх л үзүүлэлт гээд ханш бол өрөнхийдөө тогтвортых ийм боломжтой болж ирж байгаа. Ялангуяа саяын энэ импорт нэлээн өссөн экспорт тоо бид хэд гаргаж чадахгүй байгаатай холбоотойгоор бас нэг ийм эрсдэл байсан. Тэгэхдээ үүнийг бол одоо богино хугацааны гаднаас хөрөнгө татаж оруулах, нөөцөө тодорхой хэмжээнд барих энэ бодлогынхоо хүрээнд бол тогтвортой барьж чадахаар байгаа. Энэ одоо орж ирж байгаа хууль дотор бол ялангуяа тэр нефтийн бүтээгдэхүүнийг одоо ханшийнх нь савлагаагүй байдалтай байхаар Монголбанкны журмын хүрээнд форворт своп хэлцлийн хүрээнд бол тогтвортой байлгахаар ингээд заалт орчихсон байгаа.

**Г.Занданшатар:** Бoomт, хил боомтыг хэн хариулах юм. Болдын Жавхлан сайд 2 минут.

**Б.Жавхлан:** Саранчимэг гишүүнд баярлалаа. Бoomтын асуудалд санаа зовж хэлж байгаа нь их зөв өө. Гэхдээ ийм юм байгаа юм шүү. Энэ хуулиар болбол бид нар яг энэ 3 гол стратегийн одоо яг хүнд байгаа гэж байгаа энэ 3 дээрээ л анхаарья гэж байгаа юм. Мэдээж тээвэр ложистикийн асуудал, ялангуяа хилийн боомтын түгжрэлийн асуудлыг шийдэх бол бидний одоо дунд хугацааны хамгийн том чухал зорилтуудын нэг. Эдийн засгийн 6 сэргэлтийн маань хамгийн чухал, одоо суурь сэргэлтийн нэг байгаа юм аа. Тэгэхээр энэ одоо бид 6 сэргэлтийнхээ Улсын Их Хурлын тогтоолыг гаргачихсан, хөтөлбөрөө баталчихсан, программаа баталчихсан. Засгийн газар үүнийхээ дагуу хийх ажлынхаа төлөвлөгөөг баталчихсан, энэ ажлууд бүр яг ингээд зэрэгцээд явж байгаа. Одоо бид энэ богино хугацааны энэ асуудал хүндрэлүүдээс л шийдэж гаргах хэрэгтэй юм байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ богино хугацааны асуудлууд маань нөгөө боомтын дунд хугацааны зорилтуудыг маань ингээд алслуулахгүй, төлөвлөгөөг маань тасалдуулахгүй, тасалдууллаа гэхэд одоо богино байх энэ бүх одоо шийдлүүдийг энэ хуулиар хийж байгаа юм шүү. Тэгэхээр энэ хууль бол түрүүн бас нэг бас асууж байсан. Энэ бол энэ жилийн л зорилтын асуудал юм байгаа юм богино хугацааны. Урт хугацаанд үйлчлэх хууль бол биш тийм. Тэгэхээр боомтын асуудлууд дээр бол зэрэгцээд олон төрлийн арга хэмжээнүүд явж байгаа.

**Г.Занданшатар:** Одоо Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

**Ц.Сандаг-очир:** Баярлалаа. Жил гаруйн өмнө Ерөнхий сайд, Засгийн газрын зүгээс Их Хуралд ковидын талаар авах арга хэмжээний талаар хууль оруулж ирж байсан. Их Хурал дэмжээд өгсөн. Үр дүн бас гарсан гэж ингэж үзэж байгаа. Тэгвэл өнөөдөр бас Ерөнхий сайд маань бас Их Хурлаасаа дэмжлэг хүсэж байна. Энэ олон улсын нөхцөл байдлаас үүдэлтэй бараа бүтээгдэхүүний хомсдол, үнэ ханшийн өсөлттэй холбогдуулж тодорхой арга хэмжээнүүдийг авъяа гэж. Үүнийг нь дэмжээд өгөх нь зүйтэй гэж ингэж үзэж байна. Гагцхүү харин ямар үр дүн гарагыг нь харин харах, хүлээх, түүнд нь дүгнэлт хийх ёстой. Төр ямар үед эдийн

засагт оролцох ёстай юм бэ гэж. Гагцхүү харин манайхан бол харин хувийн хэвшлийнхнийхээ урдуур ороод бизнесийг нь хийгээд, ажлыг нь аваад ингээд дургүйг нь хүргээд байдаг. Харин гагцхүү өнөөдөр яг ийм цаг үед төр эдийн засагт оролцооч ээ гэж хувийн хэвшлийнхэн, ард иргэд үнэхээр их хүсэж байна. Энэ үнэ ханшийн өөрчлөлтөө зогсоогооч ээ, бараа бүтээгдэхүүний эрэлтээ нэмэгдүүлээч ээ, нийлүүлэлтээ нэмэгдүүлээч ээ гэж. Тийм учраас зайлшгүй энэ Үндсэн хуулиар олгогдсон өнөөдөр үнэхээр төр Их Хурал, эдийн засгийг зохицуулах үүрэгтэй Засгийн газрын тухай хуулиараа Засгийн газар зохицуулах ийм одоо үүрэгтэй, энэ үүргээ л хэрэгжүүлэх ёстай нөхцөл байдал нь үүссэн юм байна аа гэж ингэж харж байгаа.

Юу үнэн гэвэл харин энэ уул уурхай цаашдаа манай улсын эдийн засгийн бат найдвартай эдийн засгийн салбар биш байна шүү гэдгийг харуулж байгаа, энэ алт чинь биш байна шүү гэдгийг харуулж байгаа. Харин юу үнэн бэ гэхээр энэ жилийн 4 улиралд хөдөө хөхөрч, гадаа гандаж явдаг энэ малчдын маань энэ мал мах, энэ хөлсөө дуслуулан байдаг жилийн 4 улиралд гадаа байдаг энэ газар тариалан эрхлэгчдийн маань энэ салбарынхан маань цаашдаа Монгол Улсыг тэжээсээр байсан, цаашдаа найдвартай тэжээж явах юм байна аа гэдэг нь эндээс харагдаж байна аа. Тийм учраас цаашдаа энэ Улсын Их Хурал, Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарт хийгдэх энэ хөрөнгө оруулалт, бодлогоо үнэхээр дорвигийхон түрүүн тэр Булгантуяа гишүүний хэлж байгаа айл болгон өөрсдийнхөө хэрэглэдэг хүнсний ногоогоо тарьчихдаг бол тэр ноль долоон га-гаа зөв ашиглачихдаг бол ийм асуудал үүсэхгүй ээ. Тийм учраас өрх үрийг цаашдаа хүлэмжийн ногоо эрхлүүлдэг байх, энэ одоо газар тариалангийн бүс нутгуудад байгаа аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмждэг байх энэ бодлого цаашдаа үнэхээр одоо ямар ч маргашгүйгээр, эдийн засаг, ард түмнийг олон жил цаашдаа улс орноо аваад явах найдвартай салбар юм байна аа гэдгийг харж байна. Тийм учраас энэ салбарын бодлого цаашдаа тодорхой байх ёстай юм байна аа. Сая одоо Мэндсайхан сайд бодлого байгаа гэж ярьж байна. Яг үнэнийг хэлэхэд би өнгөрсөн засаг даргаар ч ажиллаж байхдаа өнөөдөр ч гишүүн болоод хоёр жил дүүргийнхээ нэг, хоёр одоо аж ахуй нэгжүүдэд хүлэмжийн 4 улирлын хүлэмж олж өгөөд чадахгүй л явж байна яг үнэнийг хэлэхэд. Яг энэ хүнсний хомсдолоос үүдэлтэй энэ зээл яваад байгаа л гээд байна, энэ зээлүүд эзэндээ очихгүй байна аа, авч чадахгүй байна аа. Тийм учраас энэ бодлого хэрэгжсэнээр цаашдаа ийм хүсэл хийх зорилготой, мэргэжилтэй хүний нөөц нь байгаа энэ салбаруудад л хөрөнгө оруулалтаа зөв хүнд нь олж өгөх ёстай байна. Түүнээс танил тал, найз нөхдөөрөө явчихдаг асуудал өнгөрсөн хугацаанд яаж гарсныг бид бүгд мэдэж байгаа. Тийм учраас энэ хөнгөлөлтийн бодлого энэ зээлийн бодлого иргэнээ л олохгүй байна гэдгийг олон дахин яриад байна. Үүнийг цаашдаа л энэ Их Хурал дээрээс хууль баталдаг, цаашлаад хуулийг дагасан, журмууд хэрэгждэг журам дээр очоод л, дунд шатанд төрийн бодлого замхардаг, ингээд төрийн бодлого иргэддээ хүрч чадахгүй ийм л байдалтай явж ирсэн. Энэ ахиад давтагдчих вий гэж одоо эмээж байна аа. Тийм учраас энэ тал дээр цаашдаа маш сайн анхаарч өгөөч ээ л гэж хүсэж байна. Миний хэлж байгаа санал байна аа, баярлалаа.

**Г.Занданшатар:** Санал хэллээ, баярлалаа. Одоо Цэндийн Мөнх-Оргил гишүүн алга байна. Баагаагийн Battömör гишүүн асуулт асууяа аа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн бас алга байна. Цэндийн Мөнх-Оргил гишүүн алга байна. Баагаагийн Battömör гишүүн.

**Б.Баттөмөр:** Засгийн газраас оруулж ирж байгаа энэ саналыг болбол дэмжиж байна аа. Ер нь бол энэ хүндрэлтэй асуудлыг даван туулахын зэрэгцээ

шийдэх асуудлаа бас шийдэж явах нь зүйтэй гэж Алсын хараа 2050-д орсон тэр зорилтуудыг хэрэгжүүлэх, богино хугацаанд дунд хугацаанд хийх ажлуудаа барьж авч ажиллах нь зүйтэй гэж ингэж үзэж байна аа. Энэ Засгийн газрын хувьд болбол үнэхээр бас тийм хүнд нөхцөлд ажиллаж байна л даа. Ковидтой холбоотой асуудал, энэ Украян, Оростой холбоотой асуудал, үүнээс үүдэлтэй дэлхийн хямрал энэ 1929 онд нэг айхтар хямрал болсон юм гэсэн. Түүнээс одоо дараа болж байгаа хамгийн одоо их том хямрал энэ гэж ингэж үзэж байна л даа. Энэ хямрал болбол энэ Засгийн газрын үед болбол тохиож байна л даа. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид нар өр үйлдвэрлэсэн л дээ. 33,2 тэрбум долларын өртэй байна, одоо өнөөдөр харин энэ Засгийн газрын үед өрөө багасгах чиглэлд Засгийн газрын өрийн хэмжээ жаран хоёр, гурван хувь байснаа дотоодын нийт бүтээгдэхүүний, өнөөдөр тавин нэгэн хувь болж буурсан байна. Тэгэхээр энэ бол бас ололт амжилт юм аа гэж. Тэгэхээр энэ ойрын хугацаанд төлөх бас нэг өрүүд байна л даа. Тухайлбал юу гэхээр энэ Чингис бондын тийм евро бондын 580 байна. Самурай бондын одоо өр байна. Дээрээс нь Хятадын Хөгжлийн банкны өр гээд ингээд 2,5 их наяд төгрөгийн өр төлөгдөх, одоо төлөгдөх эрх 23 ондоо багтаж төлөх ёстой бид нар. Тэгэхээр энэ өрүүд маань их төвөгтэй байна. Төлбөрийн тэнцлийн хямралыг үүсгэх вий дээ гэсэн ийм болгоомжлол байна. Энэ дээр одоо манай Сангийн яам одоо юу гэж бодож байгаа юм. Манай Жавхлан сайд энэ дээр хариулна биз.

Дараагийн асуудал бол нөгөө хүн хоёр хөл дээрээ явдагтай адилхан энэ эдийн засаг маань одоо хоёр хөлтэй байх ёстой. Энэ хөрөнгийн зах гэдэг юм ерөөсөө огт хөгжөөгүй Монголд. Энэ хөрөнгийн захыг хөгжүүлэх чиглэлд одоо бас юу хийж болох вэ? Өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн нэг ерэн хэдэн хувь нь одоо банк дээр тогтох байна шүү дээ. Тэгэхээр энэ хөрөнгийн захыг хөгжүүлэх энэ чинь нэг жаран хувь нь банк дээр, гучин хувь нь хөрөнгийн зах, арван хувь нь нэг даатгал гэсэн нэг ийм дэлхийн нэг жишиг, дундаж тоо байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг бид хөрөнгийн захын даатгалын салбарыг хөгжүүлэх чиглэлд одоо юу хийгдэх вэ гэж Сангийн сайд, хөгжлийн сайдын одоо түр орлон гүйцэтгэгч одоо сайдаас асууж байна аа.

Энэ гадаадын шууд хөрөнгө оруулалт Монгол Улсыг тойроод байгаа. Сая яах вэ, Ерөнхий сайд бас сүүлийн үед гадаадын хөрөнгө оруулалт бас Монгол руу чиглэх урсгал болбол нэмэгдэж байгаа гэдэг ийм ойлголтыг өглөө. Тэгэхээр энэ гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцооны реформыг хийх шаардлагатай. Яагаад одоо ингээд багасав? Энэ чинь одоо үндсэндээ өр нь сүүлийн арваад жилийн хугацаанд л тогтмол буураад явчихлаа шүү дээ, тийм. Тэгэхээр зэрэг үүнийг цаашдаа дэмжиж үүнийг сайжруулах чиглэлд юу хийж болох вэ гэсэн ийм асуулт байна. Юу хийгдэж байна аа гэж. Тэгээд энэ гадаадын шууд хөрөнгө оруулалтуудаа одоо бий болох их олон шалгуур байна л даа. Үндэсний мөнгөн нэмдэгт нь одоо тогтвортой байх, инфляц бага байх, ажиллах хүчин хямд байх, хууль, эрх зүйн орчин нь одоо сайн байх гээд гол нь үзүүлэлтүүд байдаг. Тэгэхээр энэ болгоныг одоо юу гэж тооцож байна аа гэж.

Энэ ашигт малтмалын нэмүү өртөг шингээх чиглэлд энэ уул уурхайн биржийг байгуулъя гэсэн ийм санал энд хуулийн төсөл яваад байгаа. Үүнийг Улсын Их Хурал ойрын хугацаанд хэлэлцэж баталж өгөх ийм шаардлага ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт хангалтгүй бол 1 минут л нэмж өгнө. Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Баттөмөр гишүүн чухал асуулт асуулаа. Манайх гадаад өрийн стратегийн гүйцэтгэл маш сайн явж байгаа. Mash сайн явж байгаа. 19-2022 оны хоорондох гадаад өрийн дунд хугацааны стратегийнхаа хүрээнд маш сайн сахилга баттай явж байгаа. Бид гадаад өрөө, бизнесийн зориулалттайгаар ямар нэг одоо Засгийн газрын өрөө огтхон ч нэмэгдүүлээгүй. Харин ч төсвийнхөө боломжит хэмжээгээр, жил бүр 200-300 сая доллароор нийт өрөө бууруулаад явж байгаа.

Манай Засгийн газрын нийт өр маань нэг 8,2 тэрбум доллар орчим байгаа. Манай дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ өнөөгийн үнэ цэнээр тооцох юм болбол өнгөрсөн оны жилийн эцсээр 51 хувьтай гарсан, 51 хувьтай. Төсвийн тогтвортой байдлын хуулиар тусгай шаардлагын хязгаараар 70 хувь байх ёстой, бид 51 хувь гаргасан, өөрөөр хэлбэл төсвийнхөө хязгаар дотор хангалттай багтаад цаашдаа нэмэхгүй, энэ хэмжээндээ байлгаад явуулах ийм стратегитай байгаа.

Ойрын хугацааны өрүүд гэх юм бол өр нь энэ 4 жил 90 оноос хойш энэ 30 гаран жилийн хугацаанд Засгийн газрын өрийг төлөх хамгийн өндөр ачаалалтай 4 жил байгаа. Бид нар 4 гаруй тэрбум доллар төлнө. Үүнийг өнөөдрийн байдлаар маш амжилттай бид зохицуулалт хийгээд явж байгаа. Өнгөрсөн онд бид нар Сентури бондод тэрбум доллар гаргасан. Ингээд тулчихсан байсан хэд хэдэн өрүүдийг хугацааг нь хойшилуулж, хүүг нь маш амжилттайгаар бууруулж төсвийн дарамтыг бууруулж чадсан байгаа. Чингис бондын энэ оны одоо эцсээр 140 сая долларын үлдэгдэлтэй байгаа. Үүнийг бид төсөв дээрээс шууд төлчихнө. Ингээд нөгөө олон жил болж байгаа Чингис бондын маань төлбөр тооцоо гадаад талдаа ингээд бүрэн дуусаж байгаа юм аа.

Ирэх жил нэг эрсдэлтэй зүйл байгаа. Тэр бол одоо энэ Хөгжлийн банкны Самурай бонд байгаа Самурай бонд. 30 гаран тэрбум юань, төгрөгөөр бол одооны ханшаар нэг 800 дөхчих 770-аад тэрбум төгрөгийн ийм гадаад өр байгаа. Энэ бол Хөгжлийн банкны Засгийн газрын баталгаатай өр, хэрвээ Хөгжлийн банк өөрөө төлж чадахгүйд хүрвэл Засгийн газар төлнө. Төсөв дээрээс төлөх ийм маш том аюул, эрсдэл үүснэ. Тийм учраас Хөгжлийн банкны чанаргүй зээлийг одоо нэг жил гаруйн хугацаанд дор хаяж энэ хэмжээнд төлүүлэх хамгийн чухал зорилт байгаа юм. Хамгийн чухал зорилт байгаа, гадаад өрийн хувьд. Ойрын хугацаанд гадаад өр дээр гарч болзошгүй эрсдэл ийм байна. Бусдаар бол манай гадаад өрийн стратеги болбол маш сайн явж байгаа. Өнгөрсөн жил Сентури бондыг гаргасны амжилтад гаргасны үр дүнд гадаад зах зээл дээр манай энэ бондыг маш сайн үнэлж манай гадаад өр, тэр гадна зах зээл бол манай хүүгийн өгөөж бол маш сайн явж байгаа. Зээлжих зэрэглэл тодорхой хэмжээнд буурсан ийм байгаа.

Хөрөнгийн зах зээлийн хувьд бас Баттөмөр гишүүн асуулаа. Хөрөнгийн зах зээлийг болбол Засгийн газар төсвийн бодлогоор бол маш сайн дэмжиж явна аа. Энэ дээр төв банкны бодлогодоо бол шууд 100 хувь харилцан уялдаж хамтарч дэмжиж ажиллана аа. Хөрөнгийн зах зээл дээр бол зах зээл, төсвийн оролцоо бол харьцангуй бага байдаг. Төв банк, арилжааны банкнууд бусад төсвийн бус банкны бус санхүүгийн оролцогч нарын идэвхжлийг сайжруулах тэр санхүүгийн зохицуулах хорооны бодлогууд их чухал. Бидний оролцож болох хязгаарлагдмал боломж, зүйлүүд нь бол Засгийн газрын үнэт цаас одоо урт богино хугацаатай, дотоодын зээллэгийн. Ийм зах зээлийг бид одоо энэ жил мөн хөгжүүлье, дэмжье гэдэг үүднээс дотоодын бонд гаргах, бенчмаркаа тогтоох ийм бодлогуудыг 22 оны төсвийн хуульд шингээж өгсөн байгаа. Засгийн газрын үнэт цаас 2 тэрбум төгрөг хүртэлх гаргах боломжтой, жилдээ төлөгдөх гээд. Мөн энэ хуультай холбоотойгоор зүгээр төсвийн яг бусад зорилгоор өөрөөр хэлбэл энэ одоо зарим нэр төрлийн

чухал стратегийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зорилгоор шаардлагатай ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Болсон уу. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна аа.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Монголын төр засаг, Монголчууд биднээс шалтгаалахгүй урьдчилан тооцоолж байгаагүй ийм нөхцөл байдлууд бий болж байна л даа. Засгийн газар 2 жилийн хугацаанд коронавирустэй амжилттай тэмцэж, үр дүн нь гарсан гэдгийг та бүхэн маань мэдэж байгаа.

Өнөөдөр бол одоо Ази тивд улбар шар зэрэглэлээс шар луу шилжсэн анхны орон болчоод байж байна. Тэгтэл бол бусад оронд буцаад хөл хорио тогтоочихсон халдварт нэлээн тархчихсан ийм хүнд байдал эргээд үүсэж байна. Дэлхий дээр та бүхэн маань мэдэж байгаа 492000000 хүн коронавирусийн халдварт авч, сая гаруй хүн амь насаа алдсан ийм хүнд нөхцөл байдалтай байгаа. Тэгвэл Монгол Улс хүн амынхаа 96 хувийг нэгдүгээр тунд, 92 хувийг нь хоёрдугаар тунд, 53 хувийг нь гуравдугаар тунд хамруулчхаад үүний үр дүнд өнөөдөр бид нар нээлттэй үйл ажиллагаа явуулах ийм боломжтой болсон. Ковидын улмаас үүссэн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах гээд явж байтал ингээд мөн тооцоолоогүй байсан ийм одоо дайны нөхцөл байдал үүслээ. Би Засгийн газарт, Ерөнхий сайдад итгэж байгаа. Ковидын нөхцөл байдлын ард бол гарч чадсан бид. Дэлхийн жишиг орон болж чадлаа. Одоо бидний тооцоогүй байсан энэ одоо олон улсад үүссэн хурцадмал нөхцөл байдлаас улбаатай эдийн засгийн хүндрэлийг хэрхэн яаж даван туулах вэ, ард түмнээ яаж сөхрүүлэхгүй байх вэ, яаж өлсгөлөнд нэрвэгдүүлэхгүй байх вэ гэдэг ийм хуулийн төслийг цаг алдалгүй оруулаад ирлээ. Мэдээж хэрэг бүх бараа бүтээгдэхүүний үнийг чөлөөлөх боломжгүй. Монголчуудын гол хэрэглэдэг стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн гэдэг гурил, мах, бензинийхээ асуудлыг ямар ч байсан үнийг нь тогтвортой байлгая, нөөц бүрдүүлээд авья гэдэг энэ арга хэмжээг хамгийн түрүүнд авах гэж байна. Би талархаж байгаа, олон хүн талархаж байгаа байх. Хэрвээ бид нар мах, гурилынхаа үнийг дийлэхээ болиод хоолгүй болбол юу болох вэ? Хүүхдүүд минь өлсөөд сууж байвал бид яаж одоо амгалан тайван амьдрах юм болж байна. Ийм байдалд оруулахгүйн тулд Засгийн газар нөхцөл байдлыг урьдчилж хараад, тооцоо судалгаа хийгээд оруулаад ирж байгаад бол би эх хүн, эмэгтэй хүний хувьд бол үнэнхүү талархаж байна.

Ганц миний асуух гээд байгаа зүйл юу вэ гэвэл манай аливаа энэ Засгийн газар, Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хэрэгжүүлэх шатандаа нугалаатай учирдаг завхрал үүсдэг. Үүнийг та бүхэн маань ер нь хэр урьдчилж харж чадаж байгаа юм бэ? Түрүүн зарим гишүүд асуугаад байна лээ. Хөнгөлөлт авчхаад өөртөө давуу боломж бий болгочоод эргээд янз бүрийн шалтаг хэлээд, бидний нөгөө хүрэх гээд байгаа зорилгыг хөсөрдүүлээд хаячих вий гэдэг ийм асуудлыг ярьж байна. Үүнийг урьдчилан хэрхэн яаж тооцож байгаа юм бэ гэдэг талаар эхлээд би нэг хариулт аваад дараа нь тодруулья, баярлалаа.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан Сангийн сайд.

**Б.Жавхлан:** Сарангэрэл гишүүний асуултад хариулья аа, их чухал аа. Бид нар ийм том улс төрийн эрсдэл аваад ийм хууль бужигнуулж одоо олон хүлээлт бий болж гаргачаад үр дүн гарахгүй бол маш харамсалтай зүйл болно. Энэ бол ерөөсөө батлагдмагц бид одоо ингээд яг төлөвлөгөөн дээрээ сууж байна. Үр дүн

гараад эхлэх ёстой. Үр дүн гараад эхлэх ёстой. Тийм учраас энэ нөгөө богино хугацааны үйлчлэлтэй ийм задлахгүй олон хүнс олон бүтээгдэхүүн хамруулахгүй хумиад яг ингэж төвлөрч чадах бид хариуцаж чадах үр дүн гарч чадах энэ хүрээнд л энэ хуулийнхаа үйлчлэлийг хийж байгаа юм.

Дээрээс нь яг тэр аж ахуйн нэгжүүд, ялангуяа тэр тусгай зөвшөөрөлтэй ийм олон аж ахуйн нэгжүүд энэ одоо хуулийн үйлчлэлд хамрагдана. Нийгмийн хариуцлага маш чухал. Өмнөхүүдээс ялгаатай нэг зүйл энэ хууль дээр орсон нь тэр аж ахуйн нэгжүүдтэй хариуцлагын гэрээ байгуулна аа. Хариуцлагын гэрээ бол нийгмийн хариуцлагын гэрээ. Тусгай зөвшөөрөлтэй нь ярина, тусгай зөвшөөрөлтэй нь ярина. Энд ямар нэг тийм бизнесийн ашиг сонирхол олох тийм богино хугацааны одоо арбитрийн шинжтэй зүйл огтхон ч аиж болохгүй огтхон ч байж болохгүй. Тийм учраас цэвэр, яг нийгмийн хариуцлагаар энэ тусгай зөвшөөрөлтэй ийм одоо аж ахуйн нэгжүүдийн үед энэ хүнд үед энэ одоо нийгмийн ачааллыг цуг үүрэлцээд, ингээд цугтаа даваад гаръяа аа гэдэг ийм зарчмаар хуульд оруулсан байгаа. Тийм энэ дээр бид нар маш анхааралтай, одоо өмнөх алдааг давтахгүй. Өмнө нь одоо хар жагсаалтад орсон ийм аж ахуйн нэгжүүдтэй бол одоо хамтарч ажиллахгүй ийм зарчим баримтална.

**Г.Занданшатар:** Сарангэрэл гишүүн 1 минут тодруулъя.

**Д.Сарангэрэл:** Өнөөдрийн үүссэн нөхцөл байдал дан ганц Засгийн газрын асуудал биш л дээ. Энэ бол бүх Монголчуудын асуудал, дэлхий нийтийн асуудал, иргэн бүр, айл өрх бүрийн асуудал болж байгаа учраас энэ хөтөлбөрийг бид маш хариуцлагатай, одоо хэрэгжүүлэх ёстой гэж нэгдүгээрт үзэж байгаа юм. Өнөөдөр хүнснийхээ хангамжийг шийдсэн гэдэг Герман улс гурилгүй болчихсон байна. Оросын холбооны улс элсэн чихрийн эрэлд мордсон байна. Тийм учраас бид бол энэ асуудалд маш ноцтой, маш хариуцлагатай хандах ёстой гэдгийг би дахин дахин хэлээд байгаагийн учир нь ийм. Тийм учраас бид хуулиа мэдээж хэрэг дэмжинэ. Хамгийн гол нь хэрэгжилт дээр нь Засгийн газар маань хатуу хяналт тавьж ажиллаарай гэдгийг дахин хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн алга байна. Хаслаа. Бөхчупууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** 2012-16 онд үнэ тогтвортжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан. Энэ одоо хөтөлбөрт нийтдээ 7,5 их наяд төгрөг зарцуулаад нийтдээ хоёр мянгаад аж ахуйн нэгж үүний үр дүнд ажлын байраа нэмэгдүүлэх, хадгалах, мөн түүнчлэн эргэлтийн сайн хөрөнгөтэй байсан учраас тодорхой хэмжээний үйл ажиллагаагаа сайжруулж, татварын орлого нэмэгдэж нэлээн сайн үр дүн авчирсан л даа. Тухайн үед бол уул уурхайн бүтээгдэхүүн бол дөнгөж одоо, жишээ нь нүүрс гэхэд 25 доллароор л зарагддаг байсан. Энэ үед бол энэ маш чухал хөтөлбөр байсан. Үүний үр дүнгээр одоо аж ахуй, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сайжраад, 16-20 он өнөөдрийг хүртэл одоо аж ахуйн нэгжүүд татвараа сайн төлж байна гэдэг бол үүний үр дүн гэж хардаг. Тэгэхээр алдаа юу байсан бэ гэхээр Эдийн засгийн байнгын хорооноос нэг бичиг яваад л, тэгээд л болчихно гэж бодсон. Энэ бол Золжаргал, Алтанхуяг нарын алдаа л даа. Харин үүнийгээ одоо засаад ингээд Их Хурлаар хэлэлцүүлж байгаа нь зөв гэж харж байгаа. Тэгээд энэ 12-16 онд явсан энэ хөтөлбөрөөр бол дэндуү улс төржсөн. Бүтэн 4 жил 12-16 онд улс төржсөн дээрээс нь өнөөдрийг хүртэл улс төржөөд сууж байгаа. Тэгээд энэ улс төрждөг юм, улс төрждөггүй хүн гэж бас байгаа л даа. Тэгэхээр одоо яг энэ хөтөлбөртэй адилхан ийм үнэ тогтвортжуулах ийм хөтөлбөр орж ирж байгаа юм.

Нийтдээ 550 тэрбум төгрөг орчим төгрөг зарцуулах юм байна. Монгол том болсон энэ 550 тэрбум гэдэг бол нэг их тийм айхтар мөнгө биш. Тэгээд нэг шатахуундаа 250, одоо гурил махандаа 300-аад тэрбум зарцуулах юм шиг байгаа юм.

Тэгээд зарим нь мөнгө хэвлэнэ гээд байгаа юм. Монголбанкны бодлогын хүү 6,5 байж байгаад тэнд чинь одоо 10 их наядын хөтөлбөр, 5 их наядын хөтөлбөр, дээрээс нь одоо Эрдэнэтээс 2 их наяд, Оюу толгой 1 их наяд, засаг дээр асар их төгрөг байж байгаа. Тэр нэг гурван хувиар бодлогын хүү нэмэгдүүлчихээр тэр хөрөнгө чинь буцаад татагдаж байгаа. Тэндээсээ л энэ мөнгө зарцуулагдана гэж би ойлгож байгаа. Тийм учраас мөнгө хэвлэнэ гэж зарим хүмүүс улс төржөөд байх шиг байна. Тийм юм байхгүй. Мэдээж энэ бол улс төр, уламжлалт бус арга, уламжлалт бус арга. Энэ зарим хүмүүс бол үүнтэй санал нийлдэггүй. Тэгэхдээ өнөөдөр энэ пандемик-ийн дараа энэ дайны дараа бол энэ шатахууны үнэ ямар үнэтэй болох юм. Украин одоо гол буудай нийлүүлэгч ямар үнэтэй болохыг бид нар мэдэхгүй шүү дээ. Тийм учраас энэ арга хэмжээг авч байгаа нь зөв л гэж би харж байгаа. Тэгээд хамгийн гол нь аж ахуйн нэгжүүдээ ингээд энэ хөтөлбөрийг хэрэгжүүл гэчхээд, заримд нь магадгүй эрсдэл гарч магадгүй, түүнийг нь ингээд дараа нь ингээд л янз янзын хууль хяналтын байгууллагаар шалгуулаад л, дээрэлхээд л ингээд байж болохгүй шүү гэдгийг хэлье.

Би бол энэ дээр бол дэмжиж байгаа. Гэхдээ би бол энд хамгийн гол нь оны эцэс гэхэд ямар үр дүн гарсан бэ гэдэг дээр бол маш хатуу хариуцлага нэхнэ ээ. Харин би улс төржихгүй 24 онд шинэ сонгуулиараа би энэ сэдвээр огт улс төрчихгүй. Яагаад гэвэл энэ бол онцгой тохиолдол oo л гэж би үзэж байгаа. Тийм учраас энэ 12-16 онд Монголбанк, Засгийн газраас хэрэгжүүлсэн үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд 7,5 их наяд төгрөг гарсан. Түүнээс 1 төгрөг ч хохиролгүй буцаж төлөгдсөн. Яах вэ, хүүний зардал гарсан. Энэ бол Монголбанкны үүрэг байхгүй юу даа. Энэ чинь инфляцыг тогтвортой байлгах, Монгол төгрөгийн ханшийг тогтвортой байлгахын тулд энэ зардал гаргах ёстой. Тэгэхээр энэ дээр яг хэдэн төгрөг гарсан юм. Түүн дээрээ Монголбанкныхан хариултаа өгчхөөрэй.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Пүрэвдорж гишүүнд талархаж байна аа, би ямар өнцгөөс уг хэлэх болов oo гэж бодож байсан. Үнэхээр яг энэ Орос, Украины нөхцөл байдалтай холбоотой улс төржихгүй байна гэдэг бол үнэхээр чухал л даа. Мэдээж улс төржих олон сэдэв байгаа бид нарт. Энэ бол манай Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой туйлын чухал асуудал. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш тогтсон дэлхийн дэг журам, эрх зүй олон зүйлүүд дээр өөрчлөлт гарч байна аа. Геополитик хүчний харьцаан дээр бас томоохон ийм өөрчлөлт гарч байна. Тийм учраас бидний хувьд туйлын нэгдмэл байх учиртай энэ одоо сэдэв дээр би их талархаж байна.

Тэгээд яах вэ, яг Ерөнхий сайд болохоор яг ингээд л шийдвэр гаргах ийм олон огтлолцлуудын дунд сууж, өнөөдөр ч гэсэн жишээлбэл, ингээд үнэхээр жишээлбэл хожмын нэг өдөр баалуулахгүйгээ бодвол бензиний үнийг мянгаар нэмээд л ингээд явчих нь бол хувь хүнийхээ хувьд зүгээр ч юм шиг. Гэхдээ яг иргэдийн амьдрал амьжиргаа үнэхээр ингээд л ковидын дараах энэ маш амаргүй нөхцөл байдал дунд ороод байгааг хараад надад ирэх жижиг сажиг эрсдэл гэдэг бол яг үнэндээ 1080 дахь асуудал болж хувирдаг юм байна л даа ер нь бол. Тэгээд үүнийгээ үе үеийн Ерөнхий сайдууд бас хийгээд л мэдээж зарим нь арга нь

зөв, зарим нь арга нь буруу байсан байх аа л гэж би одоо зүгээр боддог юм. Тэгэхээр би нэг их тийм айхтар өнгөрснийг баалаад байх бас нэг их тийм дуртай биш, нэг их улс төржөөд байх ч дуртай биш, та нар түүнийг ажигладаг болов уу л гэж боддог. Улс төржих өнцөг гарвал өөдөөс нь улс төржсөн бас хариулт хэлээд л явдаг. Тийм учраас яг энэ дээр бол ингээд улс төржихгүй гээд ингээд явах нь бол туйлын чухал юм аа.

Мэдээж үр дүн гарна гэж бид нар тооцож байгаа. Сая Сараа сайд бас хэллээ. Үнэхээр ковидын энэ эрх зүйн орчныг ч гэсэн бүрдүүлчихсэн маш их хэл ам гарсан, сунгаад л одоо тэгээд л ковидын хуулиас болж ингэж байна, тэгж байна. Гэхдээ одоо эргээд хар даа. Бид нар үнэхээр дэлхийд бас жишиг улсуудын л нэг болсон, гэхдээ ирээдүйд юу болохыг мэдэхгүй л дээ. Ямар өвчнийг бид нар хардаг биш, барьж авч зогсоодог байсан. Тийм учраас өнөөдөр дэлхийн олон улс орнууд яг ийм эрх зүйн баримт бичгүүд бүрдүүлж эхэлж байна одоо. Тийм учраас бид нар хоцроод яах вэ. Түрүүлээд бид нарын хувьд арга хэмжээнүүдээ аваад явж л байя. Бидний бодож байснаас сайн байвал сайн л биз, үнэхээр муу байж цаашаа нөхцөл байдал үнэхээр хүндэрвэл бидний хувьд юутай ч махтай, гурилтайгаа шатахуунтайгаа хомсдол тасрахгүй байж байх юмаа хийж байх нь зүйтэй.

Дээрээс нь нэмээд одоо бид нар түрүүн манай Сандаг-Очир гишүүн хэллээ. Үнэхээр л үнэн, бид нар нээрээ бас нэг малчид дээрээ мал дээрээ л бас яг үнэндээ энэ ковидын үед ч тэр, яг энэ хямралт байдалд ч тэр үнэхээр тогтох байгаа юм. Гэхдээ жишээлбэл гурил дотооддоо тэр үйлдвэрлэдэг эд нар гэдэг бол бас их тийм өрөөсгөл ойлголт юм байна лээ л дээ. Яагаад гэхээр улаан буудайг бид нар ихэнхийг нь авдаг, авахаас өөр аргагүй, энэ нь өөрөө тасарчхаж байгаа болохоор тэгээд л одоо бид нар жишээлбэл дотооддоо үйлдвэрлэнэ ээ гээд ингээд байх бол бас өрөөсгөл юм байна лээ. Тийм учраас энэ бүх зүйлийг бид нар наанатай цаанатай бодож ингэж нэгдмэл байдлаар гарах нь бол зүйтэй юм аа. Тэгээд үр дүн гаргахын төлөө Засгийн газар хичээнэ. Дээрээс нь би сая бас Энх-Амгалан сайдад бас өглөө би сайд нартаа хэлж байсан. Парламентын ардчиллын үнэхээр давуу тал байна. Тэр нь юу вэ гэхээр Засгийн газар өнөөдөр ингэж оруулж ирснээрээ болзошгүй гарах эрсдэлүүдийг бид нар өмнө нь сонсож байгаа юм. Та бүхнийхээ амнаас ард түмний мандатын Их Хурлын гишүүдийн шүүмжлэлээс, тийм учраас алдаа гаргахгүй байх, илүү их тийм няхуур ажиллах боломжийг бид нар Засгийн газар өөрөө хийгээд явчихвал алдаа гаргасныхаа дараа асуудал үүснэ. Одоо бол бид нар өмнө нь харж урьдчилан засах бас ийм том боломжийг парламент өөрөө бас бүрдүүлж өгч байгаа юм.

**Г.Занданшатар:** 83 Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч.

**Б.Лхагвасүрэн:** Пүрэвдорж гишүүний асуултад хариульяа. Монголбанк ерөнхийдөө бодлогын нэлээн бас зардалтай байдал. Монголбанк одоо макро эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах. Саяын ингээд 2012-16 онд хэрэгжүүлсэн тэр үнэ тогтвортой байдлыг хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл олгохоор олон улсын нягтлан бодох бүртгэлийнхээ тэр журмын дагуу хүүний зөрүү дээрээ алдагдал, зардал үүрээд ингээд явдаг. Өнөөдрийн байдлаар Монголбанкны нийт бодлогын зардлын хэмжээ бол 3 их наядаараа хэмжигдчихсэн байж байгаа юм.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн 1 минут тодруульяа.

**Б.Пүрэвдорж:** Ерөнхий сайд аа, таны доор хүнсний аюулгүй байдлын зөвлөл гэж байгаа. Та түүнийг хуралдуулах ёстай. Тэгтэл ойрдоо хуралдахгүй байгаа. Монголын махны компаниуд нийтдээ 50 орчим тонн мах байгаа, түүний тал нь адууны мах, тал нь 50 мянган тонн мах байгаа. Түүний тал нь адууны мах. Тал нь арьстай ямааны мах байгаа. Халуун зунаар адууны мах иддэг хүн байхгүй, дээрээс нь ямааны мах иддэг бас хүн хүн байхгүй. Тийм учраас үүнийг яалт ч үгүй хурдан экспортлох хэрэгтэй байна. Энэ чинь хоёр зуугаад сая доллар, үүний чинь тал нь бол Хятадуудын мах байгаа байх, тал нь Монголын үйлдвэрлэгч нарын мах байгаа. Тэд нарыгаа оруулаад ирэх юм бол ядаж л нэг 100 сая доллар энэ зах зээл рүү чинь орж ирэх боломжтой байна. Тийм учраас үүнийгээ маш яаралтай нэг хариулт хэлчхээч. Тэгэхгүй бол одоо энэ чинь бодлогын гэрээ гээд л Баян-Өлгийн Азат компани 1 сар ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** 94 Загджавын Мэндсайхан сайд.

**3.Мэндсайхан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариульяа. Ерөнхий сайд хүнсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэг. Энэ эрхээ хөдөө аж ахуйн сайдад шилжүүлсэн байгаа. Хүнсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаад энэ адууны мах болон энэ гуравдагч байгаа хөрш орнууд руу гуравдагч орнууд руу гаргах малын махны экспортыг нэмэгдүүлье ээ гээд хязгаарлалтыг нь цуцальяа гэдэг шийдвэрийг гаргасан байгаа. Удахгүй энэ албажаад аж ахуйн нэгжүүд дээр хүргүүлнэ ээ. Нөгөө та өөрөө сайн мэдэж байгаа байх. Энэ нэг өөр нэг гарцаар бид бас төлөвлөөд явж байгаа.

**Г.Занданшатар:** Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн. Дараа нь санал хураалттай.

**Ц.Туваан:** Монголчууд дайнаа ирэхээр дариа нухнаа гэж ярьдаг. Тэгэхээр юу хэлэх гэж байна гэхээр энэ арга хэмжээ маань оройтоогүй байгаа гэж ингэж болгоомжилж байна. Тэгээд өмнө нь үнэ тогтвожуулах хөтөлбөр гээд бас нэлээн шүүмжлэл дагуулж улс төр дагуулж нэлээн явж байсан. Тэгэхээр өнөөдөр яг л үүнтэй агаар нэг асуудал орж ирж байна аа. Тэгэхээр бас улс төржих юмыг бас хязгаартай улс төржиж баймаар байна аа гэдгийн нэг баталгаа нь энэ болж байна уу гэж ингэж харж байгаа юм.

Монголбанк энэ одоо бодлого дээр яг Засгийн газартай энэ оруулж ирж байгаа хуулийн төслийг яг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байна уу гэдэг асуултыг асууяа. Яагаад гэхээр өчигдрийн Байнгын хорооны хурал энэ тэр дээрээс харахаар буруу бодлого байсан гээд хэлж байх шиг, төсвийн арга хэмжээ байсан гээд хэлж байх шиг иймэрхүү асуудлууд яриад байна лээ. Тэгэхээр яг энэ дээр тодорхой байр суурийг чинь асууяа. Монголбанк бол Улсын Их Хурлаас одоо томилогддог ийм байгууллага. Тэгэхээр бодлогоо тодорхой хэлэх байх.

Ер нь бол аливаа тусгаар улс байгаагийн давуу тал чинь өөрөө төв банктай, тэгээд төв банк нь мөнгөний бодлогоо барьдаг. Тэгээд ер нь шаардлага гарвал энэ мөнгөө хэвлэсэн ч яах вэ дээ ер нь. Бид нар нөгөө тусгаар улс байгаа л юм чинь энэ асуудлаа бас өөрсдөө зохицуулаад шаардлага гарвал ийм ажиллагаагаа хийгээд явахад бол буруутай байх зүйлгүй ээ. Тэгэхээр энэ удаагийн энэ хууль орж ирж байгаа бол жоохон хоцорчхоогүй бол энэ одоо зөв зүйтэй арга хэмжээ. Манайх энэ дээр нэг мах, гурил, бензиний асуудал яриад байна гэж ингэж бодоод байх шиг байна. Үүний цаана чинь бол бас энэ инфляцыг барих гэдэг бодлого хамгийн том бодлого явж байгаа шүү дээ. Инфляц гээд энэ чимээгүй хулгайч чинь

иргэдийн халаас өврийг ухаад байгаа. Тэгэхээр үүний эдгээр одоо бүтээгдэхүүнүүдийн үнэ хөдлөхгүй байвал инфляц баригдаж байдаг. Тэгэхээр энэ давхар бодлого явж байгаа учраас би үүнийг бас хамгийн зөв хууль одоо орж ирлээ гэж ингэж улс төржихгүйгээр дэмжиж байгаа юм. Хүмүүс бол инфляцын нэг номерын хөшүүрэг махны үнэ гээд хэлэхээр зарим хүн үнэмшдэггүй юм. Гурилын үнэ гэхээр үнэмшдэггүй юм. Бензин гэхээр үнэмшдэггүй юм. Тэгэхээр энэ бол ийм байгаа. Тэгэхээр энэ дээр яах вэ нэг логикийн нэг зөрүү гараад байна л даа. Юу гэхээр хоёр нь бол дотооддоо бэлддэг ийм хүнсний бүтээгдэхүүн. Нэг нь бол гадаадаас авч байгаа энэ бензин бол, тэгэхээр энэ гадаадаас авч байгаа бензиний асуудлыг бол бүр эн тэргүүнд маш зүйтэй. Мянган төгрөгөөр бензин нэмчхээд дээрээс нь олдоц муудчихвал, тэгээд бүх юмны үнэ дагаад л тавиад тууна шүү дээ. Тэгэхээр бол энэ яг цагаа олсон бодлого оо гэж ингэж бодож байна.

Энэ мөнгийг юу яамаар байна аа. Энэ дээр Жавхлан сайдаас асууя. Түрүүн бас энэ хууль Их Хурал дээр та бүхэн энэ юун дээр нь өөрчилж болно оо гээд ярьж байсан. Энэ мах үйлдвэрлэгчид, мах бэлтгэн нийлүүлэгчдэд гээд байна. Монгол Улсад одоо зарах мах байхгүй ээ. Түрүүний хэлсэн 50 мянган тонноос өөр мах байхгүй, мал турсан. Тэгэхээр намар мал таргалтал бол энэ асуудал байхгүй. Тэгэхээр үүнийг харин мах жинхэнэ үйлдвэрлэдэг малчид руу тэр малынхаа үүлдэр угсааг сайжруулах руу нь өгвөл зөв бодлого болно.

Улаан буудай борлуулагдаад бараг дууссан, жоохон одоо чанарын асуудалтай буудай байгаа. Тэгэхээр намар болтол дахиад энэ улаан буудай худалдаж авдаг гурилын үйлдвэрүүдэд энэ мөнгө хэрэггүй. Яагаад гэхээр өнгөрсөн хугацаанд 10 их наядаас гурилын мөнгө гээд тавьсан, эндээс авч чадсан нь 40 тэрбумыг л авч чадсан шүү дээ. Одоо энэ мөнгө зээлтэйгээ ингээд байж байгаа. Тэгэхээр энэ дээр бас тариаланчид руугаа энэ юмаа бас чиглүүлсэн нь зөв байх аа гэж ингэж бодож байгаа. Тэр 50 мянган тонн мах энэ тэр байгаа бол үүнийг тэр гадаадын яам ажиллаад одоо тэр нөгөө бартераар Орос руу махаа тэр гаргаад оронд нь тэр түлш авах ажиллагаа энэ тэр дээрээ харин бодлого явуулж болдоггүй юм уу гэсэн ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Лхагвасүрэн Ерөнхийлөгч 83, дараа нь Гадаад яам 93 Батцэцэг сайд.

**Б.Лхагвасүрэн:** Туваан гишүүний асуултад хариултъя. Тэгээд таны асуусан асуулт тэгээд таны тодруулж байгаа зүйл бол бараг өөрийнхөө асуултад та яг л өөрөө хариулсан юм шиг л би яг таны хэлсэн зүйлтэй яг л санал нэг байна. Төв банкны одоо үндсэн зорилго бол үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдал. Төгрөгийн тогтвортой байдал ямар хоёр зүйл дээр гарч ирдэг вэ гэхээр, нэгдүгээрт инфляц буюу дотоод худалдан авалт, нөгөөдөх нь бол гадаад валюттай одоо харьцаж байгаа харьцаа, ханш, тэгэхээр бол одоо инфляцыг бол одоо яг л онилоод явж байгаа Төв банкны хувьд бол Засгийн газрын одоо ингээд хамт ингээд хуулийн төсөл ажлын хэсэгт нь ороод ингээд ажиллаад орж ирж байгаа нь бол яг л төв банкны энэ зорьж байгаа ажлыг Засгийн газраас дэмжиж байгаа дэмжлэг л гэж харж байгаа. Тэр утгаараа бол, ялангуяа тэр дурдагдаж байгаа З бүтээгдэхүүн бол хамгийн инфляцын, хамгийн том л З хэсэг нь байгаа учраас эдгээр бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна гэдэг маань инфляц өөрөө цаашдаа тогтвортой байх л ийм л зүйлийг бий болгоно оо. Тэгээд тэр утгаараа яг л таны хэлж байгаа зүйлтэй бол адилхан саналтай байгаа юм аа.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Туваан гишүүнд баярлалаа. Ер нь дэмжиж байгаа юм байна гэж ойлголоо, баярлалаа. Тэр мах буудайн дээр Мэндээ сайд бас нэмж хариулаарай. Надаас асуучихлаа зүгээр мэдэж байгаа мэдлэгийнхээ түвшинд хариульяа. Махны хувьд Туваан гишүүн ээ, тэр үүлдэр угсааны асуудлыг бид нар хагас жилийн хугацаанд шийдэж чадахгүй шүү дээ. Энэ бол дунд, урт хугацааны асуудал. Тусдаа хөтөлбөр, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөр дээр бүгдэд орчихсон ингээд явж байгаа. Тэгэхээр хоёр, гуравдугаар улирлын, дөрөвдүгээр улирлын бид идэх махныхаа асуудлыг л одоо ингээд тогтвортой байлгаяа гэдэг дээр л энэ хуулийнхаа зохицуулалтуудыг чиглүүлнэ ээ. Олон юм руу ингээд савчхаар өнөө үр дүн гэдэг юм маань байхгүй болж байгаа юм. Та хэд маань үндсэндээ бараг өнөөдөр ингээд бүгдээрээ дэмжиж байна. Mash их одоо хүлээлт үүсэж байна. Бидэнд маш их хариуцлага ирж байна. Одоо хуулиа батлуулж аваад үр дүн чухал байгаа. Тийм учраас одоо үр дүн дээрээ бид төвлөрөө өө.

Улаан буудайн дээр бол бас арай өөр схем нь. Бид бүтэн жилээр нь харахгүй бол болохгүй байгаа. Бүтэн жилээр нь. Одоо өмнөх жилийн үлдэгдлүүд энэ гурилын үйлдвэрүүдийн агуулахуудад байж байна. Тийм ч учраас бас өнгөрсөн жил тариаланчдын бас үлдэгдэл зарж чадахгүй ингээд байж байна. Тариаланчид будааны үлдэгдлээ зарж чадахгүй байгаа учраас энэ жилийнхээ тариалалтыг хийх эх үүсвэр маш дутмаг байна. Энэ түгжээнүүдийг тайлах зорилгоор л одоо бид энэ эх үүсвэрүүдийг банкны эх үүсвэрээр дамжуулж туж гаргаяа гэж байгаа юм. Ингээд байгаа энэ түгжээнүүдийг нь гаргаад гурилын үйлдвэрүүдийг хангалттай одоо нөөцтэй болгоод энэ жилийн тариалалтыг нь хэвийн түвшинд нь тариалаад. Ингээд намар одоо хангалттай ургацаа авах юм бол энэ жилдээ бид энэ гол одоо улаан буудайн гурилын бүтээгдэхүүнүүдийнхээ, үнийг тогтвортой байлгах ийм захиргааны арга хэмжээ авч болно оо гэж ингэж харж байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд 93.

**Б.Батцэцэг:** Туваан гишүүний асуултад хариульяа аа. Оросын холбооны улсын маань хориг өнөөдрийн байдлаар 8000 гарчихсан байгаа. Хоригт орсон тохиолдолд хүмүүнлэгийн тусламжаар хүнсэн дотор махыг бас нийлүүлж болдоггүй. Бarteraар хийх бас боломжгүй. Маханд бол Оросууд 60 хувийн 60 хүртэлх хувийн татвартай. Харин энэ цаг үеийг ашиглаад гэх юм уу даа бид нар бол Оросын холбооны улсад хэд хэдэн саналыг хэд хэдэн түвшинд тавьсан байгаа. Своп хэлцэл. Бид нар бас гол авдаг түүхий эдүүдээ рублиэр тооцоо хийх асуудлыг албан ёсоор тавьсан байгаа. Мөн бас Ерөнхийлөгчийн айлчлалаар ярьж байсан хэд хэдэн одоо энэ худалдаатай холбоотой тарифын хөнгөлөлт, зарим нэг нэр төрлийн бараа одоо томоохон төрийн өмчит компаниудад нийлүүлэх асуудлуудыг бол сөхөөд ингээд тавьчихсан араас нь ажиллаж байгаа. Бид нар судалгаануудыг бол байнга хийж байгаа, энэ одоо бид нартай хил залгаа байгаа Буриадад бол гахай, үхрийн мах болбол нэлээн ховордсон байгаа. Зарим нэг хүнсний төрлийн бүтээгдэхүүнүүд нэлээн ховордсон байгаа. Тэгэхээр бид нар энэ маhtай холбоотой асуудлаар бол ажиллаж байгаа. Хүнс, хөдөө аж ахуйн яам манай хоёр.

**Г.Занданшатар:** Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууяа, 1 минут.

**Ц.Туваан:** Энэ хөдөө аж ахуй одоо энэ нэг яг зовох цагт гэдэг шиг л яг энэ хөдөө аж ахуйн салбар л бас яг энэ ачааны хүндийг нуруундаа үүрч гарах нь л дээ. Тэгэхээр энэ дээр энэ мах, гурилаас гадна энэ ноолуурын асуудал яг ид чухал.

Монголчуудын малчдын 2 том орлогын 1 олдог цаг ноолуур. Тэгэхээр урьд нь бол бид нар энэ сонгуулийн өмнө бас ноолуур дээр хэрэгцээгүй шаардлага үүсээгүй энэ тэр дээр нэлээн одоо мөнгө гаргаад л явдаг л даа. Тэгэхээр одоо яг энэ хүнд цаг үед, ялангуяа одоо доллартой харьцуулахад энэ ноолуурын үнэ чинь бол маш бага болж байна шүү дээ. Одоо хар захын доллартой харьцуулахад. Тэгэхээр яг энэ үед нь харин ноолуурыг оруулах юм уу эс үгүй бол үүнтэй хамаагүй байсан ч гэсэн ноолуур дээр ер нь ямар бодлого байгаа вэ гэдгийг Ерөнхий сайдаас тодруулаад асуучихъя аа.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Ер нь хөдөө аж ахуй ялангуяа Атрын дөрөвдүгээр аян, энэ дээр хүнсний аюулгүй байдал, тэр дундаа малын гаралтай түүхий эдийг экспортыг нэмэгдүүлэх, хаягдаж байгаа арьс ширээ дахин боловсруулах зэрэг ийм олон асуудал дээр Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Засгийн газар онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаа. Маргааш эдийн засгийн форум болон түүн дээр бас нэлээн дэлгэрэнгүй ярина аа.

**Г.Занданшатар:** 94 Загджавын Мэндсайхан сайд нэмж хариульяа.

**3.Мэндсайхан:** Тываан гишүүний асуултад хариульяа. Ноолуур дээр Засгийн газар ноолуур бэлтгэдэг аж ахуйн нэгж иргэдэд зориулаад 150 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээлийг өнөөдөр гаргасан байгаа. Тэгэхээр аж ахуйн нэгжүүд маань энэ хаврын гарч байгаа малчдын гар дээр гарч байгаа ноолуурыг худалдаж авах эх үүсвэрийг Засгийн газар шийдвэрлэсэн гэж ойлгож болно.

**Г.Занданшатар:** Ноолуурын зээлийг шийдсэн гэсэн байна, тийм ээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж хэлэлцэж болно. Ерөнхий сайд үг хэлнэ. Эхлээд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд үг хэлнэ ээ.

Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэндээ Засгийн газраас оруулж ирж байгаа олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бутээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай энэхүү хууль дээр туйлын нухацтай, ажил хэрэгч хандаж, олон талаас нь бас асуудлыг харж, гарц шийдэл гаргах дээр улс төржихгүйгээр одоо ажил хэрэгч хандаж байгаад Ерөнхий сайдын хувьд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Цар тахлын хууль бас шүүмжлэлтэй батлагдаж байсан. Гэхдээ цар тахлын эсрэг энэ эрх зүйн багц орчин өнөөдөр олон мянган Монгол иргэдийн маань амь насыг аврах хатуу хөл хориогүйгээр эдийн засгаа нээх энгийн амьдралын хэмнэлдээ эргэж шилжих маш том түүхэн хувь нэмрийг оруулсан гэдгийг би зориуд өнөөдөр онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Мөн цар тахлын эсрэг энэхүү хуулийг одоо үргэлжилж байгаа хугацаанаас цааш сунгахгүй ээ гэдгийг Ерөнхий сайдын хувьд, бас хариуцлагатайгаар та бүхэндээ илэрхийлье ээ гэж бодож байна. Тогтвортой ийм эрх зүйн орчин болох тал дээр бидний хувьд ажиллаж байгаа.

Тэгээд ковидын үед, бас одоо дайн бүхий ийм зэвсэгт мөргөлдөөнтэй хүнд үед та бид одоо хамтарч ажиллах л ийм ёстай байж, тэгээд өнөөдрийн энэ хуулийг та бүхэн шүүн хэлэлцэж, Улсын Их Хурал өөрийнхөөрөө батлах онцгой бүрэн эрхээ одоо хэрэгжүүлнэ байх аа гэж бидний хувьд итгэж байгаа.

Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэж манай Монголын ард түмэн, ярьдагчлан Улсын Их Хуралтайгаа нягт хамтран ажиллаж, Улсын Их Хурлын баталсан Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан 47 орчим манай улсыг хөгжүүлэх томоохон мега төслүүд дээр одоо Засгийн газар маш их цаг зарцуулж байгаа юм. Хэдийгээр хил гааль хаалттай, амаргүй байгаа ч гэсэн бид нар техник эдийн засгийн үндэслэл болон бусад асуудлуудаар шийдлүүдээ гаргаж шийдлүүд олж байгаа юм. Цаашдаа Эрдэнэбүрэнтэй холбоотой асуудал дээр нөхөн олговор болон мөн одоо малчдын асуудлыг Их Хурлаар ярих зайлшгүй шаардлага байгаа. Үүнийг ойрын үед Засгийн газраас Улсын Их Хурлаар оруулж ирнэ ээ. Тэгээд бүгдээрээ ярилцаад энэ төслийг одоо хэрхэн хөдөлгөх вэ гэдэг дээрээ эцэслэн шийдвэр гаргаяа аа. Засгийн газрын түвшинд шийдэх гэхээр бас нэгээс хоёр хуультай зөрчилдөж байгаа асуудал үүсээд байна аа. Тийм учраас Эрдэнэбүрэнгийн станц шийдэгвэл, баруун бус нутгийн одоо эрчим хүчний асуудал бүхэлдээ шийдэгдэх, Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх дарга Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа өмнөх Засгийн газрууд ч гэсэн одоо маш нягт ажилласан ийм томоохон хөтөлбөр байгаа. Хөрөнгө оруулагчидтай ярьсан энэ ингээд одоо хөдлөхөд бэлэн болсон гэж та бүхэндээ бас хэлэхийг хүсэж байна. 1-2 хуулийн зохицуулалт хэрэгтэй байгаа юм.

Мөн Улаанбаатар хотын түгжрэл, хөнгөн галт тэрэгтэй холбоотой асуудлыг БНХАУ-д айлчлахтай холбоотой тавьсан. Энэ дээр хөрөнгө оруулагчид бас яригдсан. Засгийн газраас баталгаа мөн Улсын Их Хурлаар татвартай холбоотой, мөн нийслэлийн төсөв дээр арваас доошгүй жилийг үндсэндээ одоо байгаа 420 тэрбумыг зарцуулахтай холбоотой ийм асуудлыг хөрөнгө оруулагчдын зүгээс тавьсан. Энэ бол тус Засгийн газар дангаараа биш Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал юм аа. Тийм учраас нээлттэй оруулж ирээд бас ярья, техник эдийн засгийн үндэслэл батлагдсан, та бүхэнд ирэх долоо хоногт энэ бүх зүйлийг тарааж, бас энэ дээр ярилцана аа.

Хил холболтын цэгүүд тохиролцсон. Хил холболтын цэгүүд тохиролцсон хүрээнд Ханги Мандалын төмөр зам энэ 10 сард ашиглалтад орохоор тооцож байгаа. Гашуун сухайтын төмөр зам энэ 7 сард ашиглалтад орно. Хил холболтын терминал үндсэндээ бид нарын хувьд нүүрс урьдчилан боловсруулах гэрээгээр хийхээр тохиролцсон. Ингээд хэлэлцээрийн ажлууд явж байгаа. Мөн Зүүнбаянгийн төмөр зам үндсэндээ энэ 10 сард гэрэл дохиолол ороод явна. Туршилтын тээвэр амжилттай бас хийгдээд ингээд явж байгаа. Богд хаан төмөр зам болон баруун, зүүн босоо тэнхлэгийн төмөр замууд, төр хувийн хэвшлийн түншлэлээр явах ажлууд болон техник эдийн засгийн үндэслэл үндсэндээ дууссан гэдгийг та бүхэнд бас хэлэх нь зүйтэй.

Таван толгой цахилгаан станцын одоо үндсэндээ бас шийдлүүд гараад нээлттэй тендер зарлагдаад ингээд дуусаж байгаа. Энэ бол шийдлээ бас өгнө, олно. Оюу толгойн гэрээн дээр үндсэндээ эрчим хүч нийлүүлэх гэрээ хийгдсэн учраас энэ маань бол одоо маш ашигтай ийм төсөл болж байгаа. Оюу толгойн гүний уурхай хэвийн явж байна. Ухалтууд болон дэлбэрэлтүүд маш амжилттай явж байгаа мэдээллийг бид нар авч байгаа. 23 оны 5-6 сардаа гүний уурхай маань

үндсэндээ одоо гол тэсэлгээнүүд бүгд хийгдэж, гоожилт хийгдэх томоохон энэ боломж бол үүснэ ээ гэдэг байдалтайгаар хийгдээд явж байгаа.

Цахимжилт 11-11 төв зэрэг ажлууд бас амжилттай явж байгаа. Өнөөдөр 11-11 төв нээгдэнэ, тэгээд бас Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийгээ бас уриалахыг хүсэж байна. Ерөнхий сайд дэргэдээ шууд татаж авсан байгаа 11-11 төвийг. Тийм учраас иргэдтэйгээ илүү эргэх холбоотой байх энэ асуудал дээр бас томоохон алхам болно оо гэж бодож байгаа.

Эрт оношилгооны том аян ковидын дараах нөхцөл байдлыг одоо бас үзэх томоохон ийм эрүүл мэндийн салбарын одоо том реформ болно гэж бас бодож байгаа. Энэ маань таван сарын нэгэнд эхэлнэ.

Атрын дөрөвдүгээр аяныг бас эхлэхэд бэлтгэл ажил бүрэн хангагдсан гэдгийг та бүхэндээ бас хэлэх нь зүйтэй байх аа гэж бодож байна.

Ингээд энэ бүх зүйлээ хийж чадвал мэдээж өнөөдөр бид нарын хувьд ковидтой нөхцөл байдал нэн амаргүй ийм байгаа боловч том төсөл гэдэг бол өөрөө хугацаа ордог зүйл учраас эдгээр болон одоо Шинэ сэргэлтийн бодлогоор дэвшүүлсэн том төслүүдийн техник эдийн засгийн үндэслэл үндсэндээ дуусч, богино хугацаанд бид нар 40 орчим их наяд төгрөгийн эргэлтийг 2-3 дахин буюу 100-120 их наяд төгрөгийн эргэлттэй улс болох бүрэн боломж байна гэдгийг Ерөнхий сайдын хувьд бас та бүхэндээ өөдрөгөөр хэлэх нь зүйтэй.

Маргааш эдийн засгийн форум болно. Мэдээж эдийн засгийн форум бол дотоодод хийж байгаа арга хэмжээ гэхээс илүүтэйгээр бид нар дэлхийн эдийн засгийн форумд Монгол Улсын байр суурийг илэрхийлж оролцож байгаа ийм олон улсын арга хэмжээ гэж ойлгох ёстай. Тийм учраас 2 жилийн хугацаанд бид нар цар тахлын үед Монгол Улс бас эдийн засгийн форум дээр өөрийн дуу хоолойгоо илэрхийлж чадахгүй байсан. Маргааш, нөгөөдөр 2 бид нар хувийн хэвшлийнхэнтэйгээ мөн олон нийт иргэдтэйгээ нээлттэй бас ярилцаж өнөөдөр биш маргааш, нөгөөдрийн том шийдлүүдийн тухай бас амаргүй цаг үед ч гэсэн бидний хувьд сэрг бас ярилцаж Монгол гэдэг айл олон улсад тэр дундаа томоохон хөрөнгө оруулалт дээр бид нар ямар байр суурь, ямар зарчимтай ажиллах юм бэ гэдгээ бас илэрхийлж олон хүндтэй бас гаднын зочид ирж байгаа гэдгийг та бүхэндээ бас хэлэх нь зүйтэй байх аа. Их Хурлын эрхэм гишүүд бас идэвхтэй оролцохыг та бүхнээс хичээнгүйлэн хүсье ээ гэж бодож байна.

Ингээд өнөөдрийн хэлэлцүүлэгт талархаж байгаагаа дахин илэрхийлье.

**Г.Занданшатар:** Одоо дэмжсэн, дэмжээгүй 3. Ямар ч байсан Буланы Бейсен гишүүн үг хэлнэ ээ. Пүрэвдорж гишүүн булаалгая.

**Б.Бейсен:** Энэ дэмжсэн үг хэлнэ ээ, яагаад гэвэл энэ хойд хөршид маань дайн, зэвсэгт мөрөөдлийн биш дайн болж байна шүү дээ. Түүнийг бас зөвөөр ойлгох хэрэгтэй. Урд хөршид маань одоо тахал, бас ингээд дахиж дэгдчихсэн үед нь Засгийн газраа аягүй хүнд нөхцөлд ажиллаж байгааг ойлгож байна. Тийм учраас хэд хэдэн саналаа хэлье гэж бодож байна. Сая нэг гурил будаа, мах, их түлш, бензин шатахуун бэлтгэх асуудал дээр эм, эмнэлгийн хэрэгслийг тухай бас оруулчхаарай гэдэг саналыг хэлье. Энэ эм, эмнэлгийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл урвалж бодисуудыг гадаадаас татаад авчих нөөц бүрдүүлэх боломж байна. Яагаад гэвэл одоо Европ тийшээ Туркэш айрлайнс нисэж байгаа.

Тэгээд Корей Япон руу нисэж байгаа. Эд нарт 1 удаагийн рейсээр 1-2 тонн эм, эмнэлгийн хэрэгслийг авчрах зөвшөөрлийг энэ төлөөлөгчийн газрууд руу нь ярьж байгаад 6 сар хүртэл яхад бараг жилийн юмаа бэлдчих боломж байна. Энэ дээр эрүүл мэндээ бас анхаарч ажиллаад сая эм, эмнэлгийн хэрэгслийн газрын 130 орон тоотой ажилчдыг бол зөвхөн шалгалт биш бас туслах энэ судалгааг нь гаргахад нь бас ашиглаарай гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ хүнсний ногоо тариалах асуудал дээр Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас анх хараад аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн Засаг дарга нарт үүрэг өгөөд жилийнхээ хүнсний ногоог бэлд ээ гэдгийг эртхэн захиад хэлээд бас ингээд асуудлаа бүрдүүлээд хүнсний ногоог бэлдэх асуудал дээр эрт анхаарах зоорины асуудал байна. Энэ эртхэн харах шаардлагатай байгаа юм аа.

Гуравдугаарт, түлшний бензин шатахууны хувьд хуучин баруун бүсийг хангаж байсан Цагаан нуурын нефть бааз гээд байсан, баруун 5 аймгийг хангаж байсан. Одоо тэр нефть хангамжийн газар дээр нь том том бензиний агуулахууд байж байгаа. Үүнийг бас ашиглаад бензин шатахуунаа эртхэн татаж авах асуудал дээр бас холбогдох яамд энэ дээр анхаарч ажиллаасай гэдэг саналаа хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Дэмжиж үг хэллээ. Жамъянгийн Мөнхбат гишүүн.

**Ж.Мөнхбат:** Би энэ гол нэрийн бүтээгдэхүүний үнийн зохицуулалтыг хийж байгаа энэ асуудлыг дэмжиж байгаа. Тэгээд энэ дэмжиж байгаа гишүүддээ ч бас ингээд сонсоод байж байхад бас сайхан л сонсогдож байна. Ялангуяа манай энэ Ардчилсан намын гишүүд маань энэ дээр, бас яг улс орноо харсан өнцгөөс бас энэ асуудалд хандаж байгаад их баяртай сайхан байна аа.

Ер нь өнөөдрийн энэ үүсээд байгаа нөхцөл байдал бол улс төр хийх бол сэдэв биш юм байна лээ. Попордог топ болох гэдэг сэдэв ч бүр биш. Үгүй ээ, одоо ингээд дэлхий нийтээрээ л байна шүү дээ. Одоо урд талд ингээд цар тахалтай бид нар 2, 3 жил ингээд л хүнд байдалд байлаа. Хил хаалттай. Хойно одоо зэвсэгт мөргөлдөөн дайн болж байна. Дэлхий нийтээр нь хориг тавиад ингээд хил хаачихлаа. Ийм л хүнд нөхцөл байдалд бид нар одоо тэнгэрээс заяагдсан гэх юм уу одоо ийм л 2 том улсын дунд хоёулаа нэг нь, одоо цар тахлаас, нэг нь одоо геополитикийн асуудлаас болоод л хилээ хаачихсан ингээд байж байна. Тэгэхээр энд бол ямар ч Ерөнхий сайд байгаад ямар ч Засгийн газрын байгаад, ямар ч сайд нар байгаад нөхцөл байдал иймээрээ л байна. Харин цар тахлыг бид нар сайн давж гарсан. Би одоо энэ Эрүүл мэндийн сайд Энхболдод баяр хүргээ гэж бодож байгаа юм. Муу ярьдаг юм байна лээ. Харин сайн хийдэг юм байна лээ. Одоо яриагаа сайн сайжруул тийм. Тэгээд ер нь цаашдаа бол бид нар ингээд нэг ийм улс орны хэмжээний ийм асуудал дээрээ бол нэг иймэрхүү байр суурь барих нь их зөв байх аа. Ямар тэр намын Монгол Улс, энэ намын Монгол Улс, тэр компанийн Монгол Улс, энэ компанийн Монгол Улс гэж байхгүй шүү дээ. Бүгдээрээ л бидний адилхан л энэ эх орны иргэд, эх орны эзэд. Тийм учраас энэ ард түмнээ, иргэдээ, аж ахуйн нэгжүүдээ энэ хүнд хэцүү үед нэг аятайхан шиг аваад гарах л энэ л бодлогын төлөө, одоо ард түмний итгэл авч сонсогдсон энэ 76 хүн, тэр мал гэнэ үү, мангуу гэж дуудуулна уу хамаагүй. Яаж ийж байгаад энэ ард түмнийхээ төлөө, улс орныхоо төлөө, энэ аж ахуйн нэгжүүдийнхээ төлөө гэсэн ийм шийдвэр гаргаад эх оронч байр суурьтай байгаад, хэрвээ өөрсдөө татгалзаж болох юмнууд байдаг бол татгалзаад ингэж байгаад гарах ийм нэг жилийн хугацаа ирж байна уу л гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд ч дээрээс нь одоо ямар энэ 22 он сонгуулийн жил биш,

24 онд сонгууль болно, 23 оноос эхлээд л 23 оны хавраас эхлээд л улс төрждөг юм байгаа биз. Тийм ээ, тийм, тэгээд би одоо нэг зүйлийг бас ингээд хэлмээр байгаа юм, одоо энэ валютын ханшийн хомсдол үүслээ энэ тэр гээд сүүлийн үед одоо ингээд хүмүүс янз янзаар яриад байгаа. Бид нар энэ ялангуяа энэ Их Хурлын гишүүд хэлж ярьж байгаа юмаа сайн бodoх хэрэгтэй юм байна лээ. Бид нарын энэ чуулган дээр ярьж байгаа энэ үг ярианаас чинь болоод харин жинхэнээсээ тэр эдийн засаг дээр чинь банк санхүүгийн салбарт чинь ямар нэгэн хоосон хий бухимдал үүсэж байгаа шүү. Үүсэж байгаа шүү, үгүй ээ одоо тэгээд айлаар бол яах юм бэ. Хамаг юм нь хаалттай, гараад юмаа худалдаад хэдэн төгрөг олох боломжгүй л байгаа шүү дээ. Тийм учраас бид нар өөрсдөө бүх боломжкоо шавхаж дайчилж, энд дотооддоо зохицуулалтаа хийгээд л ингээд явахаас л өөр аргагүй байгаа юм. Тийм учраас бол энэ сэдвүүд дээр бас манай зарим гишүүд ингээд л янз бүрийн юм яриад одоо хувь хүний гэдэг юм уу хувьсгалын гэдэг юм уу зорилгоор ингээд зарим нэг субъект рүү дайралт хийгээд байгаа юм шиг байгаа юм. Тэр нь өөрөө явж байгаад энэ банкныхаа системдээ хий хоосон бухимдал үүсэх вий дээ. Үүнийгээ одоо сайн бодож зарим одоо энэ попортлоо бол одоо зогсоох хэрэгтэй байна шүү гэдгийг одоо бас хэлчихье гэж бодож байна.

Тэгээд энэ асуудлыг дэмжиж байгаа. Харин Засгийн газар одоо шуурхай сайн, хурдтай ажиллах хэрэгтэй байна аа л гэдгийг хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** З гишүүн дэмжиж үг хэллээ. Одоо дэмжээгүй л З гишүүн хүлээх зайд үлдсэн. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн дэмжихгүй л үг хэлнэ шүү дээ. Дэмжихгүй л хүн байвал одоо энэ 4-өөс үг хэлэх нь байна.

Бүгд л хэлэх болно л доо, тэгэхээр чинь. Бат-Эрдэнэ гишүүн чинь дэмжиж байгаа шүү дээ. Та дэмжиж байгаа юм чинь дэмжихгүй үг хэлээд яах вэ. Ж.Бат-Эрдэнэ ч гэсэн дэмжихгүй, дэгээрээ л явъя. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн дэмжиж үг хэлсэн түрүүн, үг хэлчихсэн, асуулт асуухгүй гэж байгаад. Ингээд энэ үндсэндээ ингээд хаачихвал яасан юм. Дэмжихгүй үг хэлэх хүн л үг хэлнэ. Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Дэмжихгүй үгийг. Дэмжсэн үг хэлсэн. Дэмжихгүй харин та үг хэл. Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Баярлалаа. Юу шүү дээ, энэ одоо арай бага алдаасай, арай ахиу оноосой л гээд л бид нар ярьдаг хэлдэг юм шүү дээ. Өмнө гаргасан алдаануудаа л ингээд л бас давтах тал руугаа л явчхаж байгаа юм л даа. Тэр үнэ тогтвржуулах хөтөлбөр, бид нар нэг социалист эдийн засаг руугаа л яваад байгаа. Ийм маягаар явж болохгүй ээ. Тодорхой хугацаанд тодорхой хэсэгхэн хугацаанд бол байж болох байх. Мэдээж хэрэг үүний дараа улс орны нөхцөл, олон улсын нөхцөл байдал ямар болохыг одоо бас л хүлээлтийн байдалтай л иймэрхүү арга хэмжээ авч байгаа гэж бодож байна. Энэ маягаараа цаашаа үргэлжилбэл бид нар картын бараанд орно шүү. Энэ валютынхаа нөөцийг, валют олдог орлогоо нэмэгдүүлэх ёстой. Өмнө нь одоо янз бүрээр ажиллаж байсан Ерөнхий сайд, Засгийн газруудын алдааг, олонхын алдааг давтаж болохгүй ээ. Энэ олонх бол дандаа зөв байдаггүй юм аа. Олонх бол дандаа буруу байдаг юм шүү. Ер нь сүргийн сэтгэхүйтэй байдаг юм шүү. Тэр тусмаа манай Монгол Ардын намынхан бол бүр тийм улсууд шүү. Тэгэхээр Ерөнхий сайд, энэ Засгийн газар бол цөөнхийнхөө үгийг сайн сонсож байх хэрэгтэй. Энэ үгэнд бол та нарыг арай бага алдаасай. Яагаад вэ гэвэл бид нар нэг л Монгол Улс. Нэг л ард түмэн. Бид нар хамт дотор нь л зовно. Тэгэхээр энэ гаргаж байгаа шийдвэрүүд зөв байх ёстой. Олон зөв шийдвэрүүд гаргаж болох байлаа. Үүнээс өмнө бол нэгдүгээрт, одоо бид нар гадаадын хөрөнгө оруулалтыг яж ихэсгэх юм. Энэ тал дээр анхаармаар байна. Энэ чинь одоо 10

жилийн өмнө 8 тэрбум доллар орж ирдэг байсан бол өнөөдөр ганцхан Оюу толгойд 1 тэрбум доллар орж ирж байгаа шүү дээ. Гадаадын хөрөнгө оруулалт зогсчихсон байгаа. Тэгээд ер нь бол яагаад ийм байгаа юм бэ. Энэ чинь төмөр замтай л холбоотой байна шүү дээ. Үгүй ээ, тэр танк, танкчин хоёроос битгий ай л даа. Танк чинь одоо өөрөө гинжээрээ өөрөөр яваад ороод ирдэг юм. Тийм одоо түүнийг чинь устгадаг зэвсэг ч өөр болчихсон байна. Тэгээд танкчин үг хэлэхээр битгий тэгээд, үнэн л үг хэлнэ шүү дээ. Явж явж байгаад л, тэгээд л хүлээн зөвшөөрдөг түүгээр л явдаг байхгүй юу. Тэр олон улсын стандартынхаа төмөр замыг тавих ёстой байж. Түрүүн түрүүний Засгийн газрууд нь энэ ажлаа хийгээгүй байж. Энэ 6 жил бол та нартай холбоотой шүү. Энэ алдааг засаж болох боломж байлаа. Ман ж манж 6 жил одоо энэ дээр явлаа. Тэгээд ийм болгочихлоо шүү. Тэгээд одоо сая өчигдөр намайг заналхийлж байна. Миний утас руу Орос хэл дээр вайбераар ярьж байна. Тэгээд мессеж явуулж байна. Иван гэдэг хүн, ийм юм болж байна аа. Тэгээд өнөө өглөө ч гэсэн Тагнуулын ерөнхий газар мэдээлэл хийж байх шиг байна. Тэгээд энэ улс орон одоо хэн нь хааш нь зөв явуулаад байгаа юм. Хамгийн одоо адгийн амьтад л эцэст нь эх орончийн цаана орж нуугддаг шүү. Тэгээд энэ бодлогоо зөв болгох энэ юман дээрээ бид нар анхаарч ажилламаар байна аа.

Энэ хувийн хэвшлээ бид нар анхаарах ёстой. Хувийн хэвшил маань дөнгөж бойкоод жигдрэх гээд явж байна аа. Тийм сайн хувийн хэвшил алга байна аа. 2012 онд бол хувийн хэвшил өөрийнхөө мөнгөөрөө төмөр замаа тавьчих байсан. Үүнийг Монгол Улсын Засгийн газрууд зогсоосон. Түүнийхээ лайг өнөөдөр эдэлж байна. Тэгээд өнөөдөр хувийн хэвшил тэндээс буруутай зөрүүтэй хүмүүс байж болно, тэр Хөгжлийн банкаар. Түүнийг очиж хурааж авах биш ээ. Яг хуулийнхаа дагуу шүүхээр нь шийдүүл л дээ. Ийм юм байлгах юм бол энд яаж хувийн хэвшил чинь хөгжих юм бэ. Нөхдүүдээ, та нар бас энэ дээрээ анхаармаар байна аа.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэллээ.

Дэмжихгүйгээр үг хэлнэ гэж байхгүй л дээ. Дэмжихгүй байгаа л байх юм бол.

Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, хоёр. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Санал хураалтад 57 гишүүн оролцож, 43 гишүүн дэмжиж, 75,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрхэм гишүүд ээ, Эдийн засгийн байнгын хорооны гишүүд ээ, нэн ялангуяа одоо ингээд олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг Засгийн газар өргөн барьсныг Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг нь дэмжиж, хэлэлцүүлгийн явцад олон

гишүүд олон чухал саналуудыг гаргалаа. Үүнийг хэлэлцүүлгийн явцад анхаарах хэрэгтэй байна аа. Эдийн засгийн байнгын хороо.

Дэлхийн улс орнууд дайнаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулах, иргэдийнхээ амьжиргааг дэмжих зорилгоор татварын бодлогоо супруулах нийтэд нь супруулах, гол нэрийн хүнсний бараа бүтээгдэхүүнүүдийг одоо үр тариа, ургамлын тос, улаан цагаан будааг экспортыг хязгаарлах, хүнсний гол бүтээгдэхүүний импортыг дэмжих зохицуулалтуудыг хэрэгжүүлж эхэлчихсэн байгаа аль хэдийн. Энэ хуулиар бол бензин шатахуун, мах, гурил З бүтээгдэхүүнийг үнэ өсөх, хомсдол үүсэхээс сэргийлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх зохицуулалтууд тусгасан.

Гишүүдийн гаргасан тэр эм, эмнэлгийн хэрэгсэл байна, бусад гол нэрийн стратегийн хүнсний бүтээгдэхүүнүүд байна. Үүний татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг бас үзэх шаардлагатай гэсэн саналуудыг гишүүд олгон хэлсэн. Үүнийг бас авч үзэх нь зүйтэй.

Тэгээд та бүхний анхаарлыг З асуудалд хандуулахыг хүсэж байна. Нэн ялангуяа Монголбанкны бас мэдээлэл, сайд нарын мэдээлэлд үндэслээд нийгэмд зөв дохио санамж өгөх ёстой. Энэ валютын ханшийн эрсдэлийг бууруулах, нөөцийг нэмэгдүүлэх асуудал байна. Зөв зүй зохистой хүлээлт үүсгэх асуудал байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэх гол арга зам нь бол экспортыг нэмэгдүүлэх явдал. Алт олборлолтыг нэмэгдүүлэх нь их чухал байна. Энэ талаарх зохицуулалт хуулийн төсөлд туссан. Тэгээд одоо зах зээлд мэдээлэхэд Оюу толгой бол 450 сая долларыг Монгол Улсад оруулж энэ 4 сардаа багтааж оруулж ирнэ, 50 хувийг нь зах дээр үнэ хаялцуулж зардаг, 50 хувь нь Монголбанканд зардаг байсан бол одоо бол Монгол банканд 100 хувь зарж валютын нөөцийн зузаатгал хийхээр ярилцаж байна. Үүнийг бол Оюу толгой дэмжинэ гэдэгт итгэж байна. Ингээд 450 сая доллароор зузаатгагдана.

Таван толгой 305 сая долларын оптекийн гэрээ хийж байгаа гэж байгаа үүнийгээ Монголбанканд бас зузаатгалд өгөх хэрэгтэй. Валютын ченж хийгээд байж болохгүй.

Дээр нь бол Эрдэнэтийн 50 мянга гаруй тонн хил дээр гацчихсан байгаа юм байна лээ. Үүнийг гаргах ажил хийхэд 100 сая долларын борлуулалт нэмэгдэнэ. Энэ мэтээр боломжийг дайчлаад арилжааны банкнууд бусад хэлбэрээр своп хэлцэл хийж байгаа зузаатгал хийж байгаа зүйлүүд байна. Ингээд нийтдээ 2 тэрбум доллароор валютын нөөцөө нэмэгдүүлэх бололцоо орж ирж байна аа. Ийм учраас зах зээлд бол тайвшрал үүсгэх ийм дохио санамжийг үүнийгээ энэ 2 тэрбум доллароор оруулж ирж Монголбанкаа зузаатгах ажлыг Засгийн газар, Монголбанк, холбогдох байгууллагууд бас анхаарч дэмжиж зохион байгуул аа. Ингээд 2 тэрбум долларын зузаатгал хийгдэхэд бол энэ ханш тогтворжих биш бүр буурах бололцоотой. Үүний тулд мэдээж хэмнэлтийн горимд шилжигдэж байгаа маань бол импортыг хязгаарлаж, энэ валютын нөөцийг хэмнэх горимд шилжих хэрэгтэй байна гэдгийг хэлж байгаа юм. Ийм учраас дахин би хэмнэлтийн асуудлаар өмнө хэлсэн үгээ давтаж хэлмээр байна. Үүнийг одоо ард түмний бүсийг чангалах гэлээ гэж мушгисан. Үнэндээ бол одоо энэ валютын нөөцөө нэмж, ханшаа тогтвортой байж эдийн засгийн өсөлтийг шинэ сэргэлтийг хангахын тулд шатахуунаас авахуулаад хэмнэлтийн горимд шилжих шаардлагатай. Дэлхий дахин ийм горим хэрэгжүүлж байгаа.

Тэгээд хэмнэлтийг дээрээсээ буюу төрийн байгууллагаас эхлэх ёстай. Эхний ээлжид төрийн байгууллага, бүх шатны байгууллагууд төсвийн зарцуулалтаа дахин хянаж тэвчиж болох бүх зардлуудаа хянах хэрэгтэй. Үндсэндээ тэтгэвэр нэмээд 630 тэрбум төгрөгөөр бол төсвийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардлыг танасан. Энэ бол хэмнэж болох ийм бололцоо байсныг бас харуулж байгаа. Үүнээс ч илүү хэмнэх бололцоо байна. Баяр ёслол одоо элдэв хангай илүү дутуу зардлаа бүгдийг нь тэвчиж хэмнэнэ ээ. Одоо ийм хууль оруулж ирж байгаа юм чинь энэ хэмнэлтэй импортын татвар нэмэгдэнэ шүү дээ.

Дараа нь, дээр нь бол одоо энэ Хяналт шалгалтын түр хороо байгуулах тогтоолын төслийг Batttemer нарын 20 гишүүн санаачилж өргөн барьсан. Хяналт шалгалтын ажил бол анх одоо шинэ шатанд гарч байгаа. Тэгэхээр энэ төсвийн эрх мэдэл тодорхой эрх мэдлүүд өгч байгаа ч гэсэн хяналт шалгалтын ажил, ард нь бол ард түмний хяналтад орчихсон байгаа шүү гэдгийг сануулж, бүх шатны төрийн албан тушаалтнууд, сайд дарга нар онцгой сонор сэрэмжтэй, илүү дутуу зардалгүй авлига албан тушаалтын хэргээс ангид байхыг бас сануулж байна. Ингэж байж бид энэ хүндрэлийг хамтдаа давж туулж чадна аа. Ер нь гадаад өрийн нөхцөл байдлаа хүндрүүлэх зээлжих зэрэглэлийг бууруулах ийм гол эрсдэлүүд чинь энэ одоо авлига, хээл хахууль, улсын хөрөнгөнд хайр гамгүй хандах явдлууд болж байгаа юм аа.

Мөн олон гишүүн хэлээ, тэр хүнсний хомсдол үүсээд 8,3 сая хүн одоо хүнсний хомсдол нүүрлэж болзошгүй энэ тэр гэсэн ийм тоо баримтуудыг сая дурдсан. Тийм учраас хаврын тариалалтаа онцгой анхаар аа. Хаврын тариалалт зөвхөн үр тариа яриад байна. Бордооны чинь асуудал, бордооны асуудал байна. Үр тарианы асуудал байна, Эдийн засгийн байнгын хорооны дарга аа, хүнсний хангамжийн асуудлаа танай Байнгын хороо анхаарна шүү дээ. Зөвхөн дизель тулшний асуудал байна. Үр тариа, бордоо, тэгээд төмс хүнсний ногоо бүх хүнсний ногоогоо тариалах хэрэгтэй байна шүү дээ. Хүлээмжийг нь ногоогоо тариалах хэрэгтэй байна. Ийм их өргөн боломж байж, ингэж байж бид нар энэ ирэх намар, тэгээд 23 оны нөөцөө бүрдүүлнэ шүү дээ. Зөвхөн өнөө, маргаашаа биш, бас энэ жилээ ядаж нэг жилийн дараах хүнсний хомсдолын асуудлаа. Одоо Украина Оросын тариалалт, Казахстаны тариалалтууд бас дэлхийн үр тариа, ургамлын тос, хүнсний хангамжид ямар нөлөөтэй гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Ийм учраас Атрын дөрөвдүгээр аяныг бол онцгой түвшинд зохион байгуулах хэрэгтэй. Монголбанк үүнийг анхаарах хэрэгтэй. Ингээд Монголбанк бол экспортыг дэмжихэд ноолуурын асуудал хэллээ. Манай уул уурхайн бас ганц экспорт чинь самнасан ноолуур шүү дээ. Одоо түүхийгээр нь биш боловсруулаад гаргахад дахиад 1 тэрбум долларын нөөц бүрдүүлэх бололцоо бий. Валютын нөөц. Энэ бүх бололцоонуудаа шавхаж дайчилж ажиллацааяа аа. Энэ асуудлуудыг энэ хуулийг хэлэлцэхдээ анхаарч нэлээн томоор нь одоо анхаарч ажиллах шаардлагатай.

Max 400 сая доллар гэж байна. Тэгэхээр одоо малаа эрүүлжүүлэхээс авахуулаад энэ дээр цогцоор нь хандах хэрэгтэй.

Ингээд эрхэм гишүүд та бүхнийг эдгээр асуудлуудад онцгой анхаарч зөв оновчтой шийдвэр гаргахын төлөө манай Ардчилсан намын гишүүдийн хэлсэн шиг эв нэгдэлтэй, улс орныхоо төлөө нэгдмэл санаа зорилготой хичээн ажиллахыгuriалж байна аа.

Өнөөдөр зургаан цаг өнгөрсөн байна.

Дараагийн асуудал Тагнуулын байгууллагын тухай хууль хэлэлцэх ёстой.

Чуулганы хуралдааныг сунгаж хуралдах уу, маргаашийн хуралдаанаар хэлэлцүүлэх үү.

Одоо хуралдъя гэж байгаа нь гараа өргө дөө.

Байхгүй байгаа учраас. Маргааш Тагнуулын байгууллагын хуулиар эхэлье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ